

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-84
1.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан	6-24
2.Дулааны цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хэрэгжилт, салбарын үнийн өсөлтийн талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох	24-73
3.Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох	73-82
4.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/	83-84

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 06-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 52.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 46 минутад Төрийн ордны “Их Засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: П.Мөнхтулга.

Нэг.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэгч газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Өнөрбаяр, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Үүрийнтуяа, мөн газрын ахлах референт Д.Отгон, ахлах шинжээч Ш.Бумаажав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, референт Д.Энхмаа нар байлцав.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Үүрийнтуяа, Д.Батбаяр, Д.Батлут, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэгч газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Өнөрбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, С.Замира, Г.Очирбат, Д.Үүрийнтуяа, Д.Батлут, С.Ганбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд хууль, Улсын Их Хурлын тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 12 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Дулааны цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хэрэгжилт, салбарын үнийн өсөлтийн талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга И.Лувсанцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, ахлах шинжээч Б.Мөнхчулуун, мөн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч П.Товуудорж, Л.Мягмардаш, Эрчим хүчний зохицуулах хорооны үнэ тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

Дулааны цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хэрэгжилт, салбарын үнийн өсөлтийн талаарх мэдээллийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, Д.Бум-Очир, Д.Энхтуяа, Б.Уянга, Г.Очирбат, Д.Үүрийнтуяа, Г.Лувсанжамц, Б.Пунсалмаа, М.Энхцэцэг, Г.Хосбаяр, Д.Батлут, Д.Жаргалсайхан, Б.Тулга, С.Замира, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч П.Товуудорж, Л.Мягмардаш, мөн хорооны Үнэ, тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Д.Үүрийнтуяа, С.Ганбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Дулааны цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хэрэгжилт, салбарын үнийн өсөлтийн талаарх Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнгийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Зам тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, мөн яамны Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Д.Мөнхбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх

захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Уянга, Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга О.Цэрэндондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Д.Жаргалсайхан, С.Ганбаатар, Ж.Золжаргал, С.Замира нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Тувааны мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Ганбаатар: “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 8

Бүгд: 22

63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Д.Энхтуяа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 22 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 72.7 хувийн Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 36 минут үргэлжилж, 24 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 95.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
11 цаг 46 минут.

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

С.Ганбаатар 1 дүгээр тойрог ирсэн байна. Бадамсүрэн гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна. Бум-Очир гишүүн ирсэн байна. Даваасүрэн гишүүн 4 дүгээр тойрог ирсэн байна. Жангабыл гишүүн 3 дугаар тойрог ирсэн байна. Замира гишүүн ирсэн байна. Лүндэг гишүүн ирсэн байна. Очирбат гишүүн ирсэн байна. Пүрэвдаваа гишүүн ирсэн байна. Буяагийн Тулга гишүүн ирсэн байна 5 дугаар тойрог. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Энхтуяа гишүүн ирсэн байна. Ингээд нийт гишүүдийн 52.2 хувийн ирцтэйгээр өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан. Энийг цаасаар, файлаар та бүхэнд бас өгсөн байгаа. Улсын Их Хурал Байнгын хороод маш их олон хууль, тогтоол үүрэг чиглэл өгөөд байдаг. Хуулийн хэрэгжилтийн хяналт гэдэг бидний бас үндсэн үүрэг байгаа.

Хоёрдугаарт, Дулааны цахилгаан станц/ДЦС/, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хэрэгжилт, салбарын үнийн өсөлтийн талаарх эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох гэсэн ийм хоёрдугаар асуудал байгаа.

Энэ дээр 10 аймгийн бас дампуурчхаад байгаа 10 ДЦС-ын тухай бас яригдах байх.

Гуравт нь Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох.

Дөрөвд нь Байнгын хорооны тогтоолын төсөл, “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” ийм 4 хэлэлцэх асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа баталъя. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудлын нэгд, Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэж эхэлье.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг би та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Одбаяр сайд ирсэн байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч Өнөрбаяр дарга ирсэн байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Үүрийнтуяа дарга ирсэн байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах шинжээч Бумаажав? Бумаажав шинжээч ирсэн байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах референт Отгон ирсэн байна. Албаны хүмүүсээ танилцуулчихлаа.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлангийн танилцуулгыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Эрдэнэбилигийн Одбаяр сайд танилцуулна.

Э.Одбаяр: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрье. Энэ оноос эхлээд Улсын Их Хурлаас үүрэг, чиглэл өгөгдсөн Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын хуулиудтай холбоотой хэрэгжилтийн тайланг Байнгын хороо тус бүрээр нь гаргаж холбогдох Байнгын хорооддоо дэлгэрэнгүй танилцуулга хийдэг болсон байгаа. Засгийн газрын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын өмнө хуулийн хэрэгжилтийг Засгийн газар хариуцах үүрэгтэй байдаг. Энэ үүргийнхээ хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаарх Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг та бүхэнд танилцуулъя.

Энэ дүнг урьдчилаад оршил болгоод хэлэхэд Хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газар дахь хяналтын тухай хууль, Улсын Их Хурал дахь хяналтын тухай хуулийн дагуу Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас үнэлгээг хийсэн. Их Хурлын Тамгын газрын зүгээс дүн шинжилгээ хийсэн байгаа. Тэгээд чиг үүргийн хүрээнд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын зүгээс хийсэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны бодлого шийдвэрүүд Монгол Улсын хууль, тогтоолын талаарх тайланг та бүхэнд дэлгэрэнгүй танилцуулъя.

Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17.1.4 дэх хэсэг, Засгийн газрын 20 оны 206 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 8.5 дахь заалтыг үндэслэн энэ бодлогын баримт бичгүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байгаа. Бүрэн хэрэгжсэн гэдэг дээр 100 хувь хэрэгжээд батлагдсан заалтуудыг, хэрэгжих шатандаа гэдэг дээр 70 хувь, хэрэгжилт хангалтгүй гэсэн дээр 30 хувийн хэрэгжилттэй, хэрэгжээгүй гэдгийг 0 гэдэг үзүүлэлтээр, хэрэгжилтийн хугацаа болоогүй гэдэг бас ангиллаар заалтуудыг ангилсан байгаа.

Энэ үнэлгээнд хамрагдсан заалтууд unelgee.gov.mn гээд байгаа Монгол Улсын 89 хуулийн 481-ийн заалт, Улсын Улсын Их Хурлын 104 тогтоолын 624

заалт, Байнгын хороодын 179 тогтоолын 445, нийт 272 шийдвэрийн 1550 заалт энэ цахим мэдээллийн санд бүртгэлтэй байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд бүртгэлтэй байгаа Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийг үнэлгээний ангиллаар авч үзэхэд 569 буюу 36.7 хувь нь бүрэн хэрэгжсэн. 390 буюу 25.2 хувь нь хэрэгжих шатдаа, 224 буюу 14.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 196 заалт буюу 12.6 хувь нь хэрэгжээгүй гэж дүгнэгдсэн байна.

Харин хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй үндэслэлээр 150 заалтыг үнэлэх боломжгүй байна. Хэрэгжилт нь дунджаар 66.4 хувь байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 3.8 хувиар өссөн гэсэн үзүүлэлт гарсан байна.

Энэ дээр Байнгын хороо тус бүрээр энэ гаргасан тогтоол, шийдвэрүүдийн тоо бүрэн хэрэгжсэн, хэрэгжих шатдаа байгаа, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй гэдэг ангиллуудаар нь бас шийдвэрүүдийг ангилсан байна.

Дараагийн слайд руу орчихъё. Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд бүртгэлтэй байгаа хуулийн 481 заалтын 69 буюу 14.3 хувь нь хэрэгжээгүй, Улсын Их Хурлын тогтоолын нийт 624 заалтын 80 буюу 12 хувь нь хэрэгжээгүй, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын 445 заалтын 44 нь буюу 9.9 хувь нь хэрэгжээгүй бөгөөд хууль Улсын Их Хурлын Байнгын хорооны нийт 1550 заалтын 193 буюу 12.5 хувь нь хэрэгжээгүй гэсэн ийм дүн гарсан байна.

Эндээс Аж үйлдвэржилтийн байнгын хороотой холбоотой шийдвэрүүд гарсан. Нийтдээ 9 шийдвэр гарсан. Дунджаар 50.8 буюу хэрэгжих шатдаа байна гэсэн ийм дүн гарсан байгаа, үнэлгээ гарсан байгаа.

Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр гарсан 10 шийдвэрийн талаарх тогтоолын дэлгэрэнгүйг холбогдох хуулиудын Байнгын хорооны хэрэгжилтийг хангах ёстой заалтуудыг нь хүснэгтээр дэлгэрэнгүй та бүхэнд тараасан байгаа. Тэгээд эндээс асуух асуулт байвал Байнгын хорооны гишүүдийн асуултад хариулъя.

Дүгнэлтийн хувьд төрийн захиргааны байгууллагууд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа харьяа байгууллагуудын тайлан, мэдээллүүдийг нэгтгэн тайлагнахгүй зөвхөн яамныхаа үйл ажиллагааг тайлагнаж байгаа нь бас учир дутагдалтай байна гэж үзэж байгаа.

Хоёрт нь юу гэхээр Улсын Их Хурлын тогтоол болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл болсон зарим шийдвэрийг тухай бүр Хяналт хэрэгжүүлэх газарт ирүүлэхгүй байгаагаас бас тайлагналтад бас асуудал үүсэж байгаа. Холбогдох байгууллагууд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн хэрэгжилтийг тайлагнахдаа өмнөх тайлант үеийн хугацааны биелэлттэй харьцуулан үзэж, хүрсэн үр дүнг тайлагнаагүй, утга, агуулгын хувьд алдаатай тайлагнах, өмнөх оны хэрэгжилтийг хуулбарлан давтан тайлагнасан, өөрийн үнэлгээг бодитой үнэлээгүй гэдэг нийтлэг алдаанууд бас гарсан байна.

Хяналт хэрэгжүүлэх газрын зүгээс дараах саналыг Байнгын хорооны гишүүдэд гаргаж байгаа. Холбогдох хууль тогтоомжоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг сайжруулах. Улсын Их Хурлын тогтоол

болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл болсон шийдвэрийн гарсан тухай бүр шийдвэрийг Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж байхаар холбогдох газарт үүрэг, чиглэл өгч уламжлахыг, Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн чиг үүрэгт хамааралгүй болсон, шийдвэр нь хүчингүй болсон, дахин шийдвэр гарсан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон зэрэг 519 заалтыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сангаас хяналтаас хасуулах үндэслэлтэй гэж дүгнэсэн бөгөөд тэгээд энэ асуудлыг бас шийдвэрлэж өгөхөөр бас уламжилж байгаа юм.

Тайлан, мэдээтэй холбоотой асуулт байвал хариулъя.

С.Ганбаатар: Одбаяр сайдад баярлалаа. Гишүүд мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд саналаа өгнө үү.

Манайхан чинь дараад нь бүгдээрээ асуулт асуух гээд байдаг шүү. Энэ чинь бидний Их Хурлын үйл ажиллагааны хэрэгжилтэд, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих гэж Их Хурлын гишүүний үндсэн 3 тун үүргийн нэг юм байгаа юм шүү дээ. Ингээд Уянга гишүүнээр, Болдын Уянга гишүүнээр, Батлут гишүүнээр тасаллаа. Ингээд Уянга гишүүн асуулт асууна.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Мэдээллийг манай Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр өмнө нь хийгдэж байсан, гарч байсан тогтоолуудын хэрэгжилт дээр хяналт шинжилгээний дүгнэлт орж ирж байгаад талархалтай хүлээж авч байна. Тэгээд ерөнхийдөө гарсан тогтоолуудын шийдвэрүүдийн хэрэгжилт 50.8 хувь гэдэг хангалттай мэдээж биш. Тэгэхээр бүгдээрээ яг яах ёстой юм болоо? Энийг зарим яг хэрэгжээгүй байгаа гэсэн дээр байгаа зүйлүүд хүнсний аюулгүй байдал байна, мал амьтны гаралтай болон ургамал түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эцсийн бүтээгдэхүүн хүртэл цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх гэх мэт энэ ажлууд хийгдээгүй, Хүнс,хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбартай л холбоотой их ажлууд нь хийгдээгүй юм шиг байгаад байх юм. Тэгэхээр бүгдээрээ яг хариулах субъект нь байхгүй болохоор Одбаяр сайдаас яг юу гэж асуухаар юм байгаа юм. Ямартай ч бид нарт тогтоол гарлаа, шийдвэр гарлаа. Хэрэгжүүлэх үүрэг нь яамдад байна. Тэрийгээ биелүүлээгүй тохиолдолд хуулийн танай шалгалт явуулж байгаа хуулийн хүрээнд ямар хариуцлага ер нь үүрүүлдэг вэ? Хуульд эсвэл бид нар нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна уу, яаж сайжруулахаар байна Батбаяр сайд аа? Тэгж л асууя даа. Тэгээд дараа нь бүгдээрээ дотооддоо энэ хийгдээгүй ажлуудын араас явахаар байна уу? Тэрийг ярилцъя.

С.Ганбаатар: 4 дүгээр микрофон дээр хариулт өгье.

Э.Одбаяр: Энэ Байнгын хороо болоод хууль тогтоомжийн биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудлуудын дүн шинжилгээ дээр үндэслээд салбарын сайдын хувьд улс төрийн хариуцлага Ерөнхий сайд бид хоёр дээр ярих байх. Бусад төрийн албан хаагчдын хувьд Төрийн албаны тухай хуулийн дагуу 1 удаа сануулаад, 2 дахь удаадаа сахилгын арга хэмжээ гэдэг юм уу Төрийн албаны холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцогдоод явна.

Гэхдээ энэ дээр яах вэ нэмэлт тайлбар хийхэд ихэнх заалтууд нь хэрэгжилтийн тайлан гарах хугацаа болоогүй заалтууд байгаа учраас бас хэрэгжилтийн хувь нь ингэж арай багаар үнэлэгдэж байгаа. Түүнээс биш яг тийм

ажил нь нурчихсан гэсэн ойлголт биш. Ерөнхийдөө энэ удаагийн энэ жилийн энэ тайлан, мэдээтэй холбоотой зүйлүүдийг ярьж байгаа дээр Байнгын хорооны гишүүддээ бас уриалмаар байгаа юм. Хэдүүлээ энэ салбарын яамнуудын тайлан энэ орж ирж байгаа дээр бас илүү их тийм хуулийн хэрэгжилтийг хангуулах дээр шахаж шаардаж ажиллах тал дээр Их Хурлын гишүүд маань бас илүү бас санаачилгатай ажиллаад сайд нартаа бас шаардлага тавьж ажиллах боломж бас өшөө илүү нээлттэй болж байгаа гэдгийг бас та бүхэндээ бас хэлэх гэсэн юм.

Илүү нэмэлт тайлбарыг кабинет дотроо бас Хөдөө аж ахуйн сайдаас саяын Уянгаа гишүүний асуусан асуулттай холбоотой хэрэгжилт хангалтгүй байгаа зүйлүүд дээр бас тайлбар мэдээлэл авч ажиллана.

С.Ганбаатар: Ингээд Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Одбаяр сайдаас надад тодорхой 2, 3 асуулт байна. Нэгдүгээрт нь танилцуулгаас ингээд харахад хуулийн нийт 69 заалт гээд байгаа юм. 481-ийн заалтын 69 буюу 14.3 хувь нь огт хэрэгжээгүй байна гэж. Энд хэчнээн, ямар төрлийн хэдэн хууль байгаа вэ? Хавсралтыг харахаар ерөөсөө ганц хууль л харагдаад байна. Хавсралт нь бас 13, 14 гээд дугаарлаад эхэлчихсэн. 11-ээс эхлээд дугаарлачихсан ямар учиртай юм? Хэдэн хуулийн 481 заалтаас хэчнээн хуулийн 69 нь огт хэрэгжихгүй байгаа юм бэ? Та бүхний танилцуулга дээр байгаа Монгол Улсын хууль гэдэг дотор байгаа 33 шийдвэр гэдэг юу вэ? Хуулийн дотор байгаа шийдвэр юу вэ? Эхний асуулт.

Хоёр дахь нь Аж үйлдвэржилтийн байнгын хорооны гаргасан 9 шийдвэрийн хэрэгжилт дунджаар 50.8 хувьтай буюу хэрэгжих шатад байна гэж байна. 9 шийдвэрээс бүрэн хэрэгжсэн 100 хувь хэрэгжсэн нь хэд юм бэ? Хэрэгжих шатдаа байгаа нь хэд юм бэ? Огт хэрэгжээгүй нь хэд юм бэ? Энийг 9 юм чинь, 9-хөн асуудлыг хуваагаад танилцуулаад өгөөч.

Үр дүнтэй танилцлаа. Улсын Их Хурлын баталж гаргаж байгаа, Улсын Их Хурлаас баталж гаргаж байгаа хууль, Улсын Их Хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна гэж. Улсын Их Хурлын Тамгын газраас мөн энэ дүн шинжилгээ хийж санал, дүгнэлтээ ирүүлсэн байна. Энэ дээр мөн Засгийн газрын энэ хяналт шинжилгээ, үнэлгээтэй аргачлал энэ тэр зөрж байгаа асуудлууд байгаа юм байна. Энэ асуудлуудыг хэрхэн яаж цэгцлэхээр шийдэж байна? Нэгдүгээрт .

Хоёрдугаарт ингээд дүн гарлаа, хангалтгүй байна гээд гарчихлаа. Ард нь яах ёстой вэ, яг ямар бодитой саналыг та бүхэнд танилцуулах гэж байгаа юм бэ? Ямар арга хэмжээ авах гэж байгаа юм бэ? Ямар ажлыг араас нь хийх гэж байгаа юм бэ гэдэг юмаа хэлээч.

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүний асуултад Одбаяр сайд хариулъя. 4 номерын микрофонд.

Э.Одбаяр: Эрхэм гишүүний асуултад хариулъя. Хоёр дахь асуулт нь асуултаас нь эхлээд хариулах нь зөв байх. Тэр Их Хурлын тамгын газрын дүгнэлттэй зөрж байгаа тухай асуудал дээр Улсын Их Хурлын Тамгын газрын зүгээс Улсын Их Хурлын даргаар аргачлалаа журмаа батлуулах ёстой. Тэгээд тэр ажлаа хийгээд явахаар энэ ойлголтын зөрөөнд гарах байх. Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн дагуу бид нар цахим системд ирүүлсэн салбарын

яамнуудын тайланд үндэслэж энэ хяналт шинжилгээ, үнэлгээг хийж байгаа. Тэгэхээр зарим тохиолдолд энэ аргачлал зөрж байгаа учраас тоонууд зөрөгдөх асуудал гарна

Нэг дэх асуудлын хувьд Байнгын хороотой холбоотой, бусад хууль тогтоомжтой холбоотой дэлгэрэнгүй тайланг Өнөрбаяр дарга танилцуулна.

С.Ганбаатар: 5 дугаар микрофонд нээж өгье.

Ч.Өнөрбаяр: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Яах вэ үнэлгээтэй холбоотой бас асуудал гараад байгаа нь нэгдүгээрт 20 оны үнэлдэг журмаар бол Засгийн газраар бол зөвхөн арга хэмжээг үнэлдэг тэгээд энэнээсээ болоод үр дүн гараагүй зүйлийг үр ашгийг үнэлж чадахгүй явж ирсэн. Энийг бол Хяналт хэрэгжүүлэх газар Одбаяр сайдын зүгээс өөрчлөх ёстой гээд 3 цогц журмыг Засгийн газрын хуралдаанаар батлуулаад одоо энэ оны 5 сарын 1-нээс эхлээд мөрдөгдөөд явж байгаа. Тэгээд ирэх жил бол бид нар энэ 3 журмын дагуу үнэлэхээр таны асуугаад байгаа зөвхөн арга хэмжээ үнэлдэг биш тодорхой хэмжээний үр дүнг үнэлдэг юм руу орох болохоор ахиц, дэвшил гарна гэж харж байгаа. Энэ үнэлж байгаа журам маань бас хүндрэлтэй, болохгүй зүйлүүд байсан гэдгийг хэлье.

9 шийдвэрийн хувьд бол тэр хавсралт дээр та бүхэнд тараасан хавсралт дээр байж байгаа. Ер нь бол 21 оноос 23 оны хооронд гарсан нийт шийдвэрүүдийн хэрэгжилтийг бол.../минут дуусав./

С.Ганбаатар: 5 дугаар микрофоныг гүйцээж хариулах боломж өгье.

Ч.Өнөрбаяр: Хувиар нь ингээд гаргасан байж байгаа. Тэгээд жишээлбэл 21 оны 02 дугаар тогтоол бол 67.5 хувьтай байж байхад 23 оны 06 дугаар тогтоол бол 42.5 хувьтай гээд. Ингээд нийт 9 шийдвэрийг дунджаар гаргахад 50.8 хувийн хэрэгжилттэй байж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хэрэгжих шатандаа байж байгаа.

Хуулиуд дээр ганц нэгхэн хууль биш. Мэдээжийн хэрэг Байнгын хорооноос чиглэл өгсөн маш чухал хуулиуд байгаа. Энэ дээр ялангуяа Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулга гээд энэ хуулийн төсөл бол хийгдээд явж байгаа. Бас хэрэгжилтийнх нь шатан дээр 30 хувьтай. Мөн Хууль батлагдсантай холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу дагаж орох маш олон шийдвэр тогтоолууд гарна. Энэ нь бас энд бас үнэлгээндээ ордог. Мөн Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай гээд энэ тоо холбоотой Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийг дэмжих хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, энэ мөн Хүнс, хөдөө аж ахуйн яам хариуцаж байгаа Хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүнийг түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг.../минут дуусав./

С.Ганбаатар: Ингээд Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Би тодорхой асуулт л асуугаад байгаа юм. Яг энэ 69 заалт чинь хэдэн хуулийнх юм бэ? Надад тэр хуулийн энэ дээр биччихсэн зүйлээ тэр дахиж яриад хэрэггүй л дээ. Нэгдүгээрт хуулийн асуулт эхний асуулт.

Хоёр дахь асуулт Аж үйлдвэржилтийн байнгын хорооны 9 тогтоол дотор чинь би арын хавсралтыг хараад л байна л даа. Огт хэрэгжээгүй хэд байгаа юм бэ гээд би асуугаад байгаа шүү дээ. Та хэд дундаж гээд тоо гаргаж ирээд хэлээдэх байх юм. Гэтэл энэ дотор чинь огт хэрэгжээгүй тогтоол бас харагдаад байна шүү дээ. Тэгэхээр огт хэрэгжээгүй нь хэд юм, хэрэгжих шатандаа явж байгаа нь хэд юм, хэрэгжсэн нь хэд юм гэдэг тоог нь гаргаад өг л дөө.

Дараагийн асуулт дараа нь яах юм бэ? Ямар арга хэмжээ авах гэж байгаа юм бэ? Юу хийх гэж байгаа юм бэ? Тодорхой хариулт авмаар байна.

С.Ганбаатар: Хариултыг 5 номерын микрофон дээр хариулт хэлье.

Ч.Өнөрбаяр: 22 хууль байгаа. Эндээс бол огт хэрэгжээгүй 1 заалт байгаа. Тэгээд тэр нь 22 оны 010 дугаар тогтоолын хэрэгжилт огт байхгүй байгаа. Энэ дээр мэдээж хэрэг түрүүн бас сайд хэлсэн Засгийн газрын гишүүнд хариуцлага тооцох асуудал Ерөнхий сайдын түвшинд ярьдаг, улс төрийн хариуцлага тооцохыг ярьдаг. Хэрвээ төрийн албан хаагч тэр тайлан, мэдээ гаргаж албан тушаалтнуудтай холбоотой байх юм бол Төрийн албаны тухай хууль руу дагуу чөлөөлөх хэмжээнд хүртэл хариуцлага ирнэ. Дээрээс нь түрүүн бас жил болгон Хяналт хэрэгжүүлэх газраас яамдын ажлыг үнэлж дүгнэж, тайланг дүгнэдэг. Үүгээр бол 2 жил дараалан хамгийн сүүлийн байр эзэлсэн яамны холбогдох албан тушаалтнуудтай бас хариуцлага тооцдогоо хуулийн дагуу. Баярлалаа.

С.Ганбаатар: Ер нь Монгол оронд ч ер нь хууль тогтоомж шийдвэр өтчихсөн байгаа шүү дээ. Ганцхан хэрэгждэггүй байгаа. Тэгээд яагаад хэрэгждэггүй вэ гэвэл хариуцлага тооцдоггүй. Хариуцлага тооцуулах гэж л өнөөдөр энэ яам байгаа. Харин ч гэж харин энэ яам ёстой нүдээ олсон бас ажлаа хийж байгаа. Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороо дэмжиж ажиллана. Ерөнхий сайд хэрвээ ухаантай хүн байгаа бол, ухаантай гэж итгэж байна. Ухаантай хүн байгаа бол энэ улс төрчдийнхөө, улс төрийн албан тушаалтнууддаа хариуцлага тооцож чадахгүйгээс болж хамаг галыг өөр дээрээ авч байгаа энэ тэнэглэлээ зогсооё гэвэл энэ яамтайгаа их ойрхон ажиллах ёстой. Гишүүдтэй та нар их ойрхон хүндэтгэлтэй хандаж ажиллаж байж ажил чинь урагшаа явна гэж би итгэж байгаа. Та нарт, энэ бол их бидний хамгийн дэмжиж, хамтарч ажиллах ёстой, хуулийн хэрэгжилтийг хангуулах яам гэж би ойлгож байгаа.

Ингээд Далайн Батбаяр гишүүн асуулт асууна.

Д.Батбаяр: Байнгын хорооны гишүүд болон ажлын хэсгийнх нь энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр өнөөдөр зөвхөн Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоолууд Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолууд дээр хийгдсэн дүн шинжилгээний асуудал яригдаж байна. Тэгэхдээ би арай өөр асуулт асууя гэж бодож байна. Орон нутаг дээр та бүхэн маань өнгөрсөн хугацаанд ямар нэгэн дүн шинжилгээ хийв үү, яг аль аймгууд дээр ямар шинжилгээ, ямар хяналт хийв, ямар үр дүн гарсан бэ? Энэ үр дүнтэй холбоотойгоор ямар арга хэмжээ авсан бэ гэдэг ийм асуулт байна.

С.Ганбаатар: Одбаяр сайд 4 номерын микрофонд хариулъя.

Э.Одбаяр: Далайн Батбаяр гишүүний асуултад хариулъя. Хуулиараа 24 оны жилийн эцсийн нутгийн өөрөө удирдах, аймгийн Засаг дарга нарын Ерөнхий сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтэд бас хяналт шинжилгээ,

үнэлгээ хийж, ажлын үр дүнг нэгтгэж гаргаж байгаа. Үүнээс гадна тодорхой тохиолдлууд дээр иргэдээс, олон нийтээс ирсэн өргөдлийн дагуу бас газар дээрх хяналт шалгалтын ажлыг хийж ажиллаж байгаа. Өнгөрсөн хугацаанд 7-8 аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийж, Төрийн албаны тухай хууль болоод бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн биелүүлж байгаа талаарх ажлууд дээр нь дүгнэлт хийгээд явж байгаа. Тухай бүрдээ хуулийн дагуу газар дээр нь шийдвэрлэж болох заалтуудаа, асуудлуудаа шийдээд хуулийн зөрчил үүссэн байна гээд гэдэг урьдчилсан байдлаар нөхцөл байдал үүсэх юм бол хуулийн байгууллагууд руу шилжүүлэх, нутгийн өөрөө удирдах байгууллага нь буюу иргэдийн хурал руу нь асуудлыг шийдвэрлүүлэхээр уламжлуулах гэх мэт хуульд заагдсан арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлж ажиллаж байгаа.

24 оны жилийн эцсийн байдлаарх Ерөнхий сайд болоод аймаг, дүүргийн, аймаг, НЗД-ын хооронд хийсэн гэрээний дүгнэлтийг бас тун ойрын үед хийж дуусаад холбогдох мэдээллүүдээ та бүхэнд бас хүргүүлнэ.

С.Ганбаатар: Далайн Батбаяр гишүүн тодруулж асууя.

Д.Батбаяр: Баярлалаа сайд. Танд ахиад цаана нь 2 минут 30 секундийн хангалттай хугацаа байгаа байхгүй юу. Тэгэхээр та тодорхой ахиад дэлгэрэнгүй тайлбарлаад өгөх боломжтой. Бид нар нэгэнт ингээд энэ үйл ажиллагааны хэрэгжилттэй холбоотой танилцуулга явж байгаа учраас ахиад жоохон дэлгэрэнгүй л тайлбарла. Яг аль аль аль аймгууд дээр ямар ямар шалгалтуудыг хийв? Харин дэлгэрэнгүй хэлээд өгчхөөч.

С.Ганбаатар: Одбаяр сайд 4 номерын микрофонд хариулт өгье.

Э.Одбаяр: Ёс зүйн хувьд гэдэг юм уу зарим асуудлууд нь шалгалтын ажлууд нь дуусаагүй байгаа. Тэрийг яг энэ энэ ажил дээр хийгдээд яваад байгаа гэдгийг нь ярих нь дэлгэрэнгүй деталь ярих нь бас төвөгтэй байх. Яг хяналт шалгалтын ажил хийгдээд тайлан, мэдээ нь гарчихсан ажлуудын талаарх мэдээллүүдийг дэлгэрэнгүйг нь Өнөрбаяр дарга тайлбар хэлэх нь зөв байх.

С.Ганбаатар: 5 номерын микрофонд хариулт өгье.

Ч.Өнөрбаяр: Гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нар биш ээ, Засаг дарга нарын үйл ажиллагааг үнэлж дүгнэж ажиллавал 5 сардаа хийгдэж дуусдаг. Засгийн газраар орно. Энэ болтол бол бид нар бас нарийн мэдээлэл өгөх боломжгүй байгаа. Иргэдийн өргөдөл, гомдолтой холбоотойгоор аймаг, нийслэлийн ЗДТГ түүний албан тушаалтнуудтай холбоотой үйл ажиллагааг бид нар холбогдох хуулийн дагуу шалгаад хүргүүлсэн. Гэхдээ нэгдсэн тайланг хуулийн дагуу жилдээ багтаж Улсын Их Хуралд танилцуулдаг. Тэгээд сайд бид хэд ярьж байгаад намрын чуулганд танилцуулах ийм чиглэлтэй байгаа. Энэ дээр бол ерөнхий иргэдийн өргөдөл, гомдолтой холбоотой хяналт шалгалтын нэгдсэн ерөнхий тайлан бол Улсын Их Хуралд бас хүргүүлэх байх. Тэгээд тэр үед бас зарим асуудлууд дээр тодорхой хариултуудыг өгөх боломжтой гэж харж байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Дамбын Батлут гишүүн асуулт асууя.

Д.Батлут: Өдрийн мэнд хүргэе. Энэ тайланг нь уншихлаар ерөөсөө яг юу гэж асуухаа бас ойлгохгүй болчихоод байна. Мэдээллүүд нь дутуу байгаа учраас. Нэг ёсондоо хагас жилээр хийгдэж байгаа ажлуудын үр дүнгүүд бүрэн гүйцэд тодорхойлогдоогүй байна гэж харж байгаа. Түүнээс гарсан үр дүнгүүдийг тооцож хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломжгүй байна гэж харж байна. Сайд ч өөрөө яг тиймэрхүү тайлбар хэлж байх шиг байна.

Тэгэхдээ энэ тайлан дотроос ганц 2 зүйлийг тодруулж асуумаар байгаа юм. Ер нь ингээд бид бүхэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд энэ хууль тогтоомж тогтоолын хэрэгжилтийг хангахад ямар хүчин зүйл нөлөөлөөд байгаа юм болоо гэдэг дээр та бүхэн ямар онол, дүгнэлт хийж байгаа юм бэ? Дээрээс нь хууль, тогтоол биелэгдэх ёстой. Тэгэхдээ энэ гарсан хууль, тогтоол нь өөрөө амьдралд хэрэгжих нөхцөл байдал бүрэн хангаж чадаж байгаа юу үгүй юу? Үүн дээр зөрчилтэй зүйлүүд гардаг уу, үгүй юу гэдэг тал дээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж гаргадаг уу та хэд? Нэг ёсондоо чи нийцэж байх ёстой шүү дээ бүх зүйл. Энэ бүх зүйлийг бид нар нэг тийм голдирол, шугамд оруулж өгөхгүй болохлоор ингээд нэг талд нь төлөвлөлт нь нэг өөр, тайлагналт нь нэг өөр, дүгнэлт нь нэг өөр. Тэгээд тэс тэс өөр юмнууд ярьцгаагаад ингээд зогсоод байгаа юм шиг санагдаад байгаа юм л даа. Энэ дээр хариулт өгөөч.

Гуравдугаарт нь энэ Хөдөө аж ахуйн яамтай холбоотой асуудал байна. Өнөөдөр ингээд 5 сар гарчихсан байна. Ямааны ноолуур бараг самнаад дуусаж байна. Ноос ингээд удахгүй хонио ноослох байх. Тэгээд сарлагийн хөөвөр энэ тэр гээд бүх зүйл ингээд боловсрогдоод эхэлж байна л даа. Самнаад дуусаж байгаа. Гэтэл тэдэнд өгөх урамшууллынх нь журам батлагдаагүй явж байна гэдгийг би юу гэж ойлгох юм бол? Аль уже батлагдаад ингээд үйл ажиллагаа нь явчихсан одоо ингээд хэрэгжиж байх ёстой зүйл шүү дээ. Нөгөө үндэсний үйлдвэрлэх компаниуд маань тэр түүхий эдийг аваад, тэр журмынх нь дагуу аваад, дээрээс нь малчдад нэмэгдэл урамшууллаа аваад тэгээд боловсруулалтаа хийгээд эхэлчихсэн байх ёстой шүү дээ. Тэгсэн чинь тийм зүйл байхгүй байна. Энийг бид юу гэж ойлгох вэ, яаж хариуцлага тооцох юм?

Гуравдугаарт нь ноосны үйлдвэрлэл гэнэ. Ноосны урамшуулалтай холбоотой асуудал байх шиг байна. Бас зээл өгч байгаатай холбоотой, бэлтгэлтэй холбоотой асуудал байна. 23 оны эцэст тайлагнал хийгээд 24 онд хийсэн ажил нь байхгүй. Энэ Хөдөө аж ахуйн сайд чинь Дархан нүүсэн биш бүр хөдөө аж ахуйн салбараасаа тасраад явчихсан юм биш үү? Энийг юу гэж ойлгох юм? Ямар ч тайлагнал байхгүй байна гээд. Ингээд бид нар ингээд бодоод үзэх юм бол энэ дотор чинь ч дотор ч гэсэн асуудлууд байна. Одоо Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль энд тайлагнаагүй байгаа гээд байгаа. Гэтэл Үндсэн хуулийн зөрчилтэй болчихоод байгаа шүү дээ наадах чинь. Би ажлын хэсгийг нь ахалж байгаа юм. Өнөөдөр хурал хуралдана. Засгийн газар өнөөдөр яг энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль 6 сарын 1-нээс хэрэгжихэд хийж хэрэгжүүлсэн ажил байгаа юм уу? Та тэн дээр.../минут дуусав./

С.Ганбаатар: Дамбын Батлут гишүүн маш тодорхой маш ажил хэрэгч асуулт асуулаа. Ингээд Одбаяр сайд 4 номерын микрофонд хариулт өгье.

Э.Одбаяр: Эрхэм гишүүний асуултад хариулъя. Тайлагналтай холбоотой асуудлуудыг тулгамдсан асуудал болчихоод байгаа. Тэгээд энэ дээр Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс. Тийм учраас яах вэ гэхээр Улсын Их Хурлаас баталж байгаа бүх аливаа тогтоол шийдвэр, Улсын Их Хурлын хууль,

Улсын Их Хурлаас баталсан хууль болоод тогтоол шийдвэр бүх шийдвэрийн биелэлтийг Засгийн газар Их Хурлын өмнө хариуцах ёстой.

Гэхдээ энэ дээр тайлагналтын хувьд яах вэ гэхээр яг энэ чиг үүргийнхээ дагуу Засгийн газрын харьяа байгууллагуудын хэмжээн дэх тайланг нэгтгэж оруулж ирж байгаа. Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны төв байгууллага яам, агентлагийн хэмжээн дэх. Энэ дээр бид нар Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгүүдтэйгээ бид нар хамтарч ажиллаад Лувсанжамц гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг, Анар гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг, Энхтүвшин гишүүнээр ажил ахлуулсан ажлын хэсгүүдтэй хамтарч ажиллаад ер нь энэ төлөвлөлт, тайлагналт, хяналтын цогц системийг нэвтрүүлэх ажлын 80-90 хувь нь Улсын Их Хурал дээрх хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, ахиж өргөн барих энэ ажлууд хийгдэх юм байна. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүдтэйгээ энэ чиглэлээр бас хамтарч ажиллаад төлөвлөлт, тайлагналтын цогц систем буюу Ди Эм И гээд байгаа юм. Энэ системийг төрийн бүх байгууллагууд Улсын Их Хурлын харьяа байгууллагууд Засгийн газар дотооддоо нэвтрүүлнэ.

Өөрөөр хэлбэл, төлөвлөгөөнд тусгагдаагүй зүйл дээр төсөв тавихгүй эргээд энэ ажлын гүйцэтгэлийг тайлагнахдаа нэгдсэн журмаар тайлагналыг нь авч хэрэгжүүлж, нэгдсэн дүн гаргаад энэ тайлангийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу түрүүн Үүрийнтуяа гишүүний асуусан асуулт дээр гарч байсан ямар хариуцлага тооцох гээд байгаа юм бэ гэдэг асуудлыг ингээд А-Я хүртэл нь нэгдсэн системтэй болъё гэдэг энэ зорилт тавиад ажиллаж байгаа. Тэгээд энэ дээрээ Засгийн газарт энэ чиг үүрэг нь харьяаллын дагуу энэ Хяналт хэрэгжүүлэх газар дээр хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. Тэгээд энэ Их Хурлын саяын 3 ажлын хэсэгтэйгээ хамтраад энэ ондоо багтаагаад бид нар Улсын Их Хурал руу нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах энэ хууль тогтоомжийн төслүүдийнхээ төслүүдийг оруулж ирээд тэр үед та бүхэнд бас дэлгэрэнгүй мэдээлэл өгнө гэдгээ бас хэлье.

Ноолууртай холбоотой асуудал дээр миний санаж байгаагаар 2 долоо хоногийн өмнөх Засгийн газрын хуралдаан дээр тэр малчдын урамшууллыг шийдэх, санхүүгийн эх үүсвэрийг Хөдөө аж ахуйн сайдыг шийдэхэд зориулж виксель гаргахад Монголбанктай хамтарч ажиллах нь зүйтэй гэдэг шийдвэрүүд гарсан гэж ойлгож байгаа. Тэгээд цаг хугацааны хувьд бас хугацаа алдаж байгаа. Зүүн аймгуудаас эхлээд ноолуурын гаралт, самналтын ажил ид өрнөж байхад энэ салбарын яамнаас хэрэгжүүлж байгаа бодлого нь бас зөв үү, буруу юу гэдэг дээрээ бас мэтгэлцээнд хэт их өрнөсний улмаас хугацаа алдаж байгаа зүйл байгаа гэдэг дээр бас тантай бас санал нэг байна. Салбар нь яам нь нүүсэнтэй холбоотойгоор шийдвэр нь буруу зөвдөж байгаа эсэх талаарх шийдвэр дээр би дүгнэлт хэлэх нь бас илүүц байх гэж бодож байна.

Ноос бэлтгэлтэй холбоотой асуудал дээр ерөнхийдөө энэ боловсруулах үйлдвэрийг ерөнхийдөө хангайн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар гишүүний бас яриад байдаг юм нь ноос хог болоод байна. Хэдүүлээ ноос боловсруулах ноосон бордооны үйлдвэр барья гэдэг юм уу иймэрхүү санал санаачилгууд явж байсан. Энэтэй бас энэ Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр орж ирснийх бас та бүхэндээ бас юу гэдэг юм энэ чиглэлийн баяжуулах бөгөөд боловсруулах үйлдвэрүүдээ.../минут дуусав./

С.Ганбаатар: Одбаяр сайд нэмж хариулъя.

Э.Одбаяр: Малын гаралтай түүхий эдийг үнэгүйдэхээс сэргийлэх, баяжуулах, боловсруулах үйлдвэр, хөнгөн үйлдвэрүүдийг бас бодлогоор дэмжиж өгөхийг бас Байнгын хороодын гишүүдээсээ бас хүсэж байгаа юм. Тэгээд бидний хувьд ч гэсэн, Засгийн газрын хувьд ч гэсэн энэ бүсүүдийнхээ кластерт тохируулаад ялангуяа энэ хангайн бүс дээр энэ мал аж ахуйн бог мал их байдаг аймгууд дээр тулгуурлаад энэ ноос боловсруулах, баяжуулах бордооны үйлдвэрүүдийг барьж байгуулахаар ирэх орнуудын төлөвлөгөөнүүдэд суулгаад ажиллаж байгаа гэж ойлгож байгаа салбарын яамны зүгээс.

С.Ганбаатар: Дамбын Батлут гишүүн асуултдаа 4 номерын микрофонд нэмж хариулт өгье. 2 удаа өгөх ёстой шүү хуулиараа.

Э.Одбаяр: Хот, тосгоны тухай хуулийн бэлтгэл ажилтай холбоотой асуудлыг чиг үүргээрээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын асуудал Учрал сайдаас би бас тодорхой нэмэлт мэдээлэл аваад танд уламжилъя.

С.Ганбаатар: Батлут гишүүн нэмж асуух гэж байна уу? Тодруулж Дамбын Батлут гишүүн тодруулж асуулт асууя.

Д.Батлут: Ингээд бас төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтаа нэг формат дээр гаргаж ирж хянах гэж бас ажиллаж байгаа нь сайн байна. Ингэхгүй бас яг үнэндээ зөрүү, хазгай юмнууд маш их явдаг. Гэхдээ энэ дээр цаг хугацааны хувьд яг шууд үнэлэлт дүгнэх олон ажлууд дээр тухайлах юм бол Хөдөө аж ахуйн яамны хийж хэрэгжүүлэх ажлууд ор тас байхгүйд гайхаж байна. Цаг хугацааны хувьд болчихсон шүү дээ энэ чинь. Бүр тэгээд энэ дээр ямар арга хэмжээ авдаг юм бол? Энийг эрчимжүүлэх талаар бас Хяналтын сайд нь ч байна. Байнгын хорооноос ч гэсэн чиглэл гаргаж үүрэгжүүлмээр байгаа юм. Ингэхгүй бол дотоодын үйлдвэрлэл маань яах юм, малчид маань хэрхэх юм, ченжүүд ноосоо ноолуураа өгөх юм уу, яах юм гээд бүх зүйл нь тодорхой биш байна шүү дээ. Санхүүгийн эх үүсвэр нь юу болж байгаа юм гээд. Тэгээд энэ асуудал дээр онцгой анхаарал хандуулахгүй бол энэ жилийн хувьд малчид маань орлогогүй, үндэсний үйлдвэрлэлүүд маань бүтээгдэхүүн, түүхий эдгүй болоод хувирчих вий дээ гэдгийг бас анхаармаар байгаа юм.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль дээр анхаарлаа хандуулахаас өөр арга байхгүй Үндсэн хуулийн зөрчилтэй холбоотой.

С.Ганбаатар: Ингээд Батлут гишүүн санал байлаа шүү. Сая ойлголоо. Нийт гишүүдийнхээ анхааралд хэлэхэд энэ өнөөдрийн энэхүү оруулж ирж байгаа хууль тогтоомж үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн талаар Хяналт үнэлгээний Үндэсний хороотойгоо бид ингэж уулзаж байгаа нь энэ Хяналт үнэлгээний Үндэсний хороогоо бид дэмжье л гэж байгаа юм. Одоо энэ бол бас анхны ажил. Урьд нь мэргэжлийн хяналтын байгууллагууд байсан. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар гээд янз бүрийн зохион байгуулалтад орж байсан. Голчлон компани, голчлон аж ахуйн нэгжүүдийг иргэдийг л хууль хэрэгжүүлж байна уу, үгүй юу гэдэг дээр л хяналт тавиад л алх цохиод байдаг байсан. Өнөөдөр энэ дээр бас стратегийн гэдэг юм уу, сэтгэл зүйн өөрчлөлт, хандлага гарч байгаа шүү. Юу гэвэл та нар хууль хамгийн их хэрэгжүүлдэггүй улсууд чинь хууль тогтоож батлаад байгаа энэ сайд дарга нар болчихоод байгаа шүү дээ. Шийдвэр гаргагч нар хүний эрхийг хамгийн их зөрчдөг гэж олон улсын конвенц дээр нь ч байна. Тэгэхлээр энэ Үндэсний хороогоо бид дэмжиж ажиллана.

Өнөөдрийн уулзалтын туйлын зорилго явж явж байгаад яг энэ янзаараа явж байгаад л 25 оныг дуусгаад л хэдүүлээ 1 сард хуралдана, ер нь 25 ондоо юу болчхов гээд хуралдана. Одоо чинь ам тагладаг юм нь ой хугацаа дуусаагүй байна гэж байгаад л сүүлийн секундэд би гол үгээ хэлэх гээд байна гэдэгтэй л адилхан үг хэлэх гээд байна шүү дээ цаадуул чинь. Тэгж байгаад энэ янзаараа явж байгаад 1 сард гарвал бүх сайд нарыг ажлаас нь огцруулах, улс төрийн арга хэмжээ авах тийм шаардлага л гарна шүү. Тийм шаардлага гарахгүйн тулд явцын шалгалтыг хэдүүлээ ингээд хамтдаа хийе гэдэг нь өнөөдрийн хурлын туйлын зорилго.

Миний тодруулж асуух хэдэн зүйл байна. Энэ хяналт Монгол оронд энэ улс төрийн нөхцөл байдалд Засгийн газарт ялангуяа хяналт, хариуцлага 2 дутаж байгаа. Тэр дотор Улсын Их Хурлын хамгийн 3 том ажлын нэг. Ард түмэнд мэдээлэл өгөх, хууль тогтоох, хуулийн хэрэгжилтийг хянах гэдэг энэ 3 дугаар ажлаа энэ 30 жил Улсын Их Хурал хаясан. Зүгээр л хууль үйлдвэрлээд л байна. Тэр хэрэгжинэ үү, байна уу хууль өөрөө хөл гар ургаад хэрэгжинэ гэж байхгүй шүү дээ. Араас нь хяналт дээр нь шалгалт тавьдаг Их Хурлын гишүүд ч байдаггүй, тийм бүтэц ч байхгүй. Тэгэхлээр Одбаяр сайд танай хамт олонд бид дэмжинэ, хамтарч ажиллана. Энэ дээр ард түмний нурууг амраах хэрэгтэй байгаа.

Асуулт бол энэ хамгийн эхний асуулт асууя. Энэ Байнгын хороон дээр энэ яамнууд манай гол хамтарч ажилладаг яамнууд Эрдэс баялаг, Хөдөө аж ахуйн яам өөр ухаантай ухаантай яамнууд манайд их л дээ. Тэднүүс орж ирээд л асуулт асуухлаар булзааруулна, үнэн, зөв хариулахгүй, бичгээр өгнө өө, дараа хариулъя гэж энэ одоо ард түмний мэдэх эрх болон хууль хэрэгжилтэд шууд хяналт одоо ингээд гай болж байгаа хуулийн. Энэ дээр би ямар хариуцлага тооцох вэ? Би 2 удаа Цэцэд өгсөн сайдыг нь огцруулъя гээд. Энэ чинь өөр механизм байна уу? Та нарт хандах механизм бий юү? Энэ дээр энэ Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны хувьд та нар надад хариулт өгөөч. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ дотор асуух юм их байна. Энэ хэрэгжээгүй 0 гэсэн хэрэгжилттэй бүүр бүхэл бүтэн листүүд явж байгаа. Замынхаа дунд бид орж байгаа шүү дээ. 5 сар гарчихсан шүү дээ одоо. Тэгээд чинь ийм пээдгэр ийм биеэ тоосон сайд нартай, яам нартай, агентлагтай байх хэрэг байна уу, үгүй юү? Та нар ямар хариуцлага тооцох вэ? Би энэ дээр нэр дурдаад ярих хөөх энэ чинь одоо тэгээд л сайд нар нь уйлаад давхичих байх даа. Аймшигтай байна шүү дээ энэ чинь бүгд эрээн мяраан. Юу ч хэрэгжээгүй байна. 14 мега төсөл гээд л мандан бадруулаад л байсан одоо чимээгүй болсон. 10 их наяд гэдэг шиг алга болж байна. Одоо ингээд л чимээгүй болж эхэлж байгаа. Ингэж үе үе пропаганда хийж ард түмнийг хуурах хэрэг байдаг юм уу? Энэ дээр энэ 0 хэрэгжилттэй байгаа улсууд дээр замын дунд орчихсон байхад ингээд таг 0 байна. Эсвэл эд нар ингэж байгаад л 12 сард гэнэт ажил нь явах гээд байгаа юм уу? Яг ямар хариуцлага тооцох вэ? Би Цэцэд өгөх үү, яах вэ гэдэг дээр надад хариулт өгөөч. Би үнэхээр одоо манай яг Байнгын хороон дээр 9 тогтоолын 50 заалт огт хэрэгжээгүй гээд бүгдээрээ ороод ирсэн бүүр манай Байнгын хорооны.

Миний гурав дахь асуулт. Ард түмэн даяараа газрын тосных гээд л яриад байгаа. Намайг чинь газрын тосны эсрэг юм шиг биднийг ойлгоод байна. Үгүй шүү дээ наад газрын тосны үйлдвэрийн газрын төсөл чинь дампуурчихсан, дампуурах нь баталгаатай болчихсон, ерөөсөө ард түмэн дээр 2.2 тэрбум долларын угаалт явагдаж байгаа. Зүгээр угаалт. Энийг би хэрвээ буруу, зөрүү ярьж байгаа бол энэ шүүхэд очих ёстой үг хэлж байна шүү дээ би. Даанч надад шүүхэд очихгүй л дээ

яагаад гэвэл би үнэн ярьж байгаа учраас. Энэ газрын тосны нөөц байхгүй, ус байхгүй, ТЭЗҮ нь баталсан гарын үсэг байхгүй. Би бусдыг нь ярьж болохгүй.

Яагаад гэвэл хүнээс ичээд цаадуул чинь нууцад оруулчихсан ийм. Тэр уран яриад бүр хүмүүсийн даралтыг нь ихэсгэхийн нэмэр л дээ. Тэгэхлээр ийм байдалтай байхад манай Байнгын хороо яаж хариуцлага тооцох вэ? Та нартай хамтарч ажлын хэсэг байгуулах уу, хамтарч одоо шалгалт оруулах уу? Шууд сайдыг нь огцруулахаар бид санал гаргах уу? Ямар механизмууд байгаа вэ? Энэ дээр Хяналтын үнэлгээний Үндэсний хорооны даргын хувьд Одбаяр сайд миний 3 асуултад хариулт өгөөч.

Э.Одбаяр: Сайнхүүгийн Ганбаатар даргын асуултад хариулъя. Хяналт хариуцлагын систем та санаж байгаа бол энэ хууль тогтоомжийн биелэлттэй холбоотой тайланг ингээд Байнгын хороод руу оруулж ирж байгаа энэ кэйс анх удаа явж байгаа кэйс. Тэгээд энэ дээрээ хэдүүлээ яг миний хувьд энэ сөрөг хүчнээ төлөөлж энэ хамтарсан Засгийн газарт энэ хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж яваа сайд хүний хувьд аль болох энэ кабинет доторх дотоод хяналтыг, кабинет дотроо 2-т Засгийн газар дахь хяналтын тухай хууль буюу 23 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлж байгаа энэ хуулийн дагуу төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймаг нийслэлийн Засаг дарга болоод хуулийн дараагийн нэг үйлчлэх заалт нь юу вэ гэхээр улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн үйл явцад явцын болон бүх шатад нь хяналт тавих эрх энэ Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт байгаа. Тэгээд энэ хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зарим тохиолдолд хуулиар олгогдсон төрийн албан хаагчдынхаа өөрөөр хэлбэл хянан шалгагч нарынхаа хүчээр хий хийх ажил байна. Зарим тохиолдолд энэ Улсын Их Хурлын гишүүдтэйгээ хамтарч хийж хэрэгжүүлэх, мэргэжлийн Байнгын хороотой хамтарч хийж хэрэгжүүлэх бас ажлууд байна. Тэгээд энэ дээрээ та хэдтэйгээ бас хамтарч ажиллая. Ер нь ил тод байя, болж байгаа, болохгүй байгаа юмнуудаа бас нээлттэй ярьдаг байя гэдэг концепцтой явж байгаа шүү гэдгээ бас хэлэх гэсэн юм.

Хоёрт юу вэ гэхээр Байнгын хорооноос гаргасан энэ 9 тогтоол 50 гаруй заалтуудын зарим хэрэгжилт хангалтгүй байгаа энэ заалтуудын хувьд цаг хугацааны хувьд бас ялгаатай. Өөрөөр хэлбэл 25 оны өнөөдөр 5 сарын 5-ны өдөр энэ өмнө гаргасан энэ тогтоолуудын хувьд 2022 он, 18 он, 19 он гээд хэрэгжилтийг нь тайлагнах хугацаа болоогүй бас мэр сэр ажлууд байгаад байгаа. Гэхдээ тэрнээс гадна яг хүнээс шалтгаалаад салбарын сайд болон салбарын яамнаас шалтгаалаад бас хэрэгжилт нь удааширсан байгаа, хоцорсон байгаа заалтууд байгаа. Энэ дээр саяын тэр кабинетын зарчмаар мэдээж салбарын сайдтай холбоотой асуудлыг Ерөнхий сайдын хэмжээнд ярих нь зөв байх. Гэхдээ миний хувьд бас саналаа бас үнэхээр яг ноцтой зөрчил, дутагдал гарсан үед саналаа оруулна гэж бодож байна. Төрийн албаны хувьд тэр хуулиар явна.

Газрын тосны үйлдвэрийн хувьд оны өмнө тэр дутагдаж байгаа нэмэлт санхүүгийн эх үүсвэрийг бас Улсын Их Хурлаар шийдүүлсэн. Тэгээд одоо байгаагаараа 28 оны 1 дүгээр улиралд багтаагаад орно гэсэн ийм хүлээлттэй байгаа. Энэ дээр зарим тохиолдолд таны хэлдэг зүйлүүдийг бас үгүйсгэхэд бас төвөгтэй. Гэхдээ зүгээр яг хуулиараа бид нар бас газар дээрх хяналтыг нь хамтраад хийгээд явцынх нь тухай мэдээллийг дэлгэрэнгүй аваад яваад байх боломжтой. Нууцад хамаарснаас бусад үйл ажиллагаа дээр нь. Одоогоороо бас Байнгын хорооны гишүүдийн хувьд ч, Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн хувьд ч бас газар дээр нь очиж ажиллаж бодит мэдээлэл авсан гэж ойлгож байгаа.

Тэгэхээр бас шууд дүгнэлт хийхэд бас арай зохимжгүй болов уу л гэж бодож байна миний хувьд.

С.Ганбаатар: Ингээд бас асуулт асуулаа. Миний асуусан асуултад яах вэ яах вэ. Ингээд хэдүүлээ хамтарч ажиллая. Өнөөдөр бас ингээд та нар шинэ яам, бас шинэ функц бас ингээд хариуцаад ажиллаж байгаа. Хэдүүлээ ингээд хамтарч ажиллана.

Ерөнхийдөө бол энэ Ерөнхий сайдын ганцхан зөв шийдвэр нь өөрийгөө хяналт тавих, өөрт нь хэрвээ буруу зөрүү, энэ Засгийн газарт буруу зөрүү юм байвал хянаж, засаж залруулах эрхийг сөрөг хүчиндээ өгсөн шүү. Энэ том бол соёл. Харин энийг нь нөгөө сөрөг хүчин гэж байгаа улсууд нь хийхгүй, аанайтаад, ангарайтаад, тал засаад, долоогоод яваад байвал Монгол орон сүйрэхэд улам л ойртоно гэсэн үг.

Тийм учраас бид энэ асуудлыг та нартайгаа бас хамтарч шийдэж хяналтыг тавья. Тэгэхгүй энэ Засгийн газрын дараа ажлаа дүгнээд янз бүрийн алдаа оноо гарч ирэх юм хянах ёстой байсан засаж залруулах ёстой байсан улсууд нь юу ч хийгээгүй гэдэг асуудалд унана гэдгийг маш их хүндэтгэлтэйгээр, нөхөрсөг, дэмжиж бас илэрхийлж байгаа гэдгийг та нар анхаараарай.

Ер нь манай оронд ганцхан хяналт, хариуцлага 2 л дутчихсан. Мөнгө дутаагүй. Дарга, цэрэг, сайд дутаагүй, шийдвэр тогтоол, хууль дутаагүй бүүр ихсэж байгаа. Тэгэхлээр энийг та нар маань анхаарна гэдэгт би итгэлтэй байна.

Одоо гишүүд үг хэлэх гишүүд саналаа өгнө үү.

Үүрийнтуяа гишүүн байна. Батлут гишүүн, Замира гишүүн. Сонгобайгийн Замира гишүүнээр тасаллаа. Ингээд Болдын Уянга гишүүн үг хэлнэ.

Б.Уянга: Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо яг ямар асуудлуудыг эрхэлдэг юм бэ гээд ихэнх асуудлууд нь Эдийн засгийн байнгын хороо руу явчихдаг болохоор тийм ойлголтын зөрүү байгаад байдаг шиг байдаг. Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд болохоороо 23.1-д аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо эрхлэх үндсэн асуудал нь ерөөсөө л үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөх ёстой, ЖДҮ-лэлээ бид нар дэмжих, хөгжүүлэх бодлогыг гаргана, хөнгөн үйлдвэрлэлийг дэмжинэ, хөгжүүлнэ гээд хүнд үйлдвэрлэлийг дэмжинэ, хөгжүүлнэ гээд. Тэгээд миний бодлоор энэ ажлын энэ Байнгын хорооны гишүүний хувиар Аж үйлдвэржилтийн байнгын хороо сайн ажиллаж байгаа гэж үзэж байгаа. Тэгээд яг өнөөдөр Одбаяр сайдын танилцуулсан танилцуулга өмнө нь яг энэ хүрээнд хийгдэж байсан ажил нь ямар шатад байгааг нь хэрэгжилт хэсэг дээрээ нэлээн дэлгэрэнгүй бичээд хэрэгжилт нь 0 байна гээд тодорхой хэдэн хуулийн төслүүдийг гаргаж өгсөн нь бид нарт өмнө нь хийгдсэн өмнө нь 4 жил хийгдсэн ажлыг давтахгүй байх боломжийг олгож байна гэж харж байна.

Тэгээд энэ хүрээнд Байнгын хорооны даргад нэг санал байна. Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруул гээд энэ Байнгын хорооны өмнөх 4 жилд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яаманд хүргүүлж байсан юм байна. Тэгээд яг хэрэгжилтийг нь уншихаар 21 онд үзэл баримтлалыг нь баталчихсан юм байна. Тэгээд одоо сайд нар нь өөрчлөгдсөнтэй холбоотойгоор үзэл баримтлалыг шинээр батлах ажил явагдаж байгаа гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар өмнө нь хэн хийгээгүй яагаад удсан нь тэгээд

хариуцлагаараа тогтоогдох байлгүй дээ. Одоо цаашаа хурдан энэ ажлыг Байнгын хорооноосоо шахамдуулж явъя гэвэл яг энэ үзэл баримтлалтай нь танилцвал яасан юм бэ гэсэн санал байна.

Хоёрдугаарх нь болохоороо энэ үйлдвэр технологийн паркийн ажлын хэсэг Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр ажиллаж байгаа. Тэгээд энэ хүрээнд Үйлдвэр, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль дээр байдаг татварын дэмжлэгийг холбогдох татварын хуулиудад нь тусгаж өгөх энэ ажлыг бид нар яг ажлын хэсгээр ярьж байгаа юм л даа. Тэгтэл өмнөх 4 жилд энэ бас яригдаад тэгээд хуулийн төслүүдийг нь оруулж ир гэсэн даалгавар өгсөн байна. Тэгээд энэ дээр бас ажиллажээ. Тэгэхээр энийг нь бас татаж аваад бүгдээрээ үзчихвэл хурдлах байх.

Гуравдугаарх нь болохоороо Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруул гэсэн байна. Үзэл баримтлал нь ер нь бэлтгэгдсэн байгаа гэж уншигдаж байна. Арай батлагдаагүй байгаа юм байна. Тэгэхээр энийг бас татаж үзэх юм бол ажил их хэмнэхээр байна. Тэгээд 4 дэх нь болохоороо энэ мал болон мал амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний бүтээгдэхүүн нь эцсийн бүтээгдэхүүн болох хүртэл тэр бүх үе шатыг нь мөрдөх тийм журмыг боловсруулъя. Цахим бүртгэлийн нэгдсэн системийг бий болгоё гэсэн юм байна. Тэгээд энийг 4-ийг онцолж хэлж байгаа нь болохоор энэ тайлагнал дээр 0 хувьтай буюу хэрэгжээгүй. Тэгсэн мөртөө хэрэгжилт хэсгийг нь уншихаар энэ засгийн бүрэлдэхүүн, холбогдох сайдууд нь солигдсонтой холбоотой хүлээгдэж байгаа юм шиг уншигдаад байгаа учраас манай бодлогын Байнгын хорооноос эдгээр асуудлуудыг нь татаж аваад, үзээд шахамдуулаад явах ийм боломжтой юм шиг харагдаж байна. Тэгэхээр энэ дээр нь Байнгын хорооны зүгээс мэдээллийг нь аваад тэгээд танилцах ийм саналтай байна дарга.

С.Ганбаатар: Болдын Уянга гишүүний санал дээр энэ маш ажил хэрэгч саналуудыг ярилаа шүү. Яагаад гэвэл ер нь өмнөх чуулган дээр ч гэсэн 20-24 онд яг энэ Аж үйлдвэрийн бодлогын байнгын хорооны гишүүд, удирдлагууд их ажил хэрэгч асуудал руугаа их гүн ордог байсан. Энхтүвшин дарга байна, Энхтүвшин гишүүн байсан, Чойжилсүрэн гишүүн байсан, Ганболд байсан, гишүүн байсан их ажил хэрэгч байсан. Тэгээд ийм ажил хэрэгч байхлаар бас зарим Их Хурал хурдан юмаа явуулах гээд эдийн засаг руу юмнуудаа шидчих гээд байдаг. Тэн дээр арай хурдан гардаг ч юм уу ийм байдал байж болохгүй. Би бас Даргын зөвлөлийн хурал дээр ярина. Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороон дээр асуудлуудыг нь ингээд алгасуулж өөр тийшээ шидэхээ болио гэдэг байр суурийг бас бас би их урам авч сонслоо. Тэгээд бас хэрүүлч гэдгээрээ сонсогдох гээд бас надад их хэцүү байдаг л даа энэ.

Хоёрдугаарт улирал болгон манай хяналтынхантайгаа бид ойрхон ажиллаж, тайланг нь сонсож, энэ энэ Хяналт, үнэлгээний Үндэсний хороотойгоо бид ойрхон ажиллана. Энийгээ бас дэмжиж, хамтарч ажиллана. Та нарынхаа бас бэрхшээлүүдийг бид ойлгож байгаа учраас. Тэгээд гишүүний 3 сард бид Эрдэс баялгийн яаманд хуулиа хурдлуул гэдэг бичиг явуулсан. Энэ дээр Үндэсний хороотойгоо хамтарч бас шахна. Тэн дээр бичиг явуулаад л тэгээд л ангал руу орчихсон юм шиг, гаваар орчихсон юм шиг л алга болдог. Энийг бас би үгэндээ сая гишүүдэд тусгалаа. Протоколд би бас онцолж энийг нэмж хэлж байгаа юм шүү.

Одоо Сонгобайгийн Замира гишүүн үг хэлнэ.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хяналт дүн шинжилгээ Үндэсний хорооны ингээд тайланг сонсоход л хангалтгүй гэж харагдаад байна л даа. 24 оны танилцуулгыг дөнгөж 25 оны 5 сард сонсож байдаг. Энэ маш удаан хугацаа. Сая миний хэлэх үгийг Ганбаатар гишүүн бас хэлчихлээ. Уг нь ингэж сунжруулахгүйгээр хэдүүлээ улирал болгон дүгнэлт хийж баймаар байх юм байна. Тэгээд дээрээс нь энэ манай Байнгын хороо Монгол орны үйлдвэр хөгжүүлэх, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх бүх юуг нь хариуцаж байгаа Байнгын хороо шүү дээ.

Тийм учраас энэ тал дээр энэ нь юу вэ гэхлээр Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дүгнэх, дэмжих Байнгын хороо гэсэн үг. Тийм учраас энэ хуулийн хэрэгжилтийг маш нарийн судлаад л тухай бүр буруу хууль батлагдсан энэ буруу байна манай хөгжилд энэ тэглээ болж байна. Эсвэл энэ хуулийг нэмж батлуулмаар байна гэсэн. Тийм хурдтай та нар минь ажиллаа ээ. Та нартай хамтран ажиллахад бэлэн байна. Маш их хууль баталлаа шүү дээ. Бид нар 24 онд, 25 онд ингээд яваад байхад яг Ганбаатар гишүүний яриад байгаа нь үнэн байхгүй юу. Бараг та бүгд ер нь хууль батлаад ингээд ном болоод л хэвтэж байх шиг байна. Тийм учраас та нар минь бас маш хурдацтай ажиллаад, шаардлагыг нь тавиад дүгнэлтээ хийгээд тэгж байж энэ бүхэн чинь аминд орно. Тийм учраас та нараас маш шуурхай ажиллахыг хүсье. Баярлалаа. Амжилт хүсье.

С.Ганбаатар: Сонгобайгийн Замира гишүүн үг хэллээ. Ганбатын Очирбат гишүүн үг хэлнэ.

Г.Очирбат: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны ажил бас жоохон хүнд л дээ. Яагаад гэхээр Засгийн газар дотроо дайсан болдог нэг талдаа. Нөгөө талдаа Их Хурлын энэ мэргэжлийн Байнгын хороонууд дээр бас дайсан болж харагдаад байдаг. Тэгээд урьд урьдын энэ түүхүүдийг нь үзэхээр их тийм бөөрөнхий маягтай явсан юм байна лээ. Нэг тайлагнасан болоод, нэг татсан болоод нийгэм рүү гарч ирээд хэлж ч чаддаггүй ийм юм явсан юм байна лээ. Энэний илрэл түрүүн бид нар энэ 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө, жилийн төлөвлөгөө дээр харлаа шүү дээ. Үндсэндээ Хяналт, үнэлгээний Үндэсний хороо байгуулагдсанаараа энэ тоонууд ил болсон шүү. Хуулиуд хэрэгжихгүй байна, тогтоолууд хэрэгжихгүй байна, тэгээд ил гаргаж ирж ганц тавьдаг байгууллага нь энэ Хяналт, үнэлгээний Үндэсний хороо болчихоод байгаа юм. Тэгээд 4 жилийн хөтөлбөр, жилийн хөтөлбөр дээр сүүлийн 8 жилийн, сүүлийн 4 жилийн хийснийг нь тоймлож үзэхэд 59 хувьтай л ажлаа хийсэн байсан шүү дээ. Энэ тоог ил гаргаж чадсан.

Тэгэхээр энэ Хяналт, үнэлгээний Үндэсний хороо ялангуяа Одбаяр сайд Ардчилсан намынхан энэ дээр байгаа. Бид ажлаа өшөө эрчимжүүлэх ёстой. Энэ хяналтаа илүү тавих ёстой. Энэ хяналтыг тавьснаараа хариуцлагажаад эхэлнэ. Тэгээд бас энэ Хяналт, үнэлгээний Үндэсний хорооныхоо даргын ярьж байгаагаар 5 сарын 1-нээс журмын төслөө батлуулсан гэж байна. Энэ журмын төслийг бас бид нар Их Хурлын чуулган дээр ярилцаад хүлээгээд байж байсан. Төлөвлөвөл төсөв, эдийн засагтай нь төлөвлөө. Гүйцэтгэлийг нь үзье, хяналт тавья, үр дүндээ хариуцлага тавья. Ийм тогтолцоо руугаа зөв орж явахгүй бол бөөрөнхийлсөн ийм маягаар сүүлийн олон жил ингээд явсан байгаа шүү.

Тэгэхээр бас энэ Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны хамт олонд энэ эрч хүчээ бас алдахгүй байх ёстой. Та хэд бол Монгол Улсын толь болсон. Ялангуяа

Их Хурлын гишүүд мэргэжлийн Байнгын хороонууд та хэдийн дата мэдээлэл дээр ажиллаж байгаа. Мөн дээрээс нь Үндэсний Аудитын газрын дата мэдээлэл дээр ажиллаж байгаа. Энэ дээр бас нэг юм тодотгож хэлэх ёстой байх. Бид түрүүн 4 жилийн хөтөлбөр, 1 жилийн хөтөлбөрийг ярьж байхад 3 тоо орж ирсэн. Нэг нь Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны тоо орж ирсэн. Нөгөөдөх нь Их Хурлын ажлаа тайлагнадаг Үндэсний аудитын газрын тоо орж ирсэн. Мөн дээрээс нь Улсын Их Хурлын Тамгын газраас тэр Хяналт, судалгааны газрынх нь тоо орж ирж байгаа. Яг одоо ч гэсэн ингээд 2 тоог өөр болгоод оруулаад ирчихсэн. Өөр өөрийнхөөрөө ярьдаг.

Тэгэхээр ийм маягаар цаашдаа яваад байх юм бол Улсын Их Хурлын гишүүд буруу мэдээллийг аваад, буруу дүгнэлт боловсруулах ийм юм руу бас шахаж хавчиж оруулж байгаа шүү гэдгийг та бүхэнд хэлэх гэсэн юм. Тэгэхээр Хяналт, үнэлгээний Үндэсний хорооныхон та хэд ингээд яг тоогоо бодитой гаргаад өгчих юм бол цаашдаа энэ улс эх орны хөгжил чинь их дэмтэй, тусдаа болох юм шүү. Энэ талаар анхаарч ажиллах ёстой гэж бодож байгаа.

Түрүүн Байнгын хорооны гишүүд ч гэсэн хэлж байна. Хяналт гэдэг хянаад шалгах гээд байгаа юм биш ажлыг сайжруулах гэж байгаа юм. Манай мэргэжлийн Байнгын хороо бүх энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, дээрээс нь эрчим хүч мөн дээрээс нь бүх л энэ яамнуудыг дэмжиж ажиллаж байгаа. Мэдээж бид ингээд асуултуудаа тавихдаа хурц та хэдэд тусаж байж магадгүй. Тэгэхдээ эцсийн дүндээ ажлыг сайжруулах гэж байгаа, улс эх орныхоо төлөө бас хамтдаа зөв шийдвэр гаргаад явах гэж байгаа шүү. Тэгээд та хэддээ бас ажлын амжилт хүсье. Энэ эрчээ алдахгүй байх ёстой. Тоогоо үнэн бодитоор гаргаж өгөөд хариуцлагыг нь ил болгоод ард түмэнд нээлттэй, хэвлэлд нээлттэй ажиллаарай гэж хүсье. Баярлалаа.

С.Ганбаатар: Ганбатын Очирбат гишүүн үг хэллээ. Ингээд Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа тайлантай танилцлаа. Мэдээллээр хангаж байгаад талархлаа илэрхийлье. Хэд хэдэн санал байна асуусан асуулттайгаа холбогдуулаад. Ер нь бид өнөөдөр Засгийн газрын хяналтын нэгжийн тайлан сонсож байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл Засгийн газрын дотоод хяналт. Засгийн газрын дотоод хяналтаа хийгээд хууль тогтоомжийн хэрэгжилт ямар байгаа талаар Улсын Их Хуралд тайлангаа гаргаад дотоод хяналтаа хийгээд ирүүлж байгаа. Улсын Их Хурал үүн дээр Улсын Их Хурлын Тамгын газрын хяналт шинжилгээний нэгж нь бас хяналтаа тайлангаа хамтад нь Байнгын хороонд оруулж байгаа байхгүй юу. 2 өөр институтын асуудал яригдаж байгаа шүү дээ өнөөдөр бол.

Өөрөөр хэлбэл, Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хийсэн тайлан дээр Улсын Их Хурлын зүгээс хяналтаа тавьж ажиллаж байгаа байхгүй юу даа. Тэгэхээр энэ хурал дээр уг нь Их Хурлын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс байсан бас их үр дүнтэй байх байжээ гэж харж байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын ирүүлсэн тайлан дээр Их Хурлын Тамгын газар юу гэж үнэлж дүгнээд байгаа юм? Тэгэхээр энэ дараа дараагийн удаагийн энэ хяналтын тайланг хэлэлцэхэд Их Хурлын Тамгын газраас орж байх нь зүйтэй байх гэж бодож байна.

Ер нь бид парламентын гишүүд, Их Хурлын гишүүд биднийг хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллээр хангах субъекттэй бас ажиллуулах хэрэгтэй

байна л даа. Өнөөдөр бид нар тэднийгээ бараг ажиллуулж ч мэдэхгүй яриад сууж байх шиг байна. Энэ хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан дээр хийсэн Их Хурлын Тамгын газраас хийсэн тайлан дээр ингээд харахад Одбаяр сайд аа журам зөрөхөөс гадна бас асуудал байгаа шүү дээ. Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоол, хуулиудын зүйл, заалт нь Их Хурлын хяналтын бүртгэл, системд байгаад байдаг. Хяналт шинжилгээ, үнэлгээний бүртгэл системд ороогүйгээс болоод тайлагнагдахгүй байгаа байхгүй юу. Тайлан нь ирэхгүй байна. Хэрэгжилт байгаа юм уу, байхгүй юм уу гэдэг нь мэдэгдэхгүй байхаас гадна тайлан нь ирэхгүй байна. Энэ асуудал дээр цаашдаа анхаарч системээ нэгтгээч. Бид нар чинь цахим Монгол болно гээд байгаа биз дээ? Их Хурлын Тамгын газрын бүртгэлд ороход л хяналт шинжилгээ, үнэлгээ Засгийн газрын бүртгэлд авдаг байх хэмжээнд бид нар системээ хийх хэрэгтэй.

Нөгөө талдаа энэ хэрэгжихгүй байгаад байгаа шалтгаан чинь ерөөсөө л 2 шалтгаантай л гэж би харж байгаа юм. Нэг бол хариуцлагагүйгээс болоод хэрэгжилтийг нь хангах хүмүүс ажлаа хийхгүй байна. Үгүй бол энэ гарч байгаа эрх зүйн баримт бичиг өөрөө амьдралд нийцэхгүй, үндэслэлгүй гарчихсан болохоор хэрэгжихгүй байна.

Тэгэхээр цаашдаа энэ тайлан дээр хэрэгжихгүй байгаад байгаа тэр хуулийн заалтыг би яагаад шаардаад байгаа юм гэхээр тэр 22 хуулийн 69 заалт гэдгээ гаргаж ирж байгаад энийг нь энэ сайдаас болоод, энэ албан тушаалтнаас болоод хэрэгжүүлсэнгүй. Энэ нь өөрөө амьдралд нийцэхгүй ийм юм хийчихсэн учраас хэрэгжсэнгүй Улсын Их Хурал энийг эргэж хараач гэдэг юмыг гаргаж ирдэг баймаар байна. Тэгж байж өөрөө энэ үр дүнд хүрнэ.

Хэрэгжүүлэхгүй байгаагаа тэчнээн хуулийн заалт, тэчнээн тогтоол гэхээс илүүтэй хэн хариуцаад, хэн үүрэг даалгавар аваад хэрэгжүүлээгүй юм бэ гэдэг эзэн биетэй нь оруулж ирмээр байна. Ингэж байж бид нар хариуцлага ярихгүй бол өнөөдөр хэрэгжээгүй байна гэж ярьчихаад дараа нь яах юм. Эдийн засгийн хөгжлийн яам Их Хурлын гишүүний асуултад хугацаанд нь хариу өгөөгүй гээд би Байнгын хороон дээр асуудлыг сонсох хүсэлт гаргаад 4 сарын 30-ны өдрийн хурлаар сонссон 14 мега төслийн хэрэгжилтийг.

Би хэрэгжилт тайлагналт хангалтгүй байна. Гишүүний асуултад ирүүлж байгаа тэр албан бичгийн мэдээлэл хангалтгүй байна. Дэгийн хуулиараа 2 хоногийн дотор Байнгын хорооны хуралдаанаас өгсөн үүргийн дагуу мэдээлэл гаргаж өгөх үүрэгтэй яамд, албан тушаалтнууд. Энэ үүргийнх нь дагуу мэдээлэл шаардсан. Өнөөдөр хэд хонож байна тэр хурлаас хойш 4 сарын 30 өнөөдөр 5 сарын 6. Одоо болтол ирээгүй. Тэгээд ямар хариуцлага тооцох юм?

С.Ганбаатар: Ерөнхийдөө гишүүд асуулт асуулаа. Сая Үүрийнтуяа гишүүний асуултыг бас тодруулж хэлэхэд Эдийн засгийн Шадар сайд, эдийн засаг хариуцсан Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайдын яаманд та бүхэн бас хариуцлага тооцох ёстой шүү. Аж үйлдвэрийн бодлогын байнгын хорооны даргын хувьд би гишүүдийнхээ ажиллах нөхцөлөөр хангах, Байнгын хорооны гишүүдийн ажиллах боломжийн төлөө ажиллана. Тэгэхлээр энэ бичиг цаас ерөөсөө ирэхгүй байгаа шүү. Тэр 6 хоногийн өмнө ярьж байхад л аль хэзээний хариулт өгөх ёстой 30 хоног нь дуусчихсан байсан. Энэ дээр та нар маань бас анхаараад Хяналт, үнэлгээний Үндэсний хороо маань энэ дээрээс бас анхаарч бас хариуцлага тооцож мэдэгдээрэй.

Дээр нь нэмээд ер нь ард иргэд, гишүүдийг сонгодог, ялангуяа аж үйлдвэртэй холбоотой асуудал дээр энэ Аж үйлдвэрийн бодлогын байнгын хорооны гишүүд л ард түмний өмнө үүрэг хүлээнэ. Ард түмэн сайдыг сонгодоггүй, Ерөнхий сайдыг ч сонгохгүй. Бид өнөөдөр та нарт үүрэг даалгавар өгч байгаа. Тэгэхээр тэрний хэрэгжилт бага, муу байна, 50 хувьтай байна гэдэг бол Засгийн газрын 50 хувийн сайд нарыг огцруулахаас өөр аргагүй байдалд орчихсон байна гэсэн үг уг нь. Тэгээд ингээд эзэн биегүй яваад л байвал Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ 50 хувь ажлаа муу хийж байна гэсэнтэй адилхан үг болж байна.

Тэгэхлээр сая гишүүдийн ярьдаг эзэн биетэй тодорхой байгаарай. Энэ дээр ганцхан Хяналт, үнэлгээний Үндэсний хороон дээр би бас яриад байхаас илүү ганц гайгүй ажил хийж байгаанууд руу нь ингээд бид яриад байгаа юм биш. Харин ч ажлаа уялдуулъя, сайжруулъя гэж ярьж байгаа юм шүү. Өнөөдөр Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газар гээд манай Алтантуяа дарга байгаа. Бас л энэ дээр идэвхтэй, чармайлттай ажиллаж байгаа байх. Аудитын байгууллагууд байгаа. Эд нар бас хүчээ нэгтгэж Монгол оронд хяналт, хариуцлага л дутаж байгаа. Толгойг нь илээд байгаа учраас л баясаад л цаад сайд нар чинь ерөөсөө л дэлхий цээжинд нь багтаад л яваад байгаа юм шүү дээ. Тэгээд л хэдэн гишүүдийг харахлаар л ерөөсөө санаанд нь багтаад л, жижиг харагдаад л. Энэ арчаагүй тэнэглэлүүдийг нь зогсоох гэж бид өнөөдөр энд хуралдаж байгаа шүү. Өнөөдөр иргэд дээр очоод л муу гишүүд л загнуулдаг юм шүү дээ. Сайд нар яах вэ хариуцлага тооцож ажлыг нь хийлгэмээр байна гэдэг нь чухал.

Ингээд би үг хэлэх дээр би 2 санаа хэлчихмээр байна. Аймаг, орон нутагт Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт улаа нойл байгаа. Тэр дундаа ганц ард түмнийг тэр алтыг нь аваад авдрыг нь хаяв гэдэг шиг ард түмэнтэй нь хэлэлцээр хийж ард түмэнд нь жоохон юм наалдуулдаг 42 дугаар зүйлийг ерөөсөө огт хэрэгжүүлэхгүй. Энэ хуулийн хэрэгжилтийг хангах гээд Замира гишүүнээр ахлуулаад бид ажлын хэсэг байгуулж байгаа. Та нар маань бас энэ дээр хамтарч ажиллаасай.

Дээр нь манай хангайн тойрог дээр ч биш ер нь улс орон даяар аймгууд дээр ИТХ-ын төлөөлөгчид нь ерөөсөө дандаа хууль зөрчигд томилогдчихсон, шүүхийн шийдвэр гарчихсан. Тэгээд энэний хэрэгжилт байхгүй. Аж үйлдвэртэй холбоотой асуудал биш юм шиг боловч би үгэн дээрээ онцолж хэлж байгаа юм шүү. Үгүй ийм байхад яаж хууль хэрэгжих вэ дээ. Хууль зөрчөөд толгой дээрээ залчихсан байгаа иргэдийн төлөөлөгчдөөс юу гарах вэ. Толгой дээрээ гэмт хэрэгтэн залчихсан байхад бид нар ер нь хаашаа харна? Хяналт, үнэлгээний Үндэсний хороо бидэнтэй ойлголцож, хамтарч ажиллаж, ард түмэн энэ сонгогчдынхоо төлөө хэдүүлээ багахан шиг загнуулж энэ ажлыг амжилттайнхан шиг хийчих юм сан л гэж горьдож байна.

Ингээд улирал болгон хэдүүлээ тайлангуудаа ярилцаж, түрүүн Өнөрбаяр дарга их чухал зүйл хэлсэн шүү. Ингээд л зүгээр үр дүнг нь бид нар харах гээд л тэвчээртэйнхэн шиг 4 жил хүлээж байгаад л харсан. Нөгөөдүүл чинь улаан нойл байдаг. Тэгээд л бид харьяалаад л сонгууль руугаа орчихно. Үйл ажиллагааных нь явцыг нь тухайн тухайн үед нь тү дү/to do/листүүдийг нь дүгнээд дүгнээд явъя. Энэ чинь цагийн 50 хувь нь өнгөрчихсөн байна. Ажлын 50 хувь явагдсан уу? Үйл ажиллагааны аль аль төлөвлөгөөтэй нь, хяналттай нь уялдуулмаар байна гэдэг санаан дээр би их магнайгаа хагартал баярлаж байна. Өнөөдөр ажил хэрэгч чухал мэдээллүүд солилцлоо гэж үзэж байна. Гишүүд маань бас чухал ажил хэрэгч асуултууд асуулаа.

Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Эрдэнэбилигийн Одбаяр болон хамт олонтой нь улс нь бид мэдээлэл авлаа. Энэ аж үйлдвэртэй холбоотой Монгол орон аж үйлдвэрлэлээрээ л улаан нойл байгаа шүү дээ. Жишээ нь нүүрс зарахаараа л хамгийн сайн байгаа байх. Архи үйлдвэрлэхийг нь мартчихаж. Архи зарахдаа бас сайн байгаа. Ийм 2 юмаар бусдаар улаан нойл байгаа. Тэгээд аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд хэдүүлээ ойрхон баг болж бас энэ том толгойтой сайд нар дээр жоохон хариуцлага тооцож ажиллана гэж чин сэтгэлээсээ итгэж байна. Мэдээлэл өгсөн та бүхэнд баярлалаа.

Ингээд дараагийнхаа асуулт руу орно. Дулааны, ер нь ийм юм байна. Гишүүд ирц дээрээ байж байгаа хэлэлцэх асуудал дээр гуравт нь байх. Байхгүй тэгвэл хэлэлцэх ер нь ирцээ бүрдүүлэх юм байна шүү энэ 3 дахь асуудал дээр ингээд хэлэлцэх асуудлын.

12.55 цаг

Хоёр.Дулааны цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хэрэгжилт салбарын үнийн өсөлтийн талаарх эрчим хүчний сайдын мэдээллийг сонсоно.

Энэ дотор бас 10 аймгийн дампуурчихсан 10 дулааны станцын тухай бас мэдээлэл орж ирж байгаа гэж би итгэж байгаа. Мэдээллийг сонсоно.

Ингээд албаны хүмүүсээ би танилцуулъя. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Эрчим хүчний сайд Чойжилсүрэн сайд ирсэн байна. Тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ерэн-Өлзий ирсэн байна. Тус яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Лувсанцэрэн ирсэн байна. Тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Энхтүвшин ирсэн байна. Тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Мөнхчулуун ирсэн байна. Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч Товуудорж ирсэн байна. Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч Дашмягмаржав ирсэн байна. Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тарифын газрын дарга Эрдэнэбулган ирсэн байна. Ингээд албаны хүмүүсийг танилцууллаа. Мэдээллийг Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн танилцуулна. Чойжилсүрэн сайдад микрофоныг нээж өгье. 5 номерын микрофон.

Б.Чойжилсүрэн: Эрхэм байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Монгол Улсад эрчим хүчний салбарт үнэ тарифыг бодит өртгөөс.

Эхний асуудлаа ярьж эхэлье. Цахилгаан, дулааны үнийн өсөлт, үр дагаврын талаар асуулгын хариу юу танилцуулгыг хийе.

Монгол Улсад эрчим хүчний салбарт үнэ тарифыг бодит өртгөөс доогуур буюу 1 квт-аас цаг цахилгаан эрчим хүчний өөрийн өртөг 280 төгрөг байхад хэрэглэгчээс авах цахилгааны дундаж тариф 2023-2024 онд 216 төгрөгөөр, үүнээс айл өрхийн тариф дунджаар 140 төгрөгөөр буюу бодит өртгөөс 2 дахин доогуур тогтоогдож ирсэн. Үүний улмаас нүүрсний уурхай, нүүрсний төмөр замын тээвэр болон эрчим хүчний салбар нийтдээ 2024 онд 355 тэрбум төгрөгийн алдагдал хүлээх тооцоо гарч хуримтлагдсан. Өр төлбөр 357 тэрбум төгрөгт хүрсний улмаас

түлш эрчим хүчний энэ богино хугацаатай өр төлбөр шүү, улмаас эрчим хүчний үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд нүүрсний хангамж, эрчим хүчний тоног төхөөрөмжид аваар сааталд гарах эрсдэл нэмэгдсэн, ур чадвар бүхий бэлтгэгдсэн ажиллах хүчний хомсдолд орсон, ажиллагчдын цалин хөлсийг банкнаас зээл авч тавихад хүрсэн зэрэг хүндрэлүүд гарч байна. Мөн эрчим хүчний салбарын хэмжээнд өвлийн их ачааллын үед суурилагдсан бүрэн хүчин чадлаараа нөөц тоноглолгүй аваарын горимд ажиллаж томоохон чадлын шинэ эх үүсвэр барьж ашиглалтад оруулаагүйн улмаас эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангаж чадахгүй хязгаарлалт хийх хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн.

Дээрх нөхцөл байдлуудыг харгалзан эрчим хүчний үнэ, тарифыг бодит өртөгт нийлүүлэн шинэчлэн тогтоох зорилгоор Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгааны тарифыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан.

Тухайлбал, цахилгааны дундаж тариф 216 төгрөгөөс 280 төгрөгт хүрч 29.6 хувиар нэмэгдсэн. Үүнд:

Уул уурхайн олборлох боловсруулах аж үйлдвэр ангиллын дундаж тариф 294 төгрөг байсныг 342 төгрөг болгож, 16.3 хувиар бусад үйлдвэр. Бусад аж ахуйн нэгж байгууллагын дундаж тариф 222 төгрөг байсныг 291 төгрөг болгож, 30.7 хувиар, айл өрхийн дундаж тариф 140 төгрөг байсныг 212 төгрөг болгож, 50.8 хувиар тус тус өөрчилсөн.

Энгийн тоолууртай айл өрхийн цахилгааны тариф 150 квт-аас цаг хүртэл хэрэглээнд 134.28 төгрөг байсныг 175 төгрөг болгож 30 хувиар, 151 квт-аас цагаас дээш хэрэглээний тариф 154.08 төгрөг байсныг 151-ээс 300 квт-аас цагийн хооронд 256 төгрөг болгож болгож 66 хувиар, 301 квт-аас цагаас дээш хэрэглээний тарифыг 285 төгрөг болгож 85 он хувиар тус тус өөрчилсөн.

Айл өрх эрчим хүчний хэрэглээгээ хэмнэх сонирхлыг төрүүлэхийн зэрэгцээ өрхөд очих төлбөрийн ачааллыг бага, ялгаатай байхаар тооцож, хэрэглээнээс хамаарсан 3 шатлал бүхий тарифыг ийнхүү нэвтрүүлсэн. Мөн 2 цагийн ялгаварт тоолууртай хэрэглэгчийн шөнийн тариф 30-40 хувийн өөрчлөлт оруулж, үүний зэрэгцээ айл өрхийн цахилгааны хэрэглээгээ удирдах, тохируулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 3 цагийн ялгаварт тарифыг шинээр нэвтрүүлсэн бөгөөд 2 цагийн ялгаварт тоолууртай хэрэглэгчийн тарифтай харьцуулахад оройн оргил цагийн тариф нь өндөр, өдрийн болон шөнийн цагийн тариф нь доогуур байх түвшинд тогтоосон.

2019 оноос хойш 5 жилийн хугацаанд айл өрхийн цахилгаан, дулааны тарифт өөрчлөлт ороогүй тогтвортой мөрдөж ирсэн бөгөөд улсын хэмжээнд нийт 788 мянган ахуйн хэрэглэгчийн хувьд 1 өрхийн сарын хэрэг хэрэглээ дундаж хэрэглээ 220 квт-аас цаг байна.

Айл өрхийг цахилгаан эрчим хүчний хэрэглээний бүтцээр авч ангилж үзвэл 45 хувь нь 150 квт-аас цаг хүртэл, 40 хувь нь 150-300 квт цагийн хооронд, 11.3 хувь буюу 301 квт-2000 квт, интервалд 3.8 хувьд байна.

2001квт цагаас дээш хэрэглээ бол 3 нийт өрхийн 3.8 хувьтай тэнцэх ийм бүтэц бүтэцтэй байна гэдгийг хэлье. Тарифын өөрчлөлттэй холбоотойгоор гэр хорооллын цахилгаанаар халаалтаа шийдсэн өндөр хэрэглээ бүхий айл өрхүүдээс

төлбөрийн талаар өргөдөл, гомдол ирсэнтэй холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хороо, Улаанбаатар ЦТС ТӨХК-аас хамтарсан ажлын хэсэгт томилж, тэдгээр айл өрхүүдэд очиж газар дээр нь цахилгааны тоолуур сууцын дулаан алдагдал, халаалтын тоног төхөөрөмжийг судлан хэмжиж цахилгааны төлбөр үндэслэлтэй эсэх, төлбөрийн шалтгааныг тодруулан сууцын дулааны алдагдлыг бууруулах, хэрэглээгээ хэрхэн удирдаж хэмнэх талаар зөвлөмжүүдийг өгөх ажлыг зохион байгуулж ирлээ.

Агаарын бохирдлыг бууруулахад тодорхой хувь нэмрийг оруулж буй эдгээр айл өрхүүдийн төлбөрийн өсөлтийг зохистой хэмжээнд хүртэл бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн хурал дааны 115 дугаар тогтоолоор гэр хорооллын айл өрхийн цахилгааны тарифт хөнгөлөлт үзүүлэх журамд өөрчлөлт оруулж, хөнгөлөлтөд хамрагдах хугацааг оройн 21цагаас өглөөний 6 цагийн хооронд байсныг өглөөний 9 цаг болгож сунгаж, Эрчим хүчний зохицуулах хорооноос гэр хорооллын айл өрхийн хөнгөлөлтөд хамрагдах сарын хэрэглээний дээд хэмжээг 2 дахин нэмэгдүүлсний дагуу цахилгаан түгээх компаниуд 2 дугаар сарын 1-ний өдрөөс хөнгөлөлтөд хамрагдах айл өрхийн цахилгааны хөнгөлөлтийг нөхөн тооцсон.

Дулааны эрчим хүчний шинэчлэгдсэн тарифыг 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс мөрдөхөөр шийдвэрлээд байсан боловч Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн “Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 132 дугаар тогтоолын дагуу эрчим хүчний зохицуулах хорооноос 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хойшлуулах шийдвэрийг гаргаад байна.

Энэхүү Засгийн газрын дээрх тогтоолын хүрээнд 2025 онд цахилгааны тарифыг индексжүүлэх асуудлыг мөн хойшлуулсан. Тарифын шинэчлэл хийснээс хойш хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгж хэрэгжүүлнэ. Тодорхой үр дүнд хүрч байна. Үүнд:

1.Төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний үнийг өртөгт хүргэн шинэчлэн тогтоосон бөгөөд 2025 онд нүүрсний уурхайнуудын нүүрс олборлох үйл ажиллагаа алдагдалгүй болж хэвийн үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн.

2.Мөн олон жил алдагдалтай тарифаар нүүрс тээвэрлэлт ирсэн УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгийн эрчим хүчний дотоодын нүүрс тээвэрлэлтийн тариф 2025 оноос эхлэн алдагдалгүй байхаар шийдвэрлэсэн.

3.Эрчим хүчний үйлдвэр компаниуд 2025 онд алдагдалгүй ажиллахаар зорилтот түвшинд бизнес төлөвлөгөө батлуулсан.

Эрчим хүчний салбар улсын төсвийн татаасгүй болсон.

4.Эрчим хүчний хүртээмж, чанар, хүчдэлийн уналтыг сайжруулах зорилгоор 107 сум Улаанбаатар хотын 8 дүүрэгт хөрөнгө оруулалтаар 422 төрлийн техникийн шинэчлэлийг хийнэ.

5.Эрчим хүчний ажиллагсдын цалин хөлсийг 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 хувиар өсгөж тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж байна.

2023, 2024 онд ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлсэнтэй холбоотой зардлын өсөлтийг санхүүжих эх үүсвэр бүрдсэн.

6.Шинээр баригдах эрчим хүчний эх үүсвэрийн төслүүд хэрэгжих боломж бүрдэж бусад салбаруудыг боомилгоч биш дээ дэмжигч салбар болж хувирах нөхцөл бүрдэж байна.

7.Эрчим хүчний салбарт хөрөнгө оруулагчийн сонирхлыг татах нөхцөл бүрдэж байна.

8.Эрчим хүчний салбарт зах зээлийн зарчмаар үнэ тариф тогтоох индексжүүлэх үндсэн суурь нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байгаа гэдгийг та бүхэнд дуулгая.

Хэдийгээр тарифын шинэчлэлийн хүрээнд дээрх томоохон эерэг үр дүнгүүд гарч байгаа боловчиг дулааны тариф болон эрчим хүчний тарифын индексжүүлэлт 2025 оны төсвийн жилд хийгдэхгүйгээс шалтгаалан эрчим хүчний үйлдвэр компаниудад 2025-2026 онд хийхээр төлөвлөсөн засвар, шинэчлэл болон урт хугацаат зээлийн эргэн төлөлт, өмнөх онуудад хуримтлагдсан богино хугацаат өр төлбөрийг төлж барагдуулах, Улаанбаатар хотод 2028 онд дуусаж шинээр ашиглалтад орох 80 мянган айлын орон сууцын цахилгаан, дулааны хангамжийг шийдвэрлэх асуудлууд хойшилж байгаа гэдгийг дуулгая.

Хоёр дахь асуудлаа танилцуулъя та бүхэнд.

Тавантолгойн ДЦС-ын төслийн талаар

Говийн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангах Оюу толгой, Тавантолгой зэрэг томоохон уул уурхайн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангах суурь горимд ажиллах эрчим хүчний үүсвэрийг бий болгох хүрээнд Тавантолгойн 450 МВт-ын ДЦС төслийн төлөвлөлт хийгдэж ирсэн. Олон улсын банк, санхүүгийн байгууллага улс орнууд нүүрсний төслүүдийн санхүүжилтийг зогсоосон зэрэг шалтгааны улмаас төслийг санхүүжүүлэх, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх этгээдийг хамтад нь юу сонгон шалгаруулах шаардлагатай болж тендерийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 133 дугаар Тавантолгойн ДЦС төслийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх тухай тогтоолын хүрээнд 300мвт дээр нэмэх нь 150 МВт-ын гэс гэж 2 үе шатад хуваан эхний ээлжид 300 МВт-аар барилга угсралт болон санхүүжүүлэх эх үүсвэрийг хамтатган И Пи Си+Файнансинг/ЕРС+F/ хэлбэрээр зохион байгуулах эхний үе шатны 300 МВт-ыг нь И Пи Си +Файнансинг/ЕРС+F/ гэрээний 30 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцахаар шийдвэрлэсэн.

Тус тогтоолын дагуу төслийн гүйцэтгэгч болон санхүүжилтийг сонгон шалгаруулах И Пи Си+файнансинг/ЕРС+F/ нөхцөлтэй олон улсын нээлттэй тендерийг 2023 оны 6 дугаар сард зарласан боловч тендерт оролцогч компаниудаас удаа дараа Сангийн яаманд гомдол, маргаан гаргасан бөгөөд хуулийн хугацаанд багтаан гэрээ байгуулах боломжгүй болсноор тендер хүчингүй болсон.

Тендер хүчингүй болсонтой холбогдуулан тендерт оролцогчдын зүгээс шүүхэд нэхэмжлэл гаргаж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг 2024 оны 12

дугаар сар хүртэл үргэлжилж, Улсын дээд шүүхийн хяналтын шатын шүүхийн тогтоолоор нэхэмжлэлийн.../минут дуусав./

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайдад нэмж мэдээлэл өгөх боломж өгье. 5 номерын микрофоныг нээж өгье. 3 минут.

Б.Чойжилсүрэн: Ганбаатар дарга дахиад 6, 7 хуудас байна. Бүгдийг нь унших уу, эсвэл та бүхэнд танилцуулга хүргүүлсэн учраас шууд асуулт хариултдаа орох уу?

С.Ганбаатар: Гишүүд, тэгвэл гишүүдээс та гол дүгнэлтүүдээ хийчих. Цаасаар бид бүгдийг нь авчихсан, танилцсан байгаа учраас.

Б.Чойжилсүрэн: Цаасаар бид нар хүргүүлсэн учраас энийг би товчлоод уншиж байгаа юм.

С.Ганбаатар: Анхан.

Б.Чойжилсүрэн: Тэгэхээр. Гэтэл бас дахиад дахиад 5, 6 минут болох юм шиг байна. Та бүхнийг цагийг хэмнэх үүднээс шууд асуулт, хариулт байвал би энийгээ унших юмаа зогсоогоод асуултад хариулахад бэлэн байна.

С.Ганбаатар: Шүүхийн шийдвэрийнхээ шийдвэрийг уншчихаад тэгээд бидэнд цаасаар байгаа учраас асуулт руугаа оръё гэж гишүүдээс хэлж байна. Ингээд 3 минутаа шинээр нэмж өгөөрэй.

Б.Чойжилсүрэн: Тус тогтоолын дагуу төслийн гүйцэтгэгч болон санхүүжүүлэгчийг сонгон шалгаруулах И Пи Си+файнансинг/ЕРС+F/ нөхцөлтэй олон улсын нээлттэй тендерийг 2023 оны 6 дугаар сард зарласан боловч тендерт орлогч компаниудаас удаа дараа Сангийн яаманд гомдол, маргаан гаргасан бөгөөд хуулийн хугацаанд багтаан багтаан гэрээ байгуулах боломжгүй болсноор тендер хүчингүй болсон.

Тендер хүчингүй болсонтой холбогдуулан тендерт оролцогчдын зүгээс шүүхэд нэхэмжлэл гаргаж маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг 2024 оны 12 дугаар сар хүртэл үргэлжилж, Улсын дээд шүүхийн хяналтын шатын шүүхийн тогтоолоор нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Цаашид төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад одоо үйлчилж байгаа хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах шаардлагатай ба Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай цаашид Төр, хувийн хэвшлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хуулийн хүрээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад дараах бэрхшээл хязгаарлалтууд үүсээд байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн юу хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулиар хэрэгжүүлэх тухайд 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн хуулийн шинэчилсэн найруулгад түлхүүр гардуулах нөхцөлтэй И Пи Си/ЕРС/ зохицуулалтыг хассан тул И Пи Си/ЕРС/ нөхцөлтэй тендер зарлах боломжгүй нөхцөл байдал үүсээд байгаа.

Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудад төслийн зураг, төсөл бүрэн хийгдээгүй байхад тендер шалгаруулалт хийхийг зарлахыг хориглосон. Гэтэл ДЦС зэрэг түгшил өндөртэй инженерийн байгууламж бүхий төслүүдийг ТЭЗҮ болон тойм зурагт үндэслэн гэрээг байгуулж нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэгч төслийн инженерчлэлийн шийдлийг боловсруулж дууссаны дараа хийж дуусгадаг олон улсын жишигтэй. Төслийн одоо байгаа бичиг баримтад төслийн нарийвчилсан зураг, төсөл боловсруулагдаагүй тул тендер шалгаруулалт зарлах боломжгүй гэх мэт ийм хүндрэлүүд байгаа гэдгийг хэлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайд мэдээллийг дэлгэрэнгүй ирүүлсэн байна. Ажил хэрэгчээр бас нэлээн ажил хэрэгч мэдээллүүд ирсэн. Ингээд бид бүгдээрээ цаасаар авсан учраас дэлгэрүүлж асуултдаа орно. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Дуламын Бум-Очир гишүүн орсон уу таных орсон уу Лувсанжамц гишүүний бас нэрийг оруулаарай. Ганбат гишүүний нэрийг бас оруулаарай. Ганбатын Хосбаяр гишүүний нэрийг оруулаарай. Пунсалмаа гишүүнээр тасаллаа. Ингээд гишүүд асуултаа асууна. Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яамныханд их баярлалаа. Өнөөдөр бас ингээд дэлгэрэнгүй танилцуулгыг бидэнд тарааж, бас танилцуулга хийж байгаа явдалд их баярлалаа.

Эрчим хүчний сайд танаас ганцхан асуулт байна. Энэ цахилгаан дулааны үнийн өсөлт үр дагаврын талаар энд танилцуулахдаа бичсэн байна. Эрчим хүчний хүртээмж, чанар, хүчдэлийн уналтыг сайжруулах зорилгоор 107 сум, тэгээд Улаанбаатар хотын 8 дүүрэгт хөрөнгө оруулалтаар 422 төрлийн техник шинэчлэлийн ажил хийх юм байна. Тэгж заасан байна. Тэгэхээр энэ 107 сумаас Баян-Өлгий аймагт хэдэн сум орсон болоо? Баян-Өлгий аймгийн хэдэн сумыг ингээд шинэчлэхээр төлөвлөсөн байна? Та энийг тодорхой хэлээд өгөөч. Баярлалаа.

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайд асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Бид уул нь 2024 оны төгсгөлд энэ эрчим хүчний үнийг нэмэгдүүлсний дараа 2025 онд энэ 280 төгрөг бол эхний ээлжид одоо энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станц, Тосонгийн цахилгаан станц гэх мэт шинэ эх үүсвэрүүдийн үнийн өөрчлөлтийг тусгаагүй ийм үнэ гэдгийг бас та бүхэнд хэлэх хэрэгтэй.

Бөөрөлжүүтээс бид нар 8.95 центээр 1квт цаг эрчим хүчийг сүлжээнд нийлүүлж байгаа боловчиг энэ 285 төгрөг гэдэг 1квт цагийн өртөгт бол оруулаагүйд тооцсон 2024 оны 6 сарын 30-ны үеэр бий болсон өртөг 280 төгрөг байсан юм. Тэгээд энэ цахилгаан эрчим хүчний үнийг нэг нэмэгдүүлсэн.

Хоёрдугаарт дулааны үнийг 2025 оны 5 сарын 16-ны өдрөөс нэмэгдүүлэхээр шийдвэр гаргасан байсан боловчиг Засгийн газрын тогтоол гараад энэ дулааны үнийг нэмэгдүүлж чадаагүй. Нэн ялангуяа Улаанбаатар хотод, бусад суурин газрууд дээр ч мөн ялгаагүй.

Гуравдугаарт цахилгааны үнийг тэр 280 төгрөгт 1 удаа хүргээд түүнээс цааш инфляцын түвшин, валютын ханш, импортын цахилгаан эрчим хүчний үнэ шинээр бий болж байгаа цахилгаан эрчим хүчнүүдийн эх үүсвэрүүдийн үнээс шалтгаалаад индексжүүлнэ гэсэн ийм бодлого Эрчим хүчний Үндэсний хороо, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороон дээр бид нар ийм ойлголттой явж байсан чинь манай энэ нөхцөл байдал энэ шинэчлэл маань яг одоо газрын дунд талд болчихоод зогсчихсон байгаа ийм нөхцөл байдалтай үүсэж байгаа юм.

Тийм учраас энэ зорилтот түвшнүүдэд өөрчлөлт оруулаад саяын миний дурдсан 107 сум болон 422 арга хэмжээний нэлээдгүй хэсгийг нь буцааж хийж чадахгүй нөхцөл байдал үүсчээд байна. Гэтэл сая 2023 оны 3 дугаар сарын дундуур Засгийн газрын тогтоол гараад эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудын 66 хувийг “Эрчист Монгол” гэдэг компани эзэмшихээр, 34 хувийг нь Эрчим хүчний яам эзэмшихээр ийм Засгийн газрын тогтоол гарсан.

Энэ Засгийн газар тогтоол гарсны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал зарласан. Одоо “Эрчист Монгол” компани энэ ТУЗ-ийнгаа байгуулах, бусад менежментийн эрх “Эрчист Монгол” компанид шилжиж байгаа гэдгийг бараг та бүхэнд хэлье.

Энэ 422 сумаас тодорхой хэмжээний энэ шинэчлэлийн асуудлууд буцаж хасагдахаас ондоо аргагүй нөхцөл байдалд орсон гэдгийг бас хэлье. Тэгэхээр энэ “Эрчист Монгол” компани энэ зорилтот түвшнээ шинэчилж батлаад энэний дараа танд эцсийн мэдээлэл хүргүүлэхгүй бол одоо энэ нөхцөл байдлаас шалтгаалаад бид нар олон нийтэд буруу хүлээлт үүсгэх ийм төвөгтэй байдал үүсэж байгаа юм.

Эрчим хүчний сайдын төсөв, багц дээрээс та бүхэн Улсын Их Хурлын 2025 оны улсын төсөв баталж өгөхдөө бүс нутгийн цахилгаан хангамж төсөл хэрэгжүүлэхээр 59 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2025 онд санхүүжих дүн нь 28 тэрбум төгрөгийн ажил хийж өгсөн. Энэ дээр бол хэд хэдэн Баяр.../минут дуусав./

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайд, Жангабыл гишүүн нэмж тодруулж асууя.

Х.Жангабыл: Эрчим хүчний сайд та өөрөө сайн мэдэж байгаа сумуудад бол эрчим хүчний хүртээмж, чанар, хүчдэлийн уналт гэдэг чинь бараг байхгүй дээ. Бид бол ингээд тойргоор явахдаа байнга иргэд асуудаг тийм асуудал. Тэгэхээр та танилцуулга дээр энд биччихээд сая бас шал өөр юм яриад байх юм. Зовлон байна л даа, асуудалгүй. Гэхдээ энийг даван туулах хэрэгтэй.

Тэгэхээр 107-гоос бага болох юм байна. Бага болсон ч гэсэн Баян-Өлгий аймагт хэдийг хэрэгжүүлэх юм бэ? Тодорхой хариулчаач та.

С.Ганбаатар: 5 номерын микрофонд Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Жангабыл гишүүн ийм учиртай одоо батлагдчихсан байгаа зорилтот түвшинд, ТӨК-удын зорилтот түвшинд бол 107 сум дээр 422 төрлийн техник шинэчлэлтийн ажлууд хийгдчихсэн байгаа. Гэтэл 2025 оны 3 дугаар сард эрчим хүчний компаниудын 66 хувь менежментийн эрх хэрэгжүүлэх 66 хувийг “Эрчист Монгол” гэдэг компани руу шилжүүлж Засгийн газрын тогтоол гарсан. Эрчим хүчний яам энэ дээр бол нөхцөл байдлыг тайлбарлаж хэлсэн хэдий боловчиг ийм шийдвэр гараад манай эрчим хүчний салбар одоогийн байдлаар бараг 4 толгойтой болсон. Эрчим хүчний реформын Үндэсний хороо, Энхцэцэг

гишүүнтэй ахлуулсан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг Их Хурал дээр бий. Одон “Эрчист Монгол” гэж компани болсон. Түүнээс гадна Эрчим хүчний яам гэдэг ийм юунд төвөгтэй нөхцөл байдалд бид нар байна.

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайдад нэмж хариулах боломж өгье 5 номерын микрофон.

Б.Чойжилсүрэн: Одоо энэ Эрчим хүчний компаниудын хувьцааны менежментийн эрхийг хэрэгжүүлэх “Эрчист Монгол” компани ямар бодлого, ямар менежмент хэрэгжүүлэхийг би урьдчилан таамаглаж хэлэхгүй байгаа учраас яг энэ 1 эзэмшигчээс нөгөө эзэмшигч рүү хэлж байгаа төвөгтэй цаг үе учраас олон нийтэд буруу мэдээлэл, горьдлого үүсгэхгүйн тулд хэдхэн хоногийн дараа энэ “Эрчист Монгол” компани та бүхэнд уулзаж мэдээллийг хүргэх болов уу гэж бодож байна.

С.Ганбаатар: Ингээд Чойжилсүрэн сайдын мэдээллээс бас энэ нөхцөл байдлууд дээр бид бас яг дэмжиж хамтарч ажиллана. Асуудлыг бас ойлгож байгаа. Ингээд Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Энэ өдрийн мэнд хүргэе. Танилцуулга хийж байгаад баярлалаа. Тэгээд энэ танилцуулгын маань нэр цахилгаан, дулааны эрчим хүчний үнийн өсөлт болоод үр дагавар гэж эхэлж байгаа. Тэгээд энэ үр дагавар нийгэм болоод ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд хэрхэн тусаж байгааг илүү дэлгэрүүлж мэдээлэл өгөх боломжтой юу гэдгийг тодруулмаар байна. Та бүхэн мэдэж байгаа манай эдийн засаг хүнд байна, ард иргэдийн амьдрал хэцүү байгаа, аж ахуйн нэгжүүд ч хүнд байдалтай байгаа. Тэгэхээр энэ цахилгааны өсөлт тодорхой хэмжээгээр ард иргэдэд төдийгүй аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дарамт учруулж байгаа гэдгийг бид нар мэдэж байгаа. Бид нар энэ эрчим хүчнийхээ салбарыг аврахын тулд Засгийн газартайгаа Их Хурал нь нийлж байгаад ард иргэд, аж ахуйн нэгжүүд дээрээ энэ ачааллыг үүрүүлсэн. Бид ард иргэд, аж ахуйн нэгжүүддээ талархаад барахгүй байх ёстой гэж би боддог юм.

Үүнтэй холбоотойгоор энэ үр дагаврын тухай асуудал нийгэмд ард иргэд, аж ахуйн нэгжид хэрхэн нөлөөлж байгаа талаарх илүү дэлгэрэнгүй нарийвчилсан судалгаа бий юу, эс үгүй бол цаашид гаргах уу гэдгийг тодруулмаар байна. Айл өрхийн хөнгөлөлт байгаа энэ яг хэдэн айл өрх ямар хөнгөлөлтөд хамрагдаж байгаа вэ гэсэн тоон мэдээлэл энэ дээр бас байхгүй байгаад байна. Энэ тоон мэдээллийг бас өгвөл зүгээр байгаад байна. Манай энэ амьжиргааны нөхцөл байдал үүсээд байгаа эдийн засгийн асуудалтай холбоотойгоор нэлээд хүнд эмзэг байдаг. Дундаж давхаргад байгаа айл өрхүүд жаахан юм нэмэгдэхэд үнэ, юмны үнэ нэмэгдэхэд ядуурлын давхарга руу орчихдог. Ядуурлын давхаргад байгаа айл өрхүүд мөн ялгаагүй нэн ядуу руу орчихдог. Тэгэхээр энэ цахилгаан дулааны үнэ өссөн явдал маань Монголын ард иргэдийн ядуурлын түвшнийг нэмэхэд ямар нэгэн байдлаар нөхцөл боломж, нөхцөл байдлыг үүсгэсэн үү ийм асуудлууд гарсан уу гэдэг нарийвчилсан судалгаа байгаа эсэхийг тодруулах гэсэн юм. Баярлалаа.

С.Ганбаатар: 5 номерын микрофонд Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Үр дагаврын талаар мэдээж шийдвэр гаргахын өмнө бид нар судалгаа хийж таарна. Цахилгаан эрчим хүчний үнийг нэмэгдүүлээд дулаантайг нь цуг нэмэгдүүлэхэд шүү. Хэрвээ бид нар анх төлөвлөж байснаараа тооцоо гэхэд Монгол Улсад инфляц боддог 2

байгууллага бий. Монголбанк, Статистикийн ерөнхий газар. Хоёуланд нь энэ асуудлаар судалгаа хийсэн инфляцын тооцоолол хийж үзсэн. Нийтдээ 2024 оны төгсгөл 2025 он, 2026 оны эхний хагас гэхэд нийтдээ 2.4 хувийн инфляцыг нэмэгдүүлэх ийм нөлөө үзүүлэх юм байна гэдэг ийм судалгаа гарсан.

Тэгэхээр 2.4 хувийн мэдээж ийм инфляц өсөхөд бол тодорхой хэмжээний хүндрэл үүсэж байгаа нь тодорхой. Ер нь бол бид нар Засгийн газар энийгээ ярихдаа инфляцыг ямар ч байсан 2 оронтой тоонд бариад алдчихгүйн тулд одоо сая тэр эрчим хүчээ шинэчлээд дунд нь очоод зогсчихоод хойшлуулчихаад байна шүү дээ. Дулааны үнийг нэмэгдүүлж чадахгүй гэх мэт ийм асуудлууд бий. Зүгээр ингээд ард түмэндээ яриад олон жил, сүүлийн нэн ялангуяа 90 оноос хойших ардчиллын 35 жилийн хугацаанд олон нийтэд таалагдах гэж энэ цахилгаан, дулааны үнийг улс даяар үнэ биш тариф болгож мөрдүүлээд зардал нь зах зээлийн бодит өртгөөр гарснаас шалтгаалаад 30 хэдэн жилийн хугацаанд алдагдал яваад ирсэн ийм л салбар байгаа юм. Одоо 90 оноос хойш энэ зах зээлийн нийгэмд харилцаанд шилжиж чадаагүй Монгол Улсад цөөн хэдэн салбар байгаагийн нэг нь манай эрчим хүчний салбар байна. Энэ нийгмийн даатгалын тогтолцоо, тэтгэврийн систем маань хамтын тогтолцоонд байна. Энд орчигч тээврүүд байна. Бүх төрлийн төмөр замын, автобус гээд гэх мэт ийм хуучин коммунизмаараа ч яваад байгаа юм шиг, зах зээлийн харилцаанд ч яваад байгаа юм шиг юу нь ч мэдэгдэхгүй ийм нөхцөлүүд байгаагийн нэг нь энэ.

Тийм учраас магадгүй энэ бол цаг тулсан. Цаашид энгийнээр хэлэх юм бол цахилгаантай байх уу, цахилгаангүй байх уу, тогтой байх уу, тоггүй байх уу гэдэг ийм харилцаанд тулж байгаа юм. 300квт цаг эрчим хүчний хэрэглээтэй байсан айл жишээлээд ирэх юм бол 35 мянган төгрөг 300квт цагийн хэрэглээ, хуучин үнээрээ бол 35 мянга орчим төгрөг байсан. Нэмэгдүүлсэн үнээр тооцооло гэхэд 52 мянган төгрөг болж сардаа тэр айлын хэрэглээ 18 мянга орчим төгрөгөөр нэмэгдэнэ. Бусад энэ цахилгаанаар халаалтаа шийдэж байгаа айлуудын тухайд бол арай дийлэнх өндөр л байгаа байгаа учраас бид нар сүүлд нэмж хөнгөлөлтийн түвшнийг нэмэгдүүлж өгсөн ийм л алхам болж байгаа юм. Энэ айлуудын тухай зохицуулах хороо миний дараа түшээ ярьчихаарай. Ядуурлын түвшин нэмэгдсэн үү, үгүй юу гэдэг ийм судалгаа байна. Яг энэ зөвхөн инфляц болон бусад орлого, зарлагын зөрүүнээс шалтгаалж ядуурлын түвшин яригдах байх өрхүүдийн орлого зарлагын түвшин.../минут дуусав./

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайдад нэмэлт 1 минут өгье.

Б.Чойжилсүрэн: Бум-Очир гишүүн ээ энэ зөвхөн инфляцаас шалтгаалаад орлого, зарлагын түвшин өөрчлөлт, ядуурлын түвшнийг ярих юм бол том сэдэв. Зөвхөн энэ цахилгааны үнийн өсөлтөөс нь шалтгаалаад энэ дотроо хэдэн хувь гарах вэ гэдгийг бид нар энэ улирал улирлын төгсгөлд Статистикийн ерөнхий газар энэ тооцооллуудыг гаргадаг. Магадгүй жилийн дараа гэхэд 2025 оны төгсгөл 3, 4 дүгээр улирал гэхэд ямар хэмжээний ядуурлын түвшин нэмэгдсэн юм болов гэдэг ийм асуудлууд гарна. Гэхдээ нэг зүйлийг тэмдэглэхэд зөвхөн эрчим хүчний үнийн өсөлтөөс шалтгаалаад ядуурал нэмэгдлээ гэдэг дэндүү өрөөсгөл ойлголт гэдгийг хэлье. Баярлалаа.

С.Ганбаатар: Ингээд Доржзодовын Энхтуяа гишүүн асууна.

Д.Энхтуяа: Маш тодорхой мэдээлэл хүрээс авч хүргүүлсэн Эрчим хүчний яамныхандаа талархал илэрхийлье. Тэгэхээр эрчим хүчний сал салбар бол шинэ

эх үүсвэр шаардсан бас маш их эрсдэлтэй тэгээд шинэчлэл өөрчлөлт хийх ийм салбар учраас энэ хамтарсан Засгийн газар дээр бол бас нэлээн ач холбогдол өгч энэ эрчим хүчний реформ хийх ийм шийдвэр гарсан байгаа. Ингээд эрчим хүчний реформын хамгийн эхний арга хэмжээ бол үнэ тарифыг өөрчлөх, нэмэгдүүлэх гэсэн ийм арга хэмжээ байсан. Багагүй хугацаа өнгөрлөө. Олон ч бас хүндрэл, бэрхшээлтэй та бүхэн маань тулж байна. Ингээд энэ тариф өөрчлөгдөхөд эрчим хүчний салбар маань 400-гаад тэрбум төгрөгийн өр төлөлттэй явж байна гэсэн ийм мэдээллийг тухайн үед өгч байсан. Ингээд үнийн тариф өөрчлөгдсөнөөр хэчнээн хөрөнгө, хэчнээн түүний хөрөнгө мөнгө хуримтлагдав? Та бүхэн энэ хуримтлагдсан хөрөнгө мөнгөөрөө ямар ямар асуудлуудаа шийдэж байна вэ? Сая таны бас танилцуулгад бас гарлаа эрчим хүчний салбарын ажилчдын цалин хөлсний асуудлыг нэмсэн байна, өр төлбөрөөсөө бас барагдуулсан байх. Илүү гарсан ийм хөрөнгө мөнгө байна уу? Энийг салбарын энэ технологийн шинэчлэлд хөрөнгө оруулж чадаж байна уу? ДЦС 3, 4 дүгээр цахилгаан станц бол маш хуучирсан 30-60 жилийн насжилттай. Ер нь өвлийн эд ачааллын үед та ч өөрөө бас мэдээлэл өгдөг. Ерөнхийдөө бас зогсоход бэлэн байна гэсэн ийм мэдээллийг өгдөг. Тэгэхээр өвөлд бэлтгэх хуримтлагдсан хөрөнгө мөнгөөрөө энэ цахилгаан станцуудынхаа шинэчлэл, өөрчлөлт, технологийн шинэчлэлийг хийгдэх дээр ямар арга хэмжээ авч байгаа вэ гэсэн нэгдүгээр асуулт байна.

Хоёрт нь манай энэ эрчим хүчний салбарт энэ сэргээгдэх эрчим хүчний асуудал нэлээн яригдаж байгаа. Тэгэхээр одоо сэргээгдэх эрчим хүчин дээр бол хөрөнгө оруулалт нэлээн орж ирж байна гэж ингэж хэлж байна. Тэгэхээр эрчим хүчний реформ дээр ч гэсэн ер нь Доржханд сайдаар ахлуулсан энэ сэргээгдэх эрчим хүчин дээр хөрөнгө оруулалт нэлээн их орж ирж байна гэсэн ийм мэдээллүүд байж байна. Тэгэхээр бодит байдал дээр ер нь ямаршуухан байна вэ? Одоо бол сэргээгдэх эрчим хүчиндээ бол 10 хувьтай байгаа байх. 2030 онд та бүхэн 20 хувь хүргэнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Тийм учраас энэ 5 жилийн хугацаанд энэ 20 хүрэх ийм боломж бололцоо нөхцөл таны хувьд ямар хараг харагдаж байна гэсэн ийм асуулт байна.

Гуравт нь ер нь бол сая та бас ер нь хэлчихлээ. Эрчим хүчний үндэсний хороо, Реформын үндэсний хороо байгаа. Эрчим хүчний яам бол бодлого шийдвэрээ гаргаад явдаг. Дээрээс нь “Эрчист Монгол” гээд энэ компани байгуулагдчихлаа. Тэгэхээр ерөнхийдөө маш олон толгойтой болчихлоо гээд тэгж байна. Тэгэхээр энэ үндэсний аюулгүй байдлын хэмжээнд яригдах эрчим хүчний энэ салбар маань ингээд үл ойлголцолтой 2, 3 толгойтой ингээд явах юм бол энэ 2024-28 оны энэ Засгийн газрын бид нарын хамгийн том бас реформ өөрчлөлт хийх энэ эрчим хүчний салбар чинь өөрчлөгдөж чадах юм уу? Та бас энэ бодлогыг бай.../минут дуусав./

С.Ганбаатар: Доржзодовын Энхтуяа гишүүн асуулт асуулаа. 5 номерт Чойжилсүрэн сайд хариулт өгнө.

Б.Чойжилсүрэн: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Эхний ээлжид асуултад хариулахын өмнө Энхтуяа гишүүнд бас талархал илэрхийлье. Эрчим хүчний үндэсний хорооны гишүүн байгаа. Энэ нөхцөл байдлыг газар дээр нь явж аягүй их уухгүй явж нөхцөл байдалтай танилцсан. Энэ нөгөө талаас бол эрчим хүчний үнэ тарифыг нэмэгдүүллээ гэж сая Энхтуяа гишүүн ярьж байна. Нэмэгдүүлээгүй үнэ тарифт нь ойртуулах арга хэмжээ авсан шүү дээ та бид нар өртөгт нь. Өртгөөсөө дандаа алдагдалтай байсан учраас өртөгт нь ойртуулах тухай алдагдлыг бууруулах тухай ярьсан болохоос биш үнэ тарифыг нэмэгдүүлээд

айхтар гийгүүлчихсэн юм бид нар хийж чадаагүй. Энийгээ бид нар бас хүлээн зөвшөөрнө.

Энэ тарифын өртөгт нь ойртуулснаас шалтгаалаад 2024 оны 5 сарын 16, 11 сарын 15-наас хойш нийтдээ 546.1 тэрбум төгрөгийн нэмэлт орлого орж ирэхээр байгаа юм. Энийг юу юунд зарцуулсан бэ гэдэг талаар бид нар олон нийтэд болон танилцуулах ёстой. Хэрвээ Эрчим хүчний яам энэ ТӨК-удын менежментийн эрхийг хэрэгжүүлээд явсан бол бид нар энэ 5 сардаа багтаагаад танилцуулах ийм төлөвлөгөөтэй байсан. Энэ маань үл ойлгох нөхцөл байдалд төвөгтэй нөхцөл байдалд орсон. Одоо шинэ тэр менежментийн эрхийг хэрэгжүүлэгч “Эрчист Монгол” компанийг олон нийтэд танилцуулах байлгүй дээ гэж би найдаж байгаа юм. Нэг.

Шинэ эх үүсвэрүүдээс энэ ОХУ-ын улсын импортын эрчим хүчний импортын зөрүү өнгөрсөн жилтэй харьцуулахад энэ жил нэмэгдсэн 108.3 тэрбум төгрөгийг импортын үнийн өсөлтөд зарцуулагдахаар байгаа. Нүүрсний уурхай төмөр замын тээврүүд дээр нүүрсний үнүүд дээр бол 102.5 тэрбум төгрөгийг тариф дээр нэмж өгсөн.

Гуравдугаарт 2025 оны 4 сарын 1-нээс эрчим хүчний салбарын ажиллагсдын ТӨК-ийн цалинг нэмэгдүүлэхэд бид нар 229.8 тэрбум төгрөг нэмэгдэхээр байсан. Гэхдээ 2023, 2024 онуудад эх үүсвэр багатай байхад гарцаагүй энэ салбарын ажиллагсдыг тогтоон барихын тулд эх үүсвэргүй нэмсэн байсан зардлууд нэмэгдээд нийтдээ 229.8 тэрбум төгрөгийг энэ цалингийн нэмэлт нь нэмэхгүй бол манай салбараас ажлаас гарах үзэгдэл бол хэт өндөр байсан учраас ийм зүйлийг яасан.

Тэр 107 сум дээр 428 ажил дээр засвар шинэчлэлийн төлбөрт 77.1 тэрбум төгрөг зарцуулахаар байсан. Энэ маань харамсалтай нь буцаад татагдах ийм нөхцөл байдал үүсэж байна. Баруун бүсийн эрчим хүчний систем Алтай-Улиастайн эрчим хүчний систем улсын төсвийн татаастай явж байсан. Энийг Сангийн сайд татаас өгөхгүй гэсэн учраас бид нар татаасны бууралтаас дахиад 28.3 тэрбум төгрөг нэмэгдэж гарах гэх мэт ийм байдлаар 546 аравны.../минут дуусав./

С.Ганбаатар: 5 номерын микрофонд гүйцэж хариулах боломж өгье. 1 минут.

Б.Чойжилсүрэн: Ийм нөхцөл байдалд орчхоод байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Хоёрдугаарт энэ дандаа та бүхэнтэй камер авахаараа зовнил нь яриад байх төвөгтэй юм. Гэхдээ бодит байдлыг хэлэхгүй бол Монгол Улс 1 сая 500 мянган квадрат нутаг дээр 3.5-хан сая хүн сууж байна. Бусад цахилгаан эрчим хүч хэрэглэгч бусад улс орнуудтай харьцуулахад хэт сийрэг байгаа. Гарцаа байхгүй байгалийн шугамын алдагдал гэдэг юм бол үнэхээр яаж ч гүрийгээд дийлэхээргүй ийм нөхцөл байдалд байна. 200 км шугам татаад 20, 30 айл, зарим айл сумын төв дээр бол 100 айл явдаг ийм нөхцөл байдлууд байгаа гэдгийг бас хэлье. Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний систем энэ бидний амьдралын хэв загвар онцлогоос шалтгаалаад ийм өндөр алдагдалтай яваад байгааг бас та бүхэн зөвөөр ойлгох байлгүй дээ гэдгийг хэлье.

Тэгэхгүйгээр бид нар чинь дандаа их гоё юм байгаа юм шиг, боломжийг дараад суучхаад байгаа юм шиг хүмүүст нөхцөл байдал үнэнээр нь хэлж чадахгүй байсаар.../минут дуусав./

С.Ганбаатар: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариуллаа. Энхтуяа гишүүн тодруулна. Нэмж тодруулъя.

Д.Энхтуяа: Тийм ээ. Чойжилсүрэн сайд аа сая та хэллээ боломжийг дараад суугаад байгаа юм шиг гээд яг ийм нөхцөл байдал, ийм ойлголтууд бас яваад байдаг байхгүй юу. Тэгээд сэргээгдэх эрчим хүчин дээр олон компаниуд л зөвшөөрлөө авч чадахгүй яамны бодлого бас ийм харьцангуй байдаг гэсэн ийм гомдлууд ирээд ер нь бол Эрчим хүчний реформ дээр бас ярьж байсан. Тэгэхээр энэ боломжуудыг яагаад ингээд дараад байгаад байдаг юм бэ?

С.Ганбаатар: 5 номерын микрофонд гүйцэж хариулах боломж өгье.

Б.Чойжилсүрэн: Энхтуяа гишүүнээ анх Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль 2006 онд батлагд чихсэн юм байна. Тэр хууль дээрээ нарны цахилгаан станцаас сүлжээнд нийлүүлэх эрчим хүчний үнэ 15-19 цент, салхин цахилгаан станцаас 9.5 цент орчмоор нийлүүлнэ гээд тийм хууль хэт хийчихжээ. Бидний үеийн урьд үеийн Улсын Их Хурлын гишүүд маань. Тэгээд энэ хуулийн дагуу сүүлийн 2006 оноос хойш нийтдээ 38 тусгай зөвшөөрөл олгосон байна. Нар салхин цахилгаан станц. Үүнээс 9 цахилгаан станц нь бол эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулчихсан. Цаана нь 11 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухай яриа байдаг. 8 нарны станц нийтдээ 90 гаруй МВт-ын хүчин чадалтай, 3 салхин цахилгаан станц нь 150 МВт-ын хүчин чадалтай байх аа. Ийм байгаа юм.

Цаашид бид нар 2019 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулаад сүлжээнд сэргээгдэх эрчим хүч нийлүүлэх юм бол уралдаант сонгон шалгаруулалт, тендер зарлая гэдэг ийм хуулийн өөрчлөлт бий болчихсон. Гэтэл энэ урьд нь байгуулчихсан энэ өндөр үнэтэй сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч нар маань Эрчим хүчний яам Эрчим хүчний зохицуулах хороотой байнгын хэрүүл тэмцэл, шүүхийн маргаантай бид нар байгаа юм. Тэгээд бид нар дундын хувилбар болоод өнгөрсөн 2024 оны 4 сарын эхээр бид нар Эрчим хүчний сайдын зөвлөлийг хуралдуулаад нарны эрчим хүчийг нь тэр тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа 11 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайд нарных нь эрчим хүчийг бид нар дундын хувилбараар 10 центээр сүлжээнд холбоно.

Гэхдээ хүчин чадлынхаа 20 хувиас доошгүй батарейтай байсан тохиолдолд холбуулъя. Цахилгааных нь 9.5 цент байсныг нь 8.5 центээр салхины станцаас болон эрчим хүчийг сүлжээнд холбуулъя. Салхин цахилгаан станцыг нь хувьсах чадвар өндөр учраас 40 хувьтай тэнцэх хэмжээний батарей суурилуулъя гэдэг ийм шийдвэр гаргаад энэ 11 тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлсэн. Одоо энэ эдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дийлэнх нь бол энэ сүүлчийн бидний тавьсан шаардлагыг хүлээж аваад явж байгаа. Энэ бол шинээр цахилгаан эрчим хүчний тендер бид нар зарлаагүй байгаа. Ийм байна.

Шинээр бусад улс орнууд Узбек, Казахстан, Саудын Араб гээд ийм улс орнууд дээр бол тендерээр зарлахаар 1квт цаг эрчим хүчний үнэ 2 центээс буугаад ирчихсэн байгаа. Одоо би та бүхэнд энэ үнэндээ бол нэг зүйлийг хэлэхэд 19 центр төвийн сүлжээнд эрчим хүч нийлүүлж байгаа нарны цахилгаан станцууд байгаа. Нийт эрчим хүчний 9.2 хувийг нь нийлүүлчхээд төлбөрийнх нь 27 хувийг

авч байгаа. Сэргээгдэх эрчим хүчний компаниудын олж байгаа ашиг төвийн бүсийн эрчим хүчний алдагдал 2 ойролцоодуу тийм байгаа. Хэний баяжсан нь миний ядуурсан 2 тэнд.../минут дуусав./

С.Ганбаатар: Манай ердөө энэ ухна ишигний зовлон мэдэхгүй гэдэг шиг л юм болж байх шиг байна. Тэгээд үнэхээр Чойжилсүрэн сайдын бас хэлээд байгаа тэр нар, сарны сэргээгдэх эрчим хүчин дээр байгаа зовлон бас байгаа шүү. Тэгээд бид бол иргэдийн төлөөлөл. Иргэдийн, компаниудын асуудлыг л тэгээд л тавина. Та нар маань мэргэжлийн зүгээс бас асуудал хоорондоо ярилцаж ойлголцох энэ боломж нь өнөөдөр энэ Байнгын хороо „Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороо шүү. Ингээд тодорхой хариултуудыг авлаа.

Болдын Уянга гишүүн асуулт асууна.

Б.Уянга: Эрчим хүчний яамныхан нэлээн дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлсэнд талархал илэрхийлье. Зарим зүйлүүд дээр бас нэмэлт мэдээлэл хэрэгтэй байгаа учраас асуултуудыг асууя. Дулааны эрчим хүчний тарифыг бас шинэчлэхээр 25 оны 5 сарын 16-нд шийдвэрлээд байсныг хойшлуулсан гээд танилцуулга дээр байгаа. Тэгээд индексжүүл гэх юм байна.

Тэгэхээр энэ сая цахилгааны тарифыг шинэчилсэнтэй холбогдуулаад тодорхой хувийн өсөлт бий болно гээд тайлбарлаж байсантай адилхан яг энэ дулааны эрчим хүчний шинэчилсэн тариф хэрэгжиж эхэлснээр энэ ер нь энэ индексжүүлнэ гэдэг нь яг яаж явах юм? Мэдээж бас бодит өртөг рүүгээ л дөхүүлж байгаа байх л даа. Тэгэхээр энэ маань хэзээнээс хэрэгжиж эхлэх гээд байна? Индексжүүлэхээрээ яг яах юм? Яг энэ өвлийн энэ дулааны эрчим хүч шаардлагатай эдгээр саруудад төлбөр нь хэр нэмэгдэх вэ гэсэн ийм ийм нэмэлт мэдээллийг асууя.

Тавантолгойн дулааны цахилгаан станцын төсөл баригдах нэн шаардлагатай байсаар их олон жилийг бид нар үзсэн. Шүүх дээр энэ тендер зарлагдсантай холбоотой, оролцогчид нь маргалдсантай холбоотой асуудлууд их удаад байсан мэдээтэй байсан. Таны, танай танилцуулгаас 24 оны 12 дугаар сард шүүхээр шийдвэрлэгдсэн, асуудал нь шийдвэрлэгдсэн юм байна. Тэгэхдээ 24 оны 1 сарын 1-нээс энэ Тендерийн хууль дээр И Пи Си/ЕРС/ нөхцөл тендер зарлах боломжгүй болсонтой холбоотойгоор та манайх энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон Эрчим хүчний хуулиуд дээр нэмэлтийг оруулж ирэхээр энэ яамдаас санал аваад явж байгаа юм байна. Энэ хаврын чуулганаар батлуулах уу? Түргэвчилсэн горимоор орж ирж Их Хурал дээр танилцуулагдаж батлагдах шаардлагатай юм шиг уншигдлаа. Тэгэхээр энэ дээр танай яамны байр суурийг сонсьё.

10 аймгийн төвд ДЦС барих төслийн талаар бас дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцлаа. 2018 оноос хойш ингээд хэрэгжээд явж байгаа төсөл. Дулааны станц, дулаан дамжуулах төвийн цахилгаан хангамж цэвэр ус ариутгах татуургатай холбоотой улсын төсөв дээр 103 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай юм шиг уншигдлаа л даа. Тэгэхээр энийг хэзээ тусгуулахаар ажиллаж байгаа вэ 2026 он уу? Энэ дээр нэмэлт тайлбар авъя.

Эдгээр 10 ДЦС дээр болохоор зээлийн гэрээгээр баригдаж байгаа. Тэгэхээр яг баригдаж дууссанахаа дараа зээлийнхээ төлбөрийг төлж эхлэх юм уу, хүү нь яг ямар байх юм? Хэзээ төлөгдөж эхлэх юм бэ? Бусад асуултууд дээрээ нэмэлт

минутаа нэмж л авъя даа. Яг энэ төслийн явцын талаар мэдээллийг харахаар ер нь 2021 оноос авхуулаад баригдаад эхэлж байгаа юм байна. Нийт 10 аймгийн хамгийн сайн явцтай байгаа нь Сүхбаатар аймаг 49.93 хувьтай байна. Тэгээд яг энэ гүйцэт гүйцэтгэгч нарыг нь харахаар минутаа нэмээд авчихъя дарга.

С.Ганбаатар: Болдын Уянга гишүүнд нэмж 1 минут өгье.

Б.Уянга: Гүйцэтгэгч нарыг нь харахаар энэ Солонгос БНСУ-ын “Бьюксан инженеринг” компани туслан гүйцэтгэгчээр Монгол компаниуд байгаа юм байна. Тэгээд энэ “Бьюксан инженеринг” компанийг дампуурсан гэсэн мэдээлэл байсан. Гэхдээ дампуураагүй юм байна. 25 оны 3 сарын 4-ний өдөр өөрсдийнхөө өөрийн орны шүүхдээ дахин хөрөнгөжүүлэгч шүүхийн эрх зүйн зохицуулалт хийлгэх хүсэлтээ гаргасан байгаа юм байна. Тэгэхдээ танай яамныхантай энэ Солонгосын тал уулзах үеэр гуравдагч байгууллагыг ажиллуулах тал дээр тохиролцсон гэсэн өгүүлбэр байна. Энэ ямар утгатай юм бэ? Гуравдагч байгууллага гэдэг нь энэ “Бьюксан инженеринг” компаниас өөр компани орж ирэх гэж байгаа юм уу? Тэгээд энэ 10 аймгууд дээр Архангай аймгаас бусад дээр 43, 4 хувийн л гүйцэтгэлтэй байгаа юм байна. Энийг ер нь яаж эрчимжүүлэх вэ? Энэ дээр яамны зүгээс асуулт асууя даа.

5 номерын микрофонд Чойжилсүрэн сайд хариулна. Дамбын Батлут гишүүн, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн 2-ын нэрийг бас асуултад оруулаарай.

С.Ганбаатар: Уянга гишүүний асуултад хариулъя. Ганбаа дарга шаардлагатай дахиад 3, 4 минут нэмээд өгчхөөрэй. Их олон төрлийн асуулт асуулаа.

Эхнийх нь Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хангамжийн талаар. Бид нар өнөө өнгөрсөн Улаанбаатар хотод ТЭЦ-2, ТЭЦ-3, ТЭЦ-4 гээд гурван ДЦС бий. Амгалан дулааны станц бол зөвхөн дулаан үйлдвэрлэдэг, цахилгаан үйлдвэрлэхгүй ийм бүтэцтэй байгаа юм. Энэний 1 гега килокалори цагийнх нь өртөг, өртөг нь шүү 66 мянган төгрөг байгаа. Орон сууцын 1м2-тай-ын-ууд шилжүүлэх юм бол Улаанбаатар хотод 1м2-ын сарын төлбөр 600 төгрөг, 506 төгрөг байгаа тиймээ. 50м2-тай орон сууцыг сар халаахад НӨАТ нь ороод 27 мянган төгрөг л төлж байгаа улс. Өөрийнхөө өртгийг нь 40 хувиар л борлуулж байгаа юм. Шинээр дулааны станц барих юм бол 1м2-тай-ын сарын төлбөр 2505 төгрөг ба түүнээс дээш болно. 2005. Сэлбэ дулааны дэд станц бол 2505 төгрөг байгаа. Одоо байгаа 506 төгрөгөөс 5 дахин өндөр байгаа. Бид нар энэ 506 төгрөгийг 1012 төгрөг болгож магадгүй 200 хувь нэмлээ гэдэг шүүмжлэл гарах байх. Ийм шийдвэр гаргачихсан байж байгаад энийгээ 26 оны 1 сарын 1 хүртэл хойшлуулчихаад байгаа энэ.

Гэтэл 50м2-тай орон сууцын айл 27 мянган төгрөг төлдөг. 8 сараар нь үржүүлэхээр энэ маань ойролцоо 200 гаруй мянган төгрөг болдог. Гэр хороололд байгаа айл бол 6 тонн түлш аваад яахаар 600 мянган төгрөг болдог. 7 буудалд байгаа гэр хорооллын айл 1 халаалтын сезон 600 мянган төгрөг. Өөрийнх нь бусад галлах худалдаж авчрах энэ бусад зардлыг оруулахгүйгээр шүү. Халуун усанд 7 хоногт 1 удаа ордог юм болох юм бараг 2 сая төгрөг болох юм байна лээ 1 айлын 4 ам бүлтэй айлууд ингээд бодохоор. Энийг л хооронд нь ойртуулъя гэсэн ийм л шийдвэр гарч байгаад харамсалтай нь бид нар энийгээ гүйцээж энэ шинэчлэлийг хийж чадахгүй байгаа ийм л байдалтай байгаа юм.

Мэдээж олон нийт шүүмжилнэ дулааны үнийг. Ямар ард түмэндээ хайргүй хүн бэ, 2 дахин нэмэгдүүлэх юм байна пи па ардын дайсан гэдэг ийм юмаар цоллох байлгүй намайг. Гэхдээ энэ нөхцөл байдлыг хэн нэгэн хүн хийхгүй бол Их төвөгтэй нөхцөл байдал руу орж байна.

Ядуу хэсэг нь улам ядуу өндөр зардалтай байдаг, баян чинээлэг хэсэг нь илүү хямд зардалтай амьдардаг ийм бүтэцтэй байгаа. Бид нар энийг засах юм уу, үгүй юм уу гэдэг дээр бид нар бол Эрчим хүчний үндэсний хороо, Эрчим хүчний яам зохицуулах хороо шийдвэр гаргах байх. Гэхдээ мэдээж айхтар том шүүмжлэлийн дарамт руу орно.

С.Ганбаатар: Дахиад 3 минут өгье. Чойжилсүрэн сайдаа энэ дээр л бид ёстой цээжээ онгойтол зовлон жаргалаа ярьж авах юм шүү. Одоо гарц гаргалгаагаа.

Б.Чойжилсүрэн: Хамгийн гол нь хамгийн гол нь та бүхэн гишүүд маань ний нуугүй асуу. Нуух юм алга. Гишүүдээс нуух ямар ч боломж, бололцоогүй. Энэ өөрчлөлтийг хийх үү хийхгүй юу гэдэг энэ асуудлууд л байна. Тэгэхгүй Зайсанд байгаа 250м2-тай амьдралын боломжтой хүний дулааны төлбөрийг сумын төв дээр байгаа жирийн иргэн хөндлөн татаасаар төлж байгаа шүү. Ийм л байгаа. Энийг бид нар нуухгүй үнэнээ хэлсэн нь дээр. Одоо дахиад дулааны үнийг өртөгт нь ойртуулах арга хэмжээ авах юм бол дахиад айхтар том дарамт ирнэ. Энэ дээр гишүүд маань бас ойлгож наанатай цаанатай энэ дээр улс төр хийхгүйгээр бодит байдалтай тулахгүй бол бид нар Улаанбаатар хот нэмэгдэж ч 1 орон сууц холбогдохгүй. Ингээд л гэр хороолол байдгаараа байна. Ийм нөхцөл байдалд тэр ямар нэг байдлаар улс төржихгүйгээр та бүхнийг дэмжээч. Шаардлагатай бол би камергүйгээр та бүхэнд энд байгаа нөхцөл байдлын танилцуулгыг нэн ялангуяа миний үндсэн Байнгын хороо энэ анх Байнгын хороог байгуулаад би энэ даргаар нь томилогдож байсан энэ Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо. Та бүхэн бол улс төржихгүй асуулт асуув уу. Бид нар хариулахад бэлэн байна. Ямар нэгэн зүйл ярихгүй.

Энэ хуулиудын төслийн талаар Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа. Энэ Эрчим хүчний хуульд өөрчлөлт оруулахаар яах юм бэ гэхлээр одоо бол эрчим хүчний хуулиар хувийн компани эрчим хүчний эх үүсвэр барья гэвэл нээлттэй байгаа. Энийг бид нар тендерт өөрчлөлтөө үүсгэе гэдэг ийм өөрчлөлт оруулах гэж ирж байгаа. Ирэх, энэ долоо хоногийн 3 дахь өдрийн засгийн хуралдаанаар чадахгүй бол дараа 7 хоногийн Засгийн газрын хуралдаан дээр яамнуудаас санал аваад Улсын Их Хуралд өргөн барина. Өргөн барьсныхаа дараа Байнгын хорооны гишүүд та бүхэндээ би бас, ямар одоо 3-хан минут дотор энийг бүгдийг хуулийг тайлбарлаж болохгүй байгаа учраас жич танилцуулга хийе Ганбаа дарга. Бололцоо байвал бас цаг гаргаж өгч туслаарай.

10 аймгийн дулааны станцын тухайд Korea Экзим банк, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр явж байгаа. Хөнгөлөлттэй нөхцөлтэй 20 хэд 25 жилийн хугацаанд жилийн 1 хүртэл хувийн хүүтэй ийм төсөл байгаа. Энэ гэрээний нөхцөлөөр Солонгосын компаниудын дунд үндсэн Ерөнхий гүйцэтгэгчийн тендер зарлагдаад 2021 онд “Бьюксан инженеринг” гэдэг компани шалгарсан юм байна. Энэ компани маань харамсалтай нь дампуурлаа. Шүүхэд дампуурах хүсэлтээ өгсөн. Энэ оны энэ 5 сарын дундуур Солонгосын дампуурлын тухай хуулиар Монголын банкны Дампуурлын тухай хуультай ижил төстэй тийм хуультай юм байна. Яаж дампууруулах вэ, эрх хүлээн авч томилогдох вэ, энэ төслийг

цаашид үргэлжлүүлэх үү, үгүй юу гэдэг шийдвэрийг энэ шүүхийн шийдвэр гарах юм байна. Тэгээд Эрх хүлээн авагч БЭТ томилогдсоны дараа бид нар бол энэ төслийг энэ “Бьюксан инженеринг” гэдэг компаниар нь цааш үргэлжлүүлэх юм уу, эсвэл одоо байгаа.../минут дуусав./

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайдад нэмж хариулах боломж өгье.

Б.Чойжилсүрэн: Дахиад энэ компаниар дуусгуулах уу, эсвэл одоо байгаа төслийн явцыг үнэлүүлээд санхүүжүүлэгч болох Korea Экзим банк манай захиалагч манай яамны хооронд эсвэл гуравдагч этгээдүүдээр дуусгуулах ийм шийдвэрийг энэ Солонгост байгаа иргэний хэргийн шүүхийн шийдвэрээс хамаараад цаашид энэ төслийг хийх тухай хувь заяа шийдэгдэнэ. Уул нь бид нар 2026 оны 5 сарын 31-ний дотор 9 аймгийн дулааны станц 10 аймгийн нэртэй боловчиг Архангай тендерт зарлагдаагүй байгаа. 9 аймгийн дулааны станцыг 2026 оны 5 сарын 31-ний дотор ашиглалтад оруулна гэдэг ийм төлөвлөгөөтэй явж байсан чинь энэ төслийн ерөнхий гүйцэтгэгч “Бьюксан инженеринг” компани дампуурлын нөхцөл байдалд үүссэн нөгөө Монголын талаас туслан гүйцэтгэгч компаниуд тодорхой хэмжээний эрсдэлд орсон байгаа нь үнэн. Тэгэхдээ энэ шүүхийн шийдвэрийг харж байж бид нар ойрын хугацаанд хааш нь энэ төслийн хувьцааг яаж эргүүлэх вэ гэдэг талаар шийдвэрүүд гаргана. Гаргасан шийдвэрээ та бүхэнд эргэж танилцуулъя.

С.Ганбаатар: Ингээд тэр Солонгосын компани ер нь 9, 10 аймгийг дааруулж байна даа. Тэгээд манай төр засгийнхны л хариуцлагагүй байдал шүү дээ. Энэ тендер зарласан, дампуурсан. Тэгээд тэр шүүхийн шийдвэрийн тодорхой нөхцөл байдал 3 дахь хувилбарын тэр дэлгэрэнгүй хувилбаруудыг бас та хариултдаа тусгавал их сайн байгаа шүү. Ингээд Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Баярлалаа. Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Эрчим хүчний яамны сайд та бас олон сонгогдсон олон жил сайд хийж байгаа Монгол төрийн түшээ. Таны зүрх сэтгэл Монголынхоо төлөө бас цохилдог. Ялангуяа Монгол Улсын хөгжил болсон энэ эрчим хүчний дэд бүтцийн салбарыг хөгжүүлнэ гэж бодож бас энд байгаа Их Хурлын гишүүд таныг бас сайдаар сонгож байсан. Энэ дээрээ бас байгаа байх гэж бодож байгаа юм.

Би 2024 оны 10 сарын 30-ны өдрийн танилцуулга буюу мөн Үндэсний реформын хороо мөн дээрээс нь манай Эрчим хүчний яамны хамтарсан танилцуулга хийсэн. Эндээс 10 асуулт асуух гэсэн юм. Бүгдээрээ олуулаа байгаа болохоор бичээд авчхаарай.

Нэгт нь ногоон эрчим хүчний хэрэглээг дэмжих бодлого тодорхойлно гэсэн. Айл өрх, аж ахуйн нэгж болгон эрчим хүч үйлдвэрлэгч болох боломжийг бүрдүүлнэ гэсэн. Энэ бүрдсэн үү? Энэ дотроо 220квт-ын холбогдсон байгаа айл өрх өөрсдөө сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлээд төвийн шугамд нийлүүлэх бололцоотой юу?

Хоёрдугаарх асуулт. Хөрөнгө оруулалт ухаалаг технологийг дэмжсэн эрх зүйн орчин бий болгоно гэсэн. Энэ эрх зүйн орчных нь хуулийн төсөл юм нь хаана явж байгаа юм? Тэр дээр.

Гуравт нь гэх юм эрчим хүчний ТӨК-удын засаглалыг сайжруулж, зардлыг бууруулж, бүтцийн өөрчлөлт хийж нээлттэй ХК болгоно гэсэн. Төрийн өмчийн 24 компани байна. Компани тус бүрээр нь мэдээллийг нь авмаар байна. Хэчнээн

хэмжээний зардал бууруулсан, яаж бүтцээр, орон тооны буюу бусад хэмнэлтийг хийсэн юм? Дараа нь эрчим хүчний мега төслүүдийг хэрэгжүүлж экспортын стратегитай болно гэсэн. Энэ стратегийн бичиг баримт хаана байгаа юм? Нэг.

Хоёрт гэх юм бол эрчим хүч экспортлогч орон болно гэж дэд хэсэгт нь заасан. Хэзээ ийм орон болох вэ?

Тавт нь эрчим хүчний үнийг харьцуулсан судалгаа хийх байна уу? ОХУ, Хятад, Солонгос, Монголын харьцуулсан судалгааг айл өрхөөр нь, аж ахуйн нэгжээр сонс авчихмаар байна мэргэжлийн яамнаас бас. Тэгээд эндээс бас тодруулга дээр би асуулт асуух гээд байгаа юм.

Дараа нь олон улсын туршлагыг харахад эрчим хүчний үнийг нэмэхээсээ өмнө хууль эрх зүйн орчингоо боловсронгуй болгоод гол хийж байгаа деталь ажил энэ урьдчилсан тоолуур руу шилжиж ордог. Энд 1 удаа орох гэж оролдсон. Энэний үр дүн ямар байсан юм? Энэ дээр тайлбар авчихмаар байна.

Долоод нь Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 1квт-ын эрчим хүчний үнэ хэд вэ? Баянгийн цахилгаан эрчим хүчний станцын 1квт-ын үнэ ойролцоогоор хэдээр гарах вэ? Баянтай холбоотой Чойжилсүрэн сайдыг хамаарал бүхий гэж ярьдаг. Энэ дээр та цэг тавиад, би хамааралтай, хамааралгүй гэдгээ хэлээд өгчихмөөр байна.

Наймд нь сэргээгдэх эрчим хүчин дээр тусгай зөвшөөрөл авсан 9 аж ахуйн нэгж байна. Өнөөдөр түрүүн Чойжилсүрэн сайд бас зовлонгоо хэлээд байна. Энэ зовлонг нь та шийдээч. Сэргээгдэх эрчим хүчний салбарт чинь олон компаниуд орж ирье дэлхийн зах зээл дээр үнэ нь буурчхаад байхад оруулж ирэхгүй байгаад байгаа юм. Тэгээд ганцхан шалтгаан нь энэ гэрээгээ бид нар цуцалж чадахгүй байна, хэцүү байна гээд байдаг. Танд эрх нь байгаа. Болохгүй бол Их Хурлын гишүүд бид нар дэмжье. Энэ эрчим хүчний салбараа нээлттэй болгоё, гаднын хөнгөлөлттэй үнээр хөрөнгө оруулалтыг татаад магадгүй хувийн хэвшил орж ирээд хөнгөлөлттэй үнээр эрчим хүчээ үйлдвэрлээд төвийн шугамд нийлүүлээд реформ хийвэл хийсэн шиг хийгээд өрсөлдөөнийг нь тавьж өгөөд үнэ бууруулъя.

Дараа нь есөд нь Улаанбаатар хот дээр энэ газрын асуудал яригдаад байгаа. Газаар халах нь зөв.../минут дуусав./

С.Ганбаатар: Ганбатын Очирбат гишүүн маш чухал асуултуудыг асуулаа. Ер нь гишүүд энэ та мэдээллийг маш их уншдаг юм шүү. Ингээд маш тодорхой асуултуудад тодорхой хариулт өгнө үү. Чойжилсүрэн сайд 5 номерын микрофон.

Б.Чойжилсүрэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. Энэ Эрчим хүчний үндэсний хороо, Эрчим хүчний яам бид нар хамтарч ажиллаж байгаа. Ямар нэгэн тийм илүү ойлголцол гаргахгүйн төлөө их тэвчиж байгаа, хичээж байгаа. Зарим юман дээр бүрэн санал нийлнэ гэж юу байх вэ. Гэхдээ байр суурийг бол тодорхой хугацаан дотор нэгтгээд явж байгаа юмнууд бий. Зохицуулах Эрчим хүчний реформ үндэсний хороо талаасаа бас тооцоо судалгаагүй зарим зүйлийг оруулсан юмнууд бай байгаа нь үнэн. Гэхдээ цаг хугацаа явах тусам Эрчим хүчний зохицуулалт реформын хороо маань манай яамтай ижил байр суурь руу ойртож ирж байгаа учраас илүү нөхцөл байдалтай бодит байдалтай танилцаж байгаа учраас би дотроо их бэлгэшээж ажиллаж байгаа. Гишүүд маань анх намар эхэлж

байсныг харьцуулахад нэлээн гайгүй мэргэшээд тооцоо бодит байдал руугаа ойртож ирсэн гэдгийг бас тэмдэглэн хэлмээр байна. Нэг.

Хоёрдугаарт эрчим хүчний үйлдвэрлэгч болох, нээлттэй ХК болгох ийм шийдвэр жишээлбэл суусан. Энийг би Эрчим хүчний яам талаасаа оруулсан. Яагаад оруулсан юм бэ гэхлээр одоо саяын ярьж байсан тэр эрчим хүчний үнэ тарифыг өртөгт нь ойртуулах арга хэмжээг хийх юм бол 25, 26, 27 он гээд энэ 3 жилдээ энэ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд ямар ч байсан алдагдалтай ажиллаж байсан энэ алдагдлуудыг ямар ч байсан жоохон ч гэсэн ашигтай болгоё. Ингэхгүй бол тэр нээлттэй ХК-д хувь хүн өөрийнхөө хөрөнгийг алдагдалгүй ийм тодорхойгүй засаглал нь тодорхой бус юм руу хөрөнгө оруулж өгөхгүй байна. Тийм учраас дараагийн алхам бол хувийн компаниудын хувийн хөрөнгийг манай салбар луу татахын тулд энэ ТӨК-удын нэг хэсгийг нь мэдээж хяналтын багцыг нь бол Засагт тодорхой хугацаанд авч байгаад хувийнханд өгөөд магадгүй цаашаа энэ маань гайгүй болоод дархлаа нэмэгдэх юм бол хувийн салбарт орчихё. Төр гэж дандаа дундуур нь орж ирээд бүх юмыг үнэн гэдэг юмыг тариф болгож мөрдүүлээд энэ бул хар чулуу хадны мангаа болж сууснаас энэ зах зээлийн зарчимд нь шилжүүлэх ийм шийдвэрийг бол энэ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд 4 жилийн хугацаанд хийгээд дуусгая гэсэн ийм тооцоололтой явж байсан юм.

Гэтэл маань эрчим хүчний үнийг бид нар өртөгт нь нэмүүлж чадахгүй байгаа учраас одоо алдагдалтай зүйл дээр хөрөнгө оруулагч нар бол манай салбарын ТӨК-удын хувьцааг худалдаж авах асуудал бол төвөгтэй байна.

2026 оны төсөв боловсруулах үед, мөнгөний бодлого боловсруулах үед би бол энийг дахиад Эрчим хүчний сайдын хувьд бусад салбарынхантайгаа тэр Монголбанкных нь, Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам гэх мэт Засгийн газар дотор манай энэ эрчим хүчний салбарын өөрчлөлтийг гүйцээхэд орон зай үлдээж өгөөч. Мөнгөний бодлогын хувьд ч тэр, төсвийн орон зай дээр ч гэсэн энийгээ дэмжээд энэ социализмаараа байгаа, коммунизмаараа байгаа энэ зах зээлийн харилцаанд шилжүүлэх, энэ либералчлал гэдэг юм руу нь орхигдуулах дээр бол тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлээч 25 онд, 26 онд, 27 онд гэдэг зүйлийг үргэлжлүүлээд тавина гэдгийг.../минут дуусав./

С.Ганбаатар: Би энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хууль байгаа шүү. Би 2 дахь удаагаа 3 минутаар Чойжоо сайд маш чухал асуултууд хариулж байгаа. Зарим үед нь ер нь бид ер нь яаман дээр очиж энэ асуудал дээр бүүр дэлгэрэнгүй танилцахаас өөр аргагүй байгаа. Энэ аж үйлдвэр гэдэг дээр энэ эрчим хүчгүйгээр тооцохгүй. Ингээд 3 минутаар нэмж Чойжилсүрэн сайд нэмж хариулах боломж өгье.

Б.Чойжилсүрэн: Энэ яг Очирбат гишүүн уучлаарай таны асуултууд айхтар тийм гүн утгатай асуултууд байна. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар 3 минут энэ асуулт хариултын юунд энэ бүгдийг нь би энэ лав 30 минут шаардлагатай болчихоод байгаа учраас Ганбаа даргын саналаар та бүхэнд цаг гаргах юм бол Эрчим хүчний яам та бүхнийг хэдийд ч хүлээж авч энэ бүх нөхцөл байдлыг танилцуулахад бэлэн байгаа гэдгийг хэлье.

Тэр улс төржсөн асуулт асуулаа. Бөөрөлжүүтийн цахилгаан станцаас 1квт цаг эрчим хүчийг ямар үнээр нийлүүлж байгаа гэж? Эхний жилдээ 7 центээр нийлүүлнэ. 2 дахь жилээсээ НӨАТ-гүйгээр 8.9 5 центээр сүлжээнд нийлүүлэх ийм

гэрээ байгуулсан юм байна лээ 2016 оны 3 дугаар сард. Түүнээс хойш Төв аймгийн Баян сум дээр Хонконгийн хөрөнгө оруулалттай “Касэн” групп 660 МВт-ын цахилгаан станц бариад эхэлж байгаа. 8.4 центээр сүлжээнд нийлүүлэхээр ийм тооцоолол хийсэн. Намайг энэ цахилгаан станцын далд эзэн байна гэдэг ийм гүтгэлгийн чанартай зүйлийг бас зарим хүмүүс явуулаад байх шиг байна лээ. Чойжилсүрэн Эрчим хүчний сайд өөртөө өөрөө өөртөө тохируулж үнэ нэмэх гэж байна гэдэг ийм л санаа агуулсан юм болов уу гэж би зүгээр таамаглаад байгаа юм.

Хариуцлагатайгаар хэлье. Тэнд ямар ч миний хамаарал байхгүй гэдгийг.

С.Ганбаатар: Ганбатын Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Баярлалаа. Сайд маань бас тодорхой хариулсанд маш их баярлалаа.Одоо энэ Байнгын хороогоо ашиглаад жоохон зоригтой ажилламаар байна сайд аа. 9 компанийн чинь нэр энд байн а сэргээгдэхийн чинь. Ажил явуулахгүй гацаагаад байгаа, урт хугацааны гэрээ хийчихсэн. Тэгээд танд дэмжлэг үзүүлбэл бид нар мэргэжлийн Байнгын хороо дэмжлэг үзүүлье. Ямар нэгэн байдлаар хууль эрх зүйн хувьд ч гэдэг юм уу дэмжлэг үзүүлэх бүх чиглэлээр. Энэ 9 компани таныг бойкотлоод энэ сэргээгдэх эрчим хүчний салбарыг явуулахгүй гацаагаад байдаг бол энэ гацаанаасаа гаръя. Та түрүүн нэг гараараа болохоор дэлхий дээр болохоор сэргээгдэх эрчим хүч 04 цент байна гээд байдаг. Нөгөө гараараа болохоор энэ чинь манайх дотооддоо энэ чинь бараг 0.17 байна шүү дээ гээд ингээд байдаг. Тэгээд 0.17-г нь үзэхэд 598 төгрөгөөр 1квт эрчим хүч аваад байдаг. Алдагдлын төсвөөс өгөөд ингээд алдагдалтай гэдэг юм яваад байдаг.

Нөгөө талдаа болохоор энэ дулааны 4 дүгээр цахилгаан станц эрчим хүчээ 87 төгрөгөөр үйлдвэрлээд 3 дугаар цахилгаан станц 145 төгрөгөөр үйлдвэрлээд бай.../минут дуусав./

С.Ганбаатар: Зохицуулах хорооныхон саяын тодруулж асуусан асуултад хариулт өгнө үү. 4 номерын микрофоныг нээж өгье.

П.Товуудорж: Айл өрх бүр үйлдвэрлэгч болох тархмал эх үүсвэрийн тарифыг асуулсан. Эрчим хүчний зохицуулах хороо 2025 оны 2 сарын 5-ны тогтоолоор сэргээгдэх эрчим хүчний 220 вольтод 20квт хүртэл нарны эх үүсвэрийг өдрийн цагаар 285 төгрөгөөр өглөөний 6-аас оройны 5 цаг хүртэл, 5-аас оройны 9 хүртэл оройны оргил ачааллын цагт хэрвээ батарейтай тийм хэрэглэгч байвал 300 төгрөгөөр нийлүүлэхээр үнэ тарифыг шинэчилж баталсан байгаа. Сэргээгдэх эрчим хүчний хуулиар зохицуулах хороо жил бүр энийг батлах үүрэгтэй. Урьд нь бол 140 төгрөг 223 төгрөг байсныг ингэж баталсан.

Бусад ОХУ бүгдээрээ Хятад Ард Улсад үнэ ямар байгаа вэ гэсэн. Хятад Улсад аж ахуйн нэгжийн үнэ 9 цент, айл өрхийн үнэ 7.8 цент, Орост 9.7 цент аж ахуйн нэгж нь, айл өрх нь 6.8 цент байгаа. Манай үнэ тарифын шинэчлэлээс өмнө бол Монголд аж ахуйн нэгжийн үнэ 7.3 цент, айл өрх 4.1 цент байсан бол саяын тарифын өөрчлөлтийн дараа аж ахуйн нэгж 9.2 цент, айл өрх 6.3 цент болсон байгаа.

Ерөнхийдөө аж ахуйн нэгжийн түвшинд ойролцоо түвшинд айл өрхийн ахуй хэрэглээ бол доогуур түвшинд байгаа.

С.Ганбаатар: Очирбат гишүүн маш их ажил хэрэгч асуултууд асуусан. Мэдээж дэлгэрүүлж хариулахад бас боломжгүй байгаа учраас одоо Байнгын хороо бүрэн бүрэлдэхүүнээрээ Эрчим хүчний яаман дээр болон холбогдох тэр байгууллагууд дээрээ цуглуулж бас ажил хэргийн уулзалт, мэдээлэл авах гарц гаргалгаа гаргах талаар ажиллана.

Ингээд Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. 3 асуулт байна. Эрчим хүч хүчний систем ер нь зардлаа бууруулах чиглэлээр юу хийж байгаа юм бэ? Нэгжийн өртөг нь өндөр байна гээд ингээд үнээ нэмчихлээ. Нөгөө талдаа өртөг бууруулахын тулд ямар ажлууд хийж байна вэ? Эрчим хүчний зохицуулах зөвлөл үнэ тогтоодог эрх бүхий субъект нь байгаагийн хувьд яг ижил үйл ажиллагаа явуулдаг станцуудын нэгжийн өртгийг ялгаатайгаар тогтооход юуг ямар хүчин зүйл нөлөөлөөд байгаа юм бэ? 1квт цахилгаан үйлдвэрлэлээ түгээхэд хамгийн их нөлөөлж байгаа зардал нь юу байгаа юм? Тодорхой хариулт өгчих.

Хоёрдугаарт, сэргээгдэх эрчим хүчний нэгжийн өртөг ингээд харьцуулахаар уламжлалт аргаар үйлдвэрлэж байгаа эрчим хүчний нэгжийн өртөгтэй харьцуулахаар хэд дахин өндөр үнэтэй болоод байдаг. Ер нь энэ сэргээгдэх эрчим хүчнээс нийт эрчим хүчний эх үүсвэрийн хэдэн хувийг хангаад, нийт зардлын хэдэн хувийг нь сэргээгдэх эрчим хүчинд өгөөд байгаа юм бэ? Тодорхой тоо хэлээч.

Гуравдугаарт сайд маань сая хэллээ эрчим хүчний системд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана гэж. Өнөөдөр яг эрчим хүчний системийн ийм нөхцөл байдал ийм системтэй, ийм эрх зүйн орчинтой байхад ер нь хөрөнгө оруулалт хийх хувийн хэвшил олдох болов уу? Би ганцхан жишээ хэлье. Эрдэнэт үйлдвэрийн ДЦС өнөөдөр үйлдвэрлэсэн эрчим хүчээ өөрийнхөө хэрэглээнд хэрэглэж чаддаггүй. Төвийн эрчим хүчний систем рүү нийлүүлдэг нэгдсэн тогтолцоотой гэж байгаа юм. Нийлүүлж болно. Нийлүүлж. Буцааж аваад хэрэглэдэг. Гэтэл Эрчим хүчний зохицуулах зөвлөл эрчим хүчний төвийн системд нийлүүлэх үнийг нь үйлдвэрлэж байгаа өртгөөс нь бага тогтоож өгчхөөд буцаагаад зарахдаа 2 дахин өндөр үнээр зардаг. Энэ станц ер нь Эрдэнэт үйлдвэрийн харьяа байгаагүй бол одоо дампуурлаа шүү дээ. Алдагдлыг нь Эрдэнэт үйлдвэрийн ашгаас нөхөөд явж байгаа шүү дээ. Ийм байхад хувийн хэвшил эрчим хүчний системд хөрөнгө оруулалт хийх үү, эсвэл ТӨК-уддаа ингэж ханддаг юм уу? Өөрийнхөө үйлдвэрлэсэн эрчим хүчийг хэрэглэдэг болгодог энэ тогтолцоо руугаа шилжихгүй юм уу? Хэрвээ Эрдэнэт үйлдвэр өөрийнхөө үйлдвэрлэдэг эрчим хүчийг хэрэглэвэл нийт хэрэглээнийхээ 50 хувийг хангах хүчин чадалтай. Яагаад суутган тооцож болдоггүй юм? Яагаад заавал дундаас нь энэ системээс систем хөрөнгө оруулалтын өгөөжийг хүртдэг байх ёстой юм. Ийм байхад хувийн хэвшил хөрөнгө оруулах юм уу ер нь? Тодорхой хариулт өгөөч.

С.Ганбаатар: Баттогтохын Чойжилсүрэн сайд асуултад хариулъя. 5 номерын микрофоныг нээж өгье.

Б.Чойжилсүрэн: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Үүрийнтуяа гишүүн бас зөв зүйтэй асуулт ярьж байна. Өртгөө бууруулах ёстой гэж. Эрчим хүчний салбарынхан нь өртгөө бууруулахын тулд байнга л ажиллаж байгаа. Бүсийг чангалдаг гэдэг ер нь их л дөхөж байгаа. Одоо хардаад байгаа эрчим хүчний компаниуд тэр ТЭЦ-4 дээр жишээлбэл янз бүрийн том тендер явж байна,

идэж байна, ууж байна гээд ийм байгаа ТЭЦ-4-өөс яг өнөөдрийн байдлаар 1квт цаг идээд уугаад байгаа гэх юу? ТЭЦ-4 маань 92.1 төгрөгөөр 1квт цаг эрчим хүчийг нийлүүлж байгаа. ТЭЦ-3 маань 165.9 төгрөгөөр нийлүүлж байгаа 1квт цагийг. Эрдэнэт үйлдвэрийн ДЦС маань 183.4 төгрөгөөр сүлжээнд нийлүүлж байгаа. Үүрийнтуяа гишүүний тухайд бол Эрдэнэт үйлдвэрийн дэд захирал байсан хүний хувьд Эрдэнэт үйлдвэр станцыг үнэхээр энэ төрийн өмчтэй компани учраас бид нар Эрдэнэт үйлдвэрт нь ч өөрөөс нь 183 төгрөгөөр авчхаад өөрт нь 342 төгрөгөөр өгөөд байгаа байхгүй юу. Эрдэнэт үйлдвэрийн өнцгөөс харах юм бол Үүрийнтуяа гишүүнтэй санал нэгдэж болно. Гарцаа байхгүй урд хормойгоо хойд хормойгоо нөхөж байгаа учраас төрийн өмчийн оролцоотой болохлоор нь үеийн үед л намайг энд сайд болохоос ч өмнө ийм л асуудлууд яриад явж байсан. Тантай ийм нөхцөл байдал ийм байна.

Хоёр дахь асуулт хөрөнгө оруулалт хийх үү гээд. Чадан ядан бас хэдэн төслүүд явж байна. Яг өнөөдрийн байдлаар Бөөрөлжүүтийн цахилгаан станц 600 МВт-ын хүчин чадалтай, эхний 150 МВт-ыг нь ашиглалтад авсан. Энэ жил багтаад дахиад 2 дахь блок буюу 150-аас 300 дахь хүчин чадалд 2 дахь блокийг ашиглалтад авна. 27, 28 он багтаад 3, 4 дүгээр блокийг ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Энэ Монголын хувийн аж ахуйн нэгж энийг санхүүжүүлээд явж байгаа нэг төсөл.

Хоёрдугаарт нь сая ярьсан. Баян сум дээр 660 МВт-ын хүчин чадалтай ийм станц 2027 оны 6 сарын 30 гэхэд эхний блокоо сүлжээнд холбохоор явж байна.

Гурав дахь нь Сэлэнгэ аймгийн төв дээр 70 МВт-ын хүчин чадалтай Read Mongolia гэдэг компани цахилгаан станц бариад явж байна.

Дөрөв дэх нь Тосонцэнгэл сум дээр Завхан аймгийн 30 МВт-ын хүчин чадалтай ДЦС-ын 22 МВт-ын хүчин чадалтай эхний блоkyг ашиглалтад ороод явж байгаа. Үүнээс гадна нүүрсний эх үүсвэрүүд энэ Шивээговь суман дээр, Говьсүмбэр аймгийн Шивээговь суман дээр дахиад 660 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц 8.4 центээр сүлжээ нийлүүлэхээр бид нартай гэрээ байгуулахаар хөрөнгө оруулагчийг бид нар оруулбал явж байгаа ийм аж ахуйд бий.

Түүнээс гадна Эрдэнэт хот дээр 200 МВт-ын гаргалгаатай 4 цаг ажиллах 800 МВт-ын хүчин чадалтай батареи станцыг сүлжээнд холбуулна. Гэхдээ бид нар энэ батареигаа нарны станцаар өөрсдөө холбоно. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар бол тендер зарлах ёстой. Гэхдээ батареинд нь холбоод бид нар зөвхөн батареинаас нь авна. 9.5 центээр сүлжээнд нийлүүлэхээр ийм гэрээ хийгдэж байна Эрдэнэт дээр.

Дундговийн Мандалговь дээр 100 МВт-ын хүчин чадалтай 4 цагийн гаргалгаатай, Өвөрхангай Арвайхээр дээр 100 МВт-ын хүчин чадалтай 4 цаг гарахаар батареинаас нь 9.5 центээр нийлүүлэхээр ийм ажлууд хийгдээд явж байгаа. Ерөнхийдөө энэ төслүүд хэрэгжчих юм бол би арай жаахан яарч байх шиг байна энэ 25-26 оны өвөл тэр жоохон чадлын дутагдалд орж магадгүй, эс бөгөөс түүнээс цааш бид нар ингээд урьд нь би та нарт 3, 4 сарын өмнө бол 2026-27 оны өвөл чадлын дутагдлаас гарна гэж ярьсан бол бид нар наад талд нь 1 жил нааш татуулахаар ийм бололцоо бүрд.../минут дуусав./

С.Ганбаатар: Тодруулах уу? Нэг дэх, хоёр дахь асуултаа бас дутуу хариулсан байна. Тэрийгээ гүйцээгээд хариулаарай. 5 номерын микрофоныг нээж өгье. Буяагийн Тулга гишүүнийг бас асуултад оруулаарай.

Б.Чойжилсүрэн: Зардлаа бууруулах чиглэлээр бол мэдээж олон ажил хийж байгаа. Гэхдээ та бүхэн зөв ойлгоорой. ТЭЦ-3 1960-аад оны дундуур, ТЭЦ-4 1984 оны ашиглалтад орсон. Өнгөрсөн зууны үед орсон технологи хуучирсан. Одоо ТЭЦ-4 шиг станц бол магадгүй үсрээд 250 хүн ажиллаж байгаа бол манай ТЭЦ-4 дээр 1400 орчим хүн ажиллаж байгаа нь үнэн нууцгүй. Энийг яг технологийг нь шинэчлээд ТЭЦ-4-ийг буулгаад шинээр бариад дахиад энэ орчин үед технологид шилжүүлэхэд ямар хэмжээний хөрөнгө оруулалт хэрэгтэйг шууд мэдэж байгаа учраас бид нар энэ ойрын хугацаанд бусад эх үүсвэрүүдээ ашиглалтад орсны дараа магадгүй энэ Засгийн газар, манай Засгийн газрын хугацаанд амжихгүй байх ТЭЦ-4 буулгана гэж худлаа янз бүрийн юм яриад яах вэ. Одоо үе шаттайгаар 1, 1 блокийг нь шинэчлээд орчин үеийн технологи руу шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хийгдээд явах байх гэдгийг хэлье.

Станцуудын үнийг яагаад ялгаатай тогтоогоод байна вэ гэхлээр яг л энэнээс шалтгаалаад ТЭЦ-.../минут дуусав./

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя. Тэр нь тодруулга дээр нь бас зарим юмаа гүйцээгээд хариулчхаарай.

Б.Чойжилсүрэн: Би яг тодорхой л асуулт асуугаад байгаа юм. Яах вэ ашиглалтад орсон он 20 жилээр ялгаатай байгаа. Нэгжийн өртөг 50 хувиар зөрүүтэй байгаа 2 станцын хувьд. Тэгээд яг юу нөлөөлөөд байгаа юм бэ? Би сайдаас илүү энэ дээр Эрчим хүчний зохицуулах зөвлөл үнэ тогтоохдоо эдийн засаг, үйлдвэрлэлийн бүхий л хүчин зүйлийг судалж байж үнэ тогтоож байгаа. Би илүү мэдээлэлтэй байгаа гэж бодож байна. Энэ дээр яг юу нөлөөлөөд, ямар зардал нь илүү нөлөөлөөд байгаа гэдэг дээр анализ хийсэн юм байна уу л гэж асуугаад байгаа юм.

Хоёрдугаарт сэргээгдэх эрчим хүчний асуултыг бүүр тодорхой хариулж өгөөч. Эрчим хүчний хэдэн хувийг нь үйлдвэрлээд хэдий хэмжээний зардлыг эд нар авчхаад байгаа юм бэ, нийт зардлын, нийт эх үүсвэрийн?

С.Ганбаатар: Өртгийн талаар бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт задарсан анализ байна уу л гэж тодорхой асууж байна. 5 номерын микрофонд хариулт өгье. 1 номерын микрофонд хариулт өгье. 1 номерын микрофоныг нээж өгье. Нээчихсэн байна.

Б.Эрдэнэбулган: Эрчим хүчний зохицуулах хороо Үнэ тарифын газрын дарга Эрдэнэбулган хариулъя. Төвийн бүсийн 6 ДЦС-ын 1 нь Эрдэнэт үйлдвэрийн ДЦС байгаа. 48 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай. 12 МВт-ын 4 турбинтэй. Суурилагдсан хүчин чадал бага станцын хувьд бол ашиглалтын зардал өндөр байдаг 4 дүгээр цахилгаан станцтай харьцуулбал. Жишээлбэл 4 дүгээр цахилгаан станц

С.Ганбаатар: 3, 4-ийг асууж байна шүү. Эрдэнэтийн тухай мэдээлэл хангалттай байгаа.

Б.Эрдэнэбулган: 3, 4 дүгээр цахилгаан станц ч мөн адилхан. Яг адилхан хүчин чадалтай станц биш. Мөн суурилагдсан хүчин чадал болон нэгж агрегатын хүчин чадлуудын ялга гайтай байгаа. Бид нар юуг адилхан түвшинд авч үздэг вэ гэхлээр нүүрсний үнэ, түлшний зарцуулалтын норм.

С.Ганбаатар: Их тодорхой тодорхой тоо асуусан шүү. 5 номерын микрофон Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Үүрийнтуяа гишүүн ийм юм. ТЭЦ-3, ТЭЦ-4 хоёр хоорондоо яагаад ялгаатай байна гэж та асуулаа. Жишээлбэл ТЭЦ-4-өөс бид урьд нь хэлсэн 1квт цаг эрчим хүчийг 92 төгрөгөөр, ТЭЦ-3-аас 165 төгрөгөөр нийлүүлж байгаа юм. Яагаад ялгаатай байна вэ гэхлээр энэ станц чинь 2 ондоо хүчин чадалтай. ТЭЦ-4 дээр 770 МВт-ын хүчин чадалтай арай хожуу орсон станц. ТЭЦ-3 198 МВт-ын хүчин чадалтай ийм станц 20-оод жилийн өмнө орсон. Тэгээд Эрчим хүчний зохицуулах хороо бид нар яг бодит зардлын өртгийг нь бодож байгаад түүнд нь тохирсон системд нь манай бочик гэж нэрлэдэг бид нар энэ коэффициент нь нийлүүлээд ингээд явж байгаа юм. Яаж ч гүрийгээд энэ хоёр ижил байх бололцоо байхгүй. Энэ технологийн хүчин чадлын зөрүү, технологийн ялгаанаас шалтгаалаад ийм байгаа юм. Эрдэнэт үйлдвэрийг жишээлбэл 183 төгрөг байгаа.

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүний асуултыг арай л ойлгоогүй байх шиг байна.

Б.Чойжилсүрэн: Дараа нь, Үүрийнтуяа гишүүний асуулт нь хамгийн сүүлд яг 2025 оны тухайд.

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүн асуултаа тодруулчихаад тэгээд Чойжилсүрэн сайд хариулаарай.

Д.Үүрийнтуяа: Би эхнийхээ асуултыг дахиад тодруулъя. Сайн ойлголт өгч чадахгүй байна уу, яагаад байна. Нэг л буруу яриад байна. Би энэ 2 ТЭЦ, мэдээж өөр байх нь ойлгомжтой шүү дээ. Яагаад өөр байгаа юм гэж би асуугаагүй байхгүй юу. Нэгжийн өртөгт юу нөлөөлөөд байгаа юм бэ? Нөлөөлөөд байгаа хүчин зүйлүүд чинь ийм ийм ийм үзүүлэлтүүд нөлөөлөөд байна. Хамгийн их өртөгт нөлөөлөөд байгаа нь энэ үзүүлэлт нь нөлөөлөөд байна гэдэг шинжилгээ байна уу л гээд байгаа шүү дээ. Факторын анализ хийсэн үү л гэж асуугаад байгаа байхгүй юу.

С.Ганбаатар: Их л тодорхой асуух юм даа. 5 номерын микрофон Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Нэгжийн өртөгт юу нөлөөлөөд байна вэ гэхлээр зуух турбин гээд технологийн ашигт үйлийн коэффициент гэж бий. Одоо манай ТЭЦ-3 дээр жишээлбэл 12 МВт-ын 4 турбин, 25 МВт-ын 4 турбин, 50 МВт-ын хэд билээ 1 турбин ингээд ажиллаж байгаа юм 198мвт. Энэний ашигт үйлийн коэффициент 20 хувь хүрэхгүй байгаа. ТЭЦ-4 дээр арай том станцууд байгаа учраас ашигт үйлийн коэффициент 25 хувь бий. Энийг супер критикал технологи руу шилжих юм бол ашигт үйлийн коэффициент 40 хувь болж байгаа юм. Энэ технологийн шийдлээсээ шалтгаалаад өртөг чинь ондоо болоод байгаа юм.

Таны түрүүн асуултад асуултад тодорхой хариулъя. Яг 2025 оны тухайд сэргээгдэх эрчим хүчнээс 10 эх үүсвэр төвийн бүсэд, 10 эх үүсвэрээс нийт цахилгаан эрчим хүчний 8.4 хувийг нийлүүлж байна.

С.Ганбаатар: Ингээд Чойжилсүрэн сайд яг мэргэжлийн энергетик шүү бас тэгээд нарийн тодорхой бас хариулна гэж бодож байна. Сая бас хариуллаа.

Лувсанжамц гишүүн асуулт асууя. Байхгүй байна.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Цахилгааны үнэ нэмсэнтэй холбоотойгоор цаашдаа төлөвлөж байгаа ажлуудтай холбоотойгоор 2 асуулт асууя. Гэр суурины өрхүүдэд дулаан алдагдал цахилгааны хэрэглээг хэмнэх талаар зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулсан гэж байна. Бодитоор хэдэн өрхөд зөвлөмж өгсөн бэ? 3 тарифтай тоолууртай өрх хэд байгаа вэ? Бид нар энэ үнийг нь нэмсэн. Гэхдээ эсрэгээрээ хэмнэх энэ заавар зөвлөгөөг эрчимтэй хийх ёстой одоо. Утааг үнэхээр бууруулъя гэж байгаа бол байшингаа дулаалаад, цахилгаанаар халааж байгаа энэ хүмүүсийгээ бид нар дэмжих ёстой. Одоо энэ намар хүртэл ямар ажил төлөвлөж байгаа, хэдэн өрхөд энэ зөвлөмжийг өгөх вэ? Өвлөөс өртөж дулаалах хэрэгтэй байгаад байгаа. Ялангуяа ийм дулаан цагаар дулаалж байж л бид нарын утааг шийдэх боломжтой. Утааг ерөөсөө дулаалахаар л шийднэ. Дээрээс нь цахилгаанаар халаана уу, газар халаана уу, сэргээгдэхээр халаана уу оршин суугчдын өөрсдийнх нь сонголт байх ёстой.

Тэгэхлээр нэгэнт үр дүн ярьж байгаа бол хэдэн өрхөд зөвлөмж өгсөн юм бэ? Утаа эхлэхээс өмнө дахиад хэдэн өрхөд зөвлөмж өгөөд хэдэн өрхийг ийм хэтэрхий их цахилгааны зардал гардгийг нь хэмнэх боломжийг нь бүрдүүлэх гэж байгаа ажлын төлөвлөгөө нь юу байна гэсэн эхний асуулт.

Хоёрдугаарх нь болохлоор. Ер нь манай төр засгийн хамгийн том үүрэг гэдэг бол тодорхой байх явдал. Тодорхойгүй байгаагаас болоод гэр суурийн газар байшин гэрээ дулаалж чаддаггүй, модоо тарьж чаддаггүй, нүхэн жорлонгоо био жорлон болгож бас өөрчилж чадахгүй байгаад байгаа юм. Төлөвлөлтийн гол зорилго гэдэг нь бол тодорхой мэдээллээр иргэдийг хангах ёстой явдал.

8 дүүрэгт 422 төрлийн техникийн шинэчлэл хийнэ гэсэн төлөвлөгөө байна. Яг бодитоор аль хороодуудад ийм шинэчлэлийн ажил хийх гэж байгаа вэ? Одоо утааг бууруулъя гээд цахилгаан халаагуурт шилжсэн боловч цахилгаан нь 380-аар ирдэггүй, 220-оор ирдэггүй тийм өрхүүд их байдаг. Тэгээд буцаагаад зуухаа оруулж ирээд галаа түлээд эхэлдэг. Яг аль хороодууд энэ 2025 оны өвөл цахилгаан тасрахгүй байх юм? Тэр хороодуудын нийтдээ хэдэн өрх байгаа юм? Энийг нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040 дээр уялдуулж өгсөн үү? Нийслэл дээр очоод асуухлаар Эрчим хүчний яам мэдээллээ өгөхгүй байна гэсэн хариулт надад тавиад байдаг. Сайдаас энэ дээр тодорхой хариулт авбал сайн байна.

С.Ганбаатар: Ганзоригийн Лувсанжамц гишүүний асуултад 5 номерын микрофонд.

Б.Чойжилсүрэн: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Гэр хорооллын айл өрхүүдийг дулаалах зөвлөмж өгье гэж. Мэдээж үе үеийн Эрчим хүчний яамнаас зөвлөмжүүдийг өгөөд ирж байсан. Түгээх сүлжээнүүдээс ч өгөөд ирж байсан. Бид нар ард түмэндээ зоригтой үнэнийг нь хэлчхэж чадахгүй байгаа юм.

Энэ сүүлийн үед энэ манай гэр хороололд барьсан монгол гэр ч тэр, хувийн орон сууцад ч тэр ямар нэгэн стандарт гэдэг юм байхгүйгээр сүүлийн Улаанбаатар хотын түүхэнд хэдэн жил 360-аад жил тийм түүхтэй байх. Ийм л юм явсан байгаа байхгүй юу. Энэнээс шалтгаалаад нэгдүгээрт хүндрэлүүд гарсан

Хоёрдугаарт дулааны үнийг хэт доогуур бариад байхлаар дулаалах сонирхолгүй болчихоод байгаа байхгүй юу. Хэт хямдхан өртөгтэй учраас. Зах зээлийн үнэд очих юм бол тэр дулаанаа үнэд ойртуулах чинь бас дулаалахын тулд хөрөнгө оруулалт хийнэ дээ. Тэрийгээ хэдэн жилд нөхөх юм бэ, урсгал зардлаа яаж хэмнэх юм гэдэг юм чинь утгагүй болчихоод байсан зах зээлийн харилцаанаас гарчхаад байсан учраас энэ өртөгт нь хүргэх тухай асуудлыг нэгдүгээрт ярьж байгаа.

Тэгэхгүй бол бараг энэ хямдхан дулаанаараа дулаалахгүй байгаад байсан нь нөгөө хэрэглэгчдээ цахилгаанаар хэрэглэж байсан нь, ашигтай байсан нь ийм нөхцөлд нуухгүй байгаа үнэ ийм байна.

Тодорхой байх хэрэгтэй гэж ярьж байна. Яг Улаанбаатар хоттой яриад Улаанбаатар хотыг би сая ярилаа Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 600 МВт-ын хүчин чадал, Баянгийн цахилгаан станцын 660мвт, сая тэр Шивээ-Овоо дээр баригдах гэж байгаа 660 МВт-ын ингэх юм бол 2 гегаватт орчим эрчим хүчний эх үүсвэр бид нар бий болж байна. Энийг Улаанбаатар хот руу авч ирэхэд Багахангай дүүрэг дээр 500 киловольтын 1 дэд станц, Ургах наран хороолол дээр 500 киловольтын 1 дэд станц, Сонгино сум дээр Баянцогт сум руу орж ирж магадгүй шүү. Төв аймаг руу нэг 500 киловольтын дэд станцаар хооронд нь холбохоор Улаанбаатар хотын 2 талд гегаваттын 1, 1 гегаваттын хүчин чадалтай цахилгаан эрчим хүчнүүд ирнэ.

Түүнээс цаашаа Улаанбаатар хот руу дахиад 220 киловольт буулгаад 110, 35 гээд ингээд хуваарилах байгууламжийг явуулахад Улаанбаатар хотод таны ахалж байгаа 240-тэй яахад эхний 2031, 2032 он хүртэл 2 тэрбум долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй гэдэг ийм тооцоо гарсан. Улаанбаатар хотын Засаг даргын орлогч Даваадалай манай яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ерэн-Өлзийгөөр хамтарсан ажлын хэсэг явж байгаа. Энэ 2 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийх шаардлагатай гэсэн энэ зорилтын эхний 1 тэрбум долларын санхүүжилтийн эх үүсвэрийг бид нар олоод хэлэлцээрийг цаашаа хөгжүүлээд явж байна. Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк сая ирж Монголд ирж уулзсан. Бид нар өнгөрсөн жилээс хойш хэлэлцэж явж байгаад энэ 2 тэрбум долларын эхний 1 тэрбум долларын санхүүжилтийг 900 саяыг нь Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, Монголын талд 100 сая долларын хөрөнгө оруулалтыг шийдсэн тохиолдолд 35 хүртэлх жилийн хугацаатай 3.2 хувийн хүүтэй жилийн юаниар анхны эргэн төлөлтөөс чөлөөлөгдөх хугацааг нь дор хаяж 5 жилээс багагүй хугацаанд байхаар ийм шийдвэрүүд явж байна. Цаана нь үлдэж байгаа манай Засгийн газрын баталгааны орон зай хүрэх юм бол үлдэж байгаа 1 тэрбум долларыг бид нар босгох бололцоо бол Эрчим хүчний яаманд байна. Бид нар чадна.

Гэхдээ энэ бүгдийг Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам энэ орон зайг бүгдийг нь эрчим хүчний салбарт өгчих үү, үгүй юү гэдэг ийм асуудлууд байгаа учраас энэ асуудлуудыг бид нар хөгжүүлээд явж байгаа. Эх үүсвэр олоод ирж чадаж байгаа ийм л байна.

Зохицуулах хороо нэмээд хэлье.

С.Ганбаатар: 4 номерын микрофонд хариулт өгье. Нэмэлт хариулт.

П.Товуудорж: Улаанбаатар ЦТС-ний 440 мянган хэрэглэгчийг ухаалаг тоолууртай хэрэгжүүлэх төсөл 2026 онд хэрэгжиж дуусахаар ингээд хэрэгжээд явж байгаа. Тэгэхээр энэ ухаалаг тоолуур дотор 2 тарифт, 3 тарифт руу шилжих сонголт нь хэрэглэгчид байгаа. Тэгээд яг хэдэн хэрэглэгч шилжсэн байна, хэдэн хэрэглэгч зөвлөгөө өгсөн байна гэдгийг танд тусад нь хариултаар өгье гэж бодож байна.

Түрүүн нь Үүрийнтуяа гишүүн асуугаад байсан энэ факторууд энэ түлшний хувийн зарцуулалт тэр 1гр дээр нь би энийг нь хэлээд өгье. ТЭЦ-2 дээр 549.4гр киловатт цаг буюу 1квт цаг эрчим хүчийг үйлдвэрлэхэд 549гр нүүрсийг зарцуулж байна гэсэн үг. ТЭЦ-3 дээр 320,3гр киловатт цаг, ТЭЦ-4 дээр 273.4гр киловатт цаг. Энэ өнгөрсөн оноос 1.5гр-аар нэмэгдсэн байна. Дарханы дулааны станц станц 432.2гр киловатт цаг. Өнгөрсөн оноос 0.2гр-аар буурсан байна. Эрдэнэтийн дулааны станц 415.2гр-аар киловатт цаг, 3.5гр-аар нэмэгдсэн байна. Эрдэнэт үйлдвэрийн ДЦС 498 аравны.../минут дуусав./

С.Ганбаатар: 4 дүгээр микрофонд минут, факторын анализ, ганцхан граммыг нь нүүрсээ л яриад байна. Өөр хүний нөөц, технологи яриарай.

П.Товуудорж: Түлшний зардал бол дийлэнх хувийг нь эзэлдэг. Даланзадгадын станц гэхэд 1364 аравны грамм киловатт цаг буюу Даланзадгадын станц 3 МВт-ын блоктор. Тэгэхээр энэ блокийн хүчин чадлын ангилал ТЭЦ-4 бол 123мвт байж байгаа дээд тал нь. Тэгэхээр энэ нэгжийн хүчин чадлын агрегатиас хамаараад цахилгаанд бол ийм байна. Дулаан дээр бол бас килограмм гекалаар тооцдог. Дулаан дээр бол ТЭЦ-2-ынх 193.5кг килограмм гекал, ТЭЦ-3-ынх 176 килограмм гекал, ТЭЦ-4-ийнх 171.5, Дарханы станц 187.5, Эрдэнэтийн станц 189.8, Эрдэнэт үйлдвэр 201 килограмм гекал, Даланзадгадын станц 238.6 килограмм гекал, Дулаан дээр бол 2023 оноос 24 онд бүгд буурсан ийм үзүүлэлттэй байна.

С.Ганбаатар: Ойлголоо. Нүүрсний орц тэр ярилаа. Тэгээд факторын анализ гээд тэр хүний нөөц, менежмент, тээвэрлэлт, өөр бусад зүйлүүд байдаг бас бичгээр өгвөл их буян болно. Баярлалаа танд. Ганзоригийн Лувсанжамц гишүүн 2 асуултдаа хариу авч чадаагүй гэж байна. Нэмж хариулах боломж өгье. 5 номерын микрофон Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороог 2023 он дуустал Эрчим хүчний сайд би толгойлж явсан юм. Гэтэл Нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах ажлыг Нийслэл хотын Засаг дарга хариуцна гэдэг ийм шийдвэр гарсан учраас Улаанбаатар хот энэ зөвлөгөөнүүдийг ярьж байгаа. Хот илүү мэдээлэл танд өгөх ёстой, өгөх болно.

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайд нэмж хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороог 2 хуваагаад Улаанбаатар хотын агаарын асуудлыг бол НЗД хариуцахаар ийм шийдвэр гараад энэ зөвлөмжүүдийг агаарын чанартай холбоотой асуудлуудыг нийслэл

Улаанбаатар хот шийднэ. Энэ мэдээллүүдийг нийслэл хариуцаад явж байгаа. Бид эрчим хүчний салбарт зүгээр нийслэлдээ тус болоод нэмэлт, мэдээллүүдийг өгөөд явж байгаа гэж ойлгож болно шүү.

3 номерын микрофонд нэмэлт хариулт өгье.

Л.Мягмардаш: Энэ эрчим хүчний үнийг 11 сараас нэмсэнтэй холбогдуулаад манай яам Эрчим хүчний зохицуулах хороо компаниудын хамтарсан ажлын хэсгийг бид бүх аймгуудад Улаанбаатар хотод зохион байгуулж ажилласан. Санал, гомдол, өргөдөл хүлээж авч, түрүүн Лувсанжамц гишүүний хэлдгээр яг жишээ нь Улаанбаатар хотын хэмжээнд бид нийтдээ 400 өргөдөл, гомдол ирсний 135 айлаар нь ороод тэр айлуудын дулаан алдагдал, цахилгааны алдагдал, хэрэглээний өсөлт үнэ төлбөрийн талаарх зөвлөмжийг яг газар дээр нь Улаанбаатар хотын 6 дүүрэгт бол өгсөн байгаа юм. Энэ ажил бол мөн бүх аймгуудад яг бүх түгээх сүлжээнүүд ажлын хэсэг гараад өргөдөл, гомдол гаргасан айл өрхөөр нь яваад ингээд гомдлыг барагдуулаад, гомдлын барагдуулалт 98 хувийн гүйцэтгэлтэй гарсан ийм дүн байгаа.

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайд 5 номерын микрофонд. Аль аль хороолол вэ гэж нарийвчилж асууж байна.

Б.Чойжилсүрэн: Мэдээж тог тасрахгүй байна гэж байхгүй Лувсанжамц гишүүнээ. Одоо бидний байгаа ганцхан эх үүсвэртэй тийм үү? Аливаа хэрэглэгчид 2 эх үүсвэртэй бид нар болоход энэ түвшинд очтол энэ 30, 40 жилийн асуудал болно. Тог бага тасрах тухай л ярина. Огт тасрахгүй байх тухай байхгүй. Яагаад гэвэл тог таслахгүй байхын тулд 2 эх үүсвэртэй байж таарна даа. Нэг талд нь үйлчилгээ хийхэд нөгөө талаас салхинд залгадаг энэ боломж үнэндээ Улаанбаатар хотын сүүлийн 30 жилийн хугацаанд энэ төлөвлөлтгүй явчихсан гэр хороолол дээр ийм бололцоо байхгүй. Тэгж худлаа ярьж ард түмнийг худлаа молигодож хэрэггүй бид нар, чадахгүй. Бага тасрах тухай ярина. Одоо та бүхэн мэдэж байгаа бид нар ирэх жилийн намрын бэлтгэл ажил, өвлийн бэлтгэл ажил хийгээд явсан. Хороодууд дээр нийслэлийн жишээлбэл, Монгол даяараа л бид нар системтэй юу зарлаж байгаад хязгаарлана, энэ хооронд засвар үйлчилгээ хийнэ гэдгээ илэн далангүй шууд ярьж байгаа. Түүнээс биш таны яриад байгаа шиг.../минут дуусав./

С.Ганбаатар: Лувсанжамц гишүүн тодруулж асууна. Энхцэцэг гишүүнийг асуултад оруулаарай.

Г.Лувсанжамц: Ерөөсөө попроод байгаа юм байхгүй сайд аа. Хаана нь тасрах юм, хаана нь тасрахгүй юм бэ гэдгийгээ бид нар тодорхой гаргаж өгөх ёстой шүү дээ. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээрээ байшингаа дулаалаад, гэрээ дулаалаад, цахилгаан халаагуурт шилжчих, энэ хэсгийг бол бид нар тэгэх юм бол тогийг нь таслахгүй гэсэн ийм тодорхой байдлыг өгөх хэрэгтэй гэдгийг л би хэлээд байгаа юм.

Нийтээрээ тасрахаа болио гээд би ерөөсөө асуудал хэлээгүй. Би сая өнөөдөр энэ талбай дээр барьж байгаа үзэсгэлэнг үзлээ л дээ Эрчим хүчний яамны танилцуулгаас бас харлаа. Улсын хэмжээний л юм байгаад байгаа болохоос биш Улаанбаатар хотод хаана, аль хороо тог тасрахгүй юм бэ гэдэг тийм төлөвлөгөө байх ёстой шүү дээ.

Хоёрдугаарх нь 440 мянган хэрэглэгчийг ухаалаг тоолуурт шилжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж байна гэж байна 26 оноос өмнө тээ? Тэрнийхээ мэдээ, тоон мэдээллийг бас гаргаж өгөхийг хүсэж байна. Тэгэхлээр энэ хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040 дээрээ бид нар энийгээ л тодорхой болгож өгөх гээд л төрийн хамгийн том үүрэг чинь тодорхой байх ёстой юм. Энийгээ л авъя гээд байгаа юм би.

С.Ганбаатар: 5 номер.

Б.Чойжилсүрэн: Лувсанжамц гишүүнээ та тодорхой асуулт тавьж байгаа учраас бид тодорхой хариулъя гээд байгаа юм. Улаанбаатар хотын гэр хороололд 2 талын эх үүсвэртэйг тог тасардаггүй болох, таны яриад байгаагаар ийм гэр хороолол үнэндээ байхгүй. Хаана? Бид нар тэгж тийм оруулаагүй улайм цайм чадахгүй юмыг би оруулмааргүй байна. Хаана? Одоо тэр урьд нь тэр гэр хорооллууд дээр юу 4квт-аар халаалтаа хийнэ гээд цахилгаан гээд. Яг бодит байдлаар 4квт-аар чинь 100м2-тай гэр хорооллын байшинг халаах хүч хүрэхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь тог тасарна даа. Ачаалал нь хүрэхгүй болохлоор тасарна шүү дээ. Тэгж тасрахгүй байна. Бид нар гоё юм таслахгүй болно гээд.

Хэрвээ тог таслахгүй гэх юм бол 2 тал оны эх үүсвэртэй. Бүүр ярих юм бол тэр хэрэглэгч дахиад генератор байж байж тог тасрахгүй болно.

С.Ганбаатар: Лувсанжамц гишүүн тодруулъя. 1 минут.

Г.Лувсанжамц: Чойжилсүрэн сайд аа би таныг ажил хийхгүй байгаа ч юм уу, эсвэл таны хийсэн ажлыг ерөөсөө үгүйсгээгүй шүү. Таны төлөвлөж байгаа энэ ажил дээр 8 дүүрэгт 422 төрлийн техникийн шинэчлэл хийнэ гэж байгаа юм. Энийг нь би байршил нь хаана юм бэ л гэж асуугаад байгаа юм. Ингээд биччихсэн байгаа зүйл чинь газрын зураг дээр, хот төлөвлөлт дээрээ уялдаж явж байх ёстой. Нийслэл дээр очоод асуухлаар Эрчим хүчний яам юу хийж байгаагаа мэдэхгүй байна гээд байгаа байхгүй юу. Тэгээд би ингээд аргаа бараад өнөөдөр Эрчим хүчний яамнаас нь асууж байгаа юм. Тог тасарна гэдгийг би ойлгож байна. Үнэ нэмсэн тодорхой хэмжээнд тасална. Гэхдээ бид нар төр өөрсдөө хаана тог тасрахгүй юм бэ гэдгийгээ энэ төлөвлөж байгаа ажлынхаа хүрээнд тэрийгээ тодорхой гаргаж өгье, Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040 дээрээ тусгаж өгөх хэрэгтэй байна гэсэн зүйлийг хэлж байгаа болохоос биш таны хэлж байгаа энэ тайлбаруудыг би бүгдийг нь ойлгож байна. Би чинь тийм тэнэг хүн биш шүү дээ. Инженер хүн.

С.Ганбаатар: 5 номерын микрофонд инженер хүний асуултад инженер хүн хариулна уу.

Б.Чойжилсүрэн: Лувсаа гишүүний асуултад нэмээд хариулъя. Би лав Монгол Улсын цахилгаан хэрэглэгч бүрийг 2 талын эх үүсвэртэй болгоход, чадвал 3 талын эх үүсвэртэй болгохоос нааш тогийг чинь таслахгүй гэж би худлаа амлахгүй. Нэг талын эх үүсвэртэй байхад нэгдүгээрт тасална гэдгийг хэлье. Засвар үйлчилгээг хийнэ гэдгийг хэлье. Нэг.

Хоёрдугаарт тэр сая таны ярьж байгаа тэр 4 суман дээр хүчдэлийн 8 дүүрэгт ороод 422 төрлийн шинэчлэлийн ажил хийнэ гэж. Хүчдэлийн уналттай болчихоод байгаа чийдэн нь улайчихаад байгаа газрууд дээр бага багаар шинэчлэлийн ажлууд хийж байж энэ эрчим хүчний үнийг өртөгт нь ойртуулах арга

хэмжээ авсан юм бол манай энэ салбараас 2, 3-хан бүтээгдэхүүнтэй. Цахилгаан эрчим хүч, дулаан тэгээд уур жоохон бий. Энэ бүтээгдэхүүнийхээ чанарыг нэмэгдүүлэхэд шүүмжлэл бага гарахын тулд байгаа эх үүсвэр 77 тэрбум төгрөгөөр энэ шинэчлэлийн ажлуудыг хийж арай жоохон багасгая гэсэн ийм шийдвэр гаргаад зорилтот түвшинд нь өнөөдөр баталчхаад байгаа юм.

Гэтэл харамсалтай нь энэ эрчим хүчний ТӨК-удын 66 хувь менежментийн эрхийг Эрчим хүчний яам өнгөрсөн сараас эхлээд хариуцахаа больсон “Эрчист Монгол” гэдэг компани гарч ирээд тэр компаниуддаа энэ асуудлуудыг ярина. Тэгээд энэ эрчим хүчний өртөгт нь ойртуулах арга хэмжээний нэг хэсэг нь зогссон. Улаанбаатар хот дулааны үнийг өртөгт нь ойртуулах ажил хийгдэж чадахгүй болж байгаа. Цахилгаан эрчим хүчний үнийг тэр шинэ эх үүсвэрүүд, валютын ханш, инфляц, импортын эрчим хүчний үнүүдээс шалтгаалсан энэ индексжүүлэх ажлыг хийж чадахгүй байгаа учраас энийг энэ “Эрчист Монгол” гэдэг компани, менежментийг хэрэгжүүлэгч компани ямар үйл ажиллагаа явуулахыг бид тэр хүмүүсийн өмнөөс урьдчилан хэлж чадахгүй байна. Тийм учраас энэ 422 арга хэмжээний хэдийг нь үлдээх юм.

С.Ганбаатар: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя. Энэний дараа харин Энхцэцэг гишүүнийг урагшаа оруулах боломж байна уу? Дараагийн хурал нь бас шахаад байгаа шүү.

Б.Пунсалмаа: Эрчим хүчний яамны мэдээлэл сонсож байна. Эрчим хүчний тогтвортой байдлыг хангахын тулд бид нар үйлдвэрлэж байгаа эрчим хүчнийхээ нөөцийг зөв хуваарилах хэрэгтэй байна. Өнөөдөр бол бид нар эрчим хүчний оргил ачааллын үед энэ эрчим хүчийг ОХУ-аас импортолж байгаа. Гэтэл оргил ачааллын бус энгийн үед бол дотооддоо үйлдвэрлэж байгаа эрчим хүч нь хэрэглээнээсээ өндөр байдаг. Энийг бид нар батарей хураагуураар хурааж авч байгаа. Энэ улсын хэмжээнд хэдий хэмжээний батарей хураагуур, энэ илүү гарч байгаа энэ эрчим хүчээ хураагаад эд ачааллын үед хэрэглэх боломж боломжоо яаж хэрэглэж байна? Хэдий хэмжээний эрчим хүчээ бид нар хурааж, хуримтлуулаад ер нь хэрэглэж байгаа вэ гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуулт нь бол энэ эрчим хүчний тогтвортой байдалд сэргээгдэх эрчим хүч маш чухал. Сэргээгдэх эрчим хүч дээр өнөөдөр амжилттай ажиллаж байгаа 9 компани байна. Энэ 9 компаниудад бол амжилттай ажиллаарай гээд компаниуд, айл өрхүүд энэ цахилгааны төлбөр дээр сэргээгдэх эрчим хүчний нэмэлт төлбөр төлдөг. Тэгэхээр энэ 9 компани дээр нэмэгдүүлээд сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэж байгаа жижиг бичил өрх айлуудын хэмжээнд, бусад эргэн тойрныхоо айл өрхүүдэд энэ эрчим хүчээ нийлүүлэх энэ ямар эрх зүйн орчин байна вэ? Энэ эрчим хүчний сайдын 2020 оны 8 сарын 14-нд 159 дүгээр тушаалаар эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх, сүлжээнд нийлүүлэх журам гэж батлагдсан юм байна. Энэ журмын хэрэгжилт өнөөдөр ямар явагдаж байгаа? Хэрвээ бид нар эрчим хүчийг, энэ сэргээгдэх эрчим хүчийг аж ахуйн нэгжүүд өрх айлууд ингээд жижиг жижгээр үйлдвэрлээд эргэн тойрондоо тараагаад ингэх юм бол энэ эрчим хүчний тогтвортой байдалд маш их хувь нэмэр оруулна гэж ингэж тооцоолж байгаа. Энэ 2 асуулт дээр хариулт авъя.

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайд хариулъя 5 номерын микрофоныг нээе.

Б.Чойжилсүрэн: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Тогтвортой эрчим хүч гэдэг ойлголт бид нар ойлгох хэрэгтэй байна. Нар, салхи гээд сэргээгдэх

эрчим хүч маань ер нь ерөнхийдөө ус муу Монголд их цөөхөн болчхоод байна шүү дээ. Эрдэнэбүрэн УЦС явж байна. Төсөл нь ингээд яваад явж байгаа. Эгийн голын УЦС-ыг хөөцөлдөж байгаа. Оросуудтай бас тодорхой хэмжээний асуудалтай байгаа учраас сэргээгдэхийн тухайд бид нар нар, салхин дээр голлоод ярих юм бол нэг асуудал бий. Нар ороод, эсвэл салхи зогсчихоор сэргээгдэх эрчим хүч маань эрчим хүч үйлдвэрлэж чадахгүй болчхоод байгаа юм. Тэгэхээр тэр үйлдвэрлэж байсан тэр үйлдвэрлэлийг хаа нэг газар нь бид нар нөөцлөх шаардлагатай болно. Хуучин одоогоос хэд 10-аад жилийн өмнө бол ОХУ-аас бид нар захиалгаа энэ тогтворжуулалтаа нөхөж авдаг байсан. Оргил ачааллын тэр ачаалал нэмэгдэх юм бол тэр сэргээгдэх зогсчихоор ОХУ-аас авах чадлаа нэмэгдүүлдэг ийм тогтолцоотой явсан. Одоо бид нар энэ батарей гэдэг зүйлийг бид нар сүүлийн үед нэлээн нэвтрүүлэх гэж оролдож байна. Яг ашиглалтад орчихсон байгаа батарей бол Сонгино дэд станц дээр 80 МВт-ын хүчин чадалтай 2.5 цаг, гаргах хүчин чадалтай 200 МВт-ын хүчин чадалтай батарей станц Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ашиглалтад орчихсон явж байна. Нэг.

Багануур дүүрэг дээр нийслэл хотын захиалгаар 50 МВт-ын хүчин чадалтай 4 цаг сүлжээнд нийлүүлэх хүчин чадалтай 2 дахь батарей явж байгаа. Завхан аймгийн Алдархаан сум дээр байна уу, төв дээр нь байгаа 5 МВт-ын хүчин чадалтай батарей өнөөдөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа юм. Сая би энэний түрүүчийн гишүүний асуултад хариулсан одоо бол 400 МВт-ын хүчин чадалтай 4 цагаас доошгүй 4 цагийн хэмжээнд гаргахаар 1600 МВт-ын хүчин чадалтай батарей станцыг 9.5 центр барихаар, өөрсдөө сэргээгдэхээсээ тэр батарейгаа цэнэглээд батарейнаасаа сүлжээ нийлүүлэх ийм хөрөнгө оруулагчийг хойшлоод энэ наадмаас өмнө ашиглалтад оруулах ийм л тооцоотой явж байгаа юм.

Түүнээс биш тэр тогтворжилтын тухай ярих юм бол сэргээгдэх эрчим хүчээр тогтвортой эрчим хүч нийлүүлнэ гэдэг ийм ойлголт байхгүй Пунсалмаа гишүүн. Эсрэгээрээ хүндэрнэ. Хэрэглээ маань нийлүүлэлт маань хувьсаад байх тусам системийн тогтвортой байдал их төвөгтэй болж байгаа. Хэрэглээ ч хувьсаж байгаа, үйлдвэрлэл нь ч хувьсаж байгаа тохиолдолд бол системийг тогтвортой барихын тулд манайх байтугай энэ хөгжингүй орны цахилгаан эрчим хүчний системүүд бол аягүй төвөгтэй байдалд үүссэн. Системийн автоматикийн хөрөнгө оруулалтын шаардлага бол 3, 4 дахин нэмэгдэж байгаа ийм л зүйл байгаа юм.

Тийм учраас энэ тогтвортой байх тухай Монгол Улсад ямар ч эрчим хүчний хэрэглэгч зөвшөөрөхгүй байна. Нар орчихоор миний цахилгаан эрчим хүчийг хязгаарла, эсвэл салхи зогсчихоор би эрчим хүч, цахилгаан эрчим хүч хэрэглэхээ больё гэдэг ийм нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэглэгч олдохгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Эрчим хүчний яамны тухайд бол эхний ээлжид бага ч гэсэн тогтвортой бага таслаад тогтвортой эрчим хүчээр хэрэглэгчийг хангах гэдэг бол тэргүүн зэргийн зорилт байна. Энийгээ хангасны дараа тэр хөгжлийн тухай дараагийн тухай тэлэлтийн тухай ярина.

С.Ганбаатар: Ингээд Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ингээд Эрчим хүчний яамнаас ирээд танилцуулга хийж байгаа юм байна. Би 2 асуултыг л асууя гэж бодож байна л даа. Нэгдүгээрт нь болохоор Монгол Улсын 2025 оны хөгжлийн хөтөлбөр дээр маш энэ хөгжлийн хөтөлбөр гэдэг бол хууль өөрөөр

хэлбэл, Улсын Их Хурлаас баталж өгсөн хууль. Энэ хуулийг хэрэгжүүлэх субъект нь Эрчим хүчний яам.

Тэгэхээр энэ хууль дээр маш товч бөгөөд тодорхой Архангай, Өвөрхангай, Баянхонгор гэсэн энэ 3 аймгийн цахилгаан хангамжийг найдваржуулахын тулд 10 МВт-ын нарны станц, 20 МВт-ын цагийн батарей станцыг суурилуулах төслийг хэрэгжүүл гэсэн ийм заалт орж ирсэн байгаа. Өнөөдөр эхний 4 сар өнгөрчхөөд байна. Та бүхэн энэ хуулийг хэрэгжүүлэхийн төлөө, энэ төслүүдийг хэрэгжүүлэхийн төлөө энэ 4 сарын хугацаанд ямар ажил хийсэн юм бэ? Орон нутгаас би энэ найдвартай ажиллагаа хангая, хаа байсан Эрдэнэтээс насжилт өндөртэй бетон тулгуураар хангагддаг, засвар хийнэ, тулгуур унана, 3 аймаг хэдэн 10 сум цахилгаангүй хөлдөх аюултай байдаг. Тэгэхээр энэ асуудлыг аймгийн орон нутгаас маш их дэмжиж байгаа гэж байгаа. Зүгээр Эрчим хүчний яамнаас яг өнөөдөр ямар байдалтай, ямар ажил хийсэн, тэгээд энэ ажлыг яг хэзээ хэрэгжүүлэх юм гэдгээ хариулаач гэсэн ийм нэг асуулт байна.

Хоёрдугаар асуулт болохоор бид ер нь цаашдаа ерөөсөө л өрсөлдөөн зах зээл рүү аажмаар явах ёстойб Яагаад чухам өрсөлдөөнт вэ? Өнөөдөр бид нар шинэ эх үүсвэр барихад тэр хэрэглэгч дээр очиж байгаа тэр тариф, тэр цахилгааны тариф, тэр дулааны тариф юун дээр үндэслэгддэг вэ? Өнөөдөр бодит өртөг, зардал, өнөөдөр тэр шинээр орж байгаа хөрөнгө оруулалт. Тэгэхээр үнэхээр тэр бодит өртөг зардал бодитой юм уу, тэрийг яаж цааш нь бууруулах вэ, үнэхээр тэр хөрөнгө оруулалт бодитой юм уу гэдгийг шалгадаг арга өнөөдөр Монголд байтугай дэлхийд байхгүй. Ганц шалгадаг арга нь ерөөсөө л өрсөлдөөн өрсөлдөөн. Тэгэхээр цаашдаа бид нар өрсөлдөөн рүү явах ёстой.

Гэтэл өрсөлдөөн рүү явахын тулд бид нар дунд оврын дор хаяж 300, 400 МВт-ын л эх үүсвэрүүд олон тооны эх үүсвэрүүд байж байж өнөөдөр өрсөлдөөн явагдана. Гэтэл та бүхэн маань 600, 700 МВт-ын том чадалтай эх үүсвэрийг 30 жилээр, өндөр тарифаар оруулах ийм гэрээнүүдийг ямар ч өрсөлдөөнгүйгээр хийгээд байна. Энэ бол улс орныхоо хөгжлийг боомилсон асуудал. Тэгэхээр энэ дээр яавал та бүхэн тэр бодлого дээрээ, бид нар зөвхөн сэргээгдэх дээр л өрсөлдөөн явуулна гэж ярьж байгаа. Гэтэл энэ шинээр орж байгаа Тавантолгой дээр гэхэд чинь бид нар бас л өрсөлдөөн явуулж байж тэрний үр дүнд тэр хөрөнгө оруулалт доошоо орох ёстой, тэр тариф доошоо орох ёстой. Яагаад гэвэл эцсийн дүндээ энэ тарифыг чинь, энэ юуг чинь л хэрэглэгч маань л төлнө. Тэгэхээр энэ дээр та бүхэн минь ямар бодлого барьж ажиллаж байгаа вэ? Энэ 2 дээр л асуултад хариулаач гэж бодож байна.

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайд 5 номерын микрофонд.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн хөтөлбөр дээр ийм заалтууд оруулсан юм байна лээ. Та гишүүнээ сонсчихгүй юм уу? Улсын Их Хурал дээр хэлэлцүүлгийн үед гишүүдийн саналаар ийм асуудлууд ордог. Архангай, Өвөрхангай, Баянхонгор дээр гээд. Сэргээгдэх хэний лоббигоор яаж орсон юм мэдэхгүй тогтворгүй эрчим хүчээр энэ дээрх 3 аймгийн цахилгаан эрчим хүчний асуудлыг шийднэ гэсэн ийм шийдвэр орсон юм байна лээ. Бид энэ асуудлыг яаж шийдэх гэж байгаа вэ гэхлээр Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудын тухайд Арвайхээр дэд станц дээр 100 МВт-ын нарны батарей станцыг барина. 4 цагийн гаргалгаатай. Магадгүй энэ чинь 100 МВт-аар биш 50 МВт-аар 8 цаг ч явж болно. Ийм байдлаар бид нар найдваржилтыг нь нэмж байгаа батарейгаар. Нарны станц бариад батарейгаа цэнэглэнэ. Тэр нь бид нарт

хамаагүй. Одоо ямар үнэ цэн мөрдөгдөж байна уу гэхлээр намайг сайд болохоос өмнө шөнийн тариф буюу 2 центээр батарейг цэнэглээд буцаагаад сүлжээнд авахдаа 15 центээр авч байсан.

Гэтэл бид нар энийг бол 9.5 центээр сүлжээнд холбуулна. Одоо 2 цент болгож буулгаж өгөхгүйгээр нарны станц бариад өөрөө батарей цэнэглэхээд өгчих өө л гэж байгаа. Салхиа барина уу, нараа барина уу хамаагүй би батарейнаас чинь авъя гэдэг ийм л шийдвэр гаргаж байгаа гэдгийг хэлье.

Өрсөлдөөн зах зээл рүү явах шаардлагатай. Бүх юмыг өрсөлдөөн зах зээл рүү шилжүүлэх гэж бид нар оролдож байгаа боловчиг яг Монголын нөхцөл байдлын суурь рейтинг, суурь эрсдэлийн хүрээнд Монголд оруулж ирээд ямар нэг байдлаар борлуулалтынхаа орлогыг тогтворжуулахгүйгээр хэн ч хөрөнгө оруулалт хийж өгөхгүй байна.

Тийм учраас тодорхой хэмжээний өртгөө нөхөөд оруулсан хөрөнгөө гаргаж авах хугацаанд нь, тодорхой хэмжээний хугацаанд Диспетчерийн үндэсний төвтэй гэрээ байгуулж сүлжээнд бид нар тогтвортой цахилгаан эрчим хүчийг худалдан авна гэдэг гэрээг хийж өгөхгүй бол ямар ч хөрөнгө оруулагч ажил явахгүй. Сүүлийн 30-аад жил шинээр станц баригдахгүй байгаа учраас ийм ажил хийгдсэн. Энийг юу гэж ойлгох юм. Ийм ажлууд хийгдээд явахаас ондоо аргагүй. Эхний ээлжид энэ өсөн нэмэгдэж байгаа жилд 12 хувиар нэмэгдэж байгаа чадлынхаа гүйцэх юм уу, эсвэл ингээд өрсөлдөөн гаргана гээд юу ч хийхгүй суугаад байх вэ гэдэг энэ сонголтын өмнө л ирээд тэр саяын нэр дурдсан цахилгаан станцуудыг цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээг хийж байгаа ийм зүйл бий. Өрсөлдөөнийг тодорхой хугацаанд хязгаарлана ондоо арга байхгүй. Уул нь өрсөлдөх ёстой. Ингээд яваад байх юм бол ерөөсөө цахилгаан станц ч нэмж ашиглалтад орохгүй суугаад байх ийм л юм. Аль өнцгөөс яаж шүүмжлэх вэ, дэмжих вэ гэдгээ та бүхэн минь өөрсдөө шийднэ биз дээ ийм л байна.

С.Ганбаатар: Хариултыг авлаа Чойжилсүрэн сайдад бас баярлалаа хүлээцтэй бас хүндэтгэлтэй хандлаа. Сая асуулт асуунгуутаа гарсан дараагийн хурал нь яаралтай байгаа гээд надаас бас хэлээд гарсан шүү. Зөвөөр ойлгоорой. Ингээд Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Сая Энхцэцэг гишүүний ярьдаг тэр хангайн бүсийн 3 аймаг дээр хөгжлийн төлөвлөгөө дээр 10 МВт-ын сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлнэ гээд орчихсон байгаа л даа. Тэгэхээр энийг яах вэ сая сайд лобби гэж байх шиг байна. Мэдэхгүй тэрийг нь сайн мэдэхгүй. Тэгэхдээ энэ та бүгдийн тараасан материал дээр Баянхонгор аймагт 10 МВт-ын цахилгаан станцын төслийн сонгон шалгаруулалтыг зарлахаар бэлтгэж байна гээд орчихсон байна. Энэ танилцуулга дээр. Нөгөө 2 аймаг нь жишээ нь алга.

Тэгтэл саяхан орон нутгаас мэдээлэл ирсэн чинь Эрчим хүчний яамнаас албан бичиг ирээд 100 МВт-ын сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх гэж байгаа гээд 300 га газар хүссэн гээд. Тэгээд аймаг Арвайхээр сумын хотын хурал хуралдаад 300 га газраа олгоод явуулсан гэж ийм мэдээлэл өгсөн. Тэгэхээр энэ аль нь үндэслэлтэй юм бэ? Яг Өвөрхангай аймагт тэр 300 га дээр 100 МВт-ын станц, сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжих юм уу? Тэр хүчин чадал юм нь 100 гэдэг чинь жигтэйхэн л өндөр юм сонсогдоод байх юм. Тийм хэрэгцээ бас энэ бүс нутагт байгаа юм уу? Тэрийг тодорхой хэлж өгөөч гэж.

Дараа нь алдарт 10 аймгийн дулааны станцын асуудлыг л бас ярих гээд байгаа юм. Тэгээд тэр аймгууд ч ерөөсөө утаа униартаа баригдаад, хүмүүсийн эрүүл мэнд, олон асуудал байна л даа. Тэгээд ямар нэгэн гарз шийдэл яримаар байгаа юм. Тэгэхгүй бол ингээд Солонгосын зээлийн асуудлыг яриад. Тэгээд би энэ зээлийг түрүүн бас Уянгаа гишүүн асуусан чинь хариулахгүй л явчих шиг болох юм. Зээлээ төлөөд эхэлсэн үү? Үндсэн зээл, мэдээж энэ зээл маань бас хэдий бага хүүтэй ч гэсэн хүүтэй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хүү нь төлөгдөж эхэлсэн үү? Бид нар чинь жишээлбэл нефтийн үйлдвэр дээр гэхэд нефтийн үйлдвэр нь ч баригдаж дуусаагүй байхад үндсэн зээлийн төлөлт эхэлчихсэн байгаа шүү дээ. Тэгэхээр энэ шиг ийм дампуурсан юм болсон юм биш биз дээ? Тэгэхээр энэ зээлийн асуудлыг тодорхой хариулж өгөөч. Уянгаа гишүүнд хариулаагүй шүү түрүүн.

Дээр нь дахиад Өвөрхангай аймагт жишээлбэл 30 МВт-ын дулааны станц баригдаж байгаа нүүрсээр ажилладаг. Тэгэхээр би энэ Солонгосын банкны зээлийг чинь бас талаас нь их гайхаад жоохон хардаад байх юм. Одоо энэ чинь дэлхий дээр станцууд, үгүй ээ том санхүүгийн байгууллагууд нүүрсний цахилгаан, дулааны станцыг санхүүжүүлэхгүй гээд байна. Эд нар маань ер маань ер нь манай станцыг санхүүжүүлэхгүй болоод л ийм арга саам хийгээд ингээд 10 жил гацаагаад байгаа юм биш биз дээ гэж хардлага төрөөд байх юм. Энэ дээр ер нь ямар байр суурьтай байдаг юм бэ?

Дараа нь болохоор дахиад Өвөрхангай аймагт баригдаж байгаа тэр 30 МВт-ын станц чинь гэхэд одоо Өвөрхангайн хэрэглээг хангаж дийлэхгүй болчихсон гэж яриад байна л даа. Өвөрхангайн яг бодит хэрэглээ 40 гаргачихсан гээд байна. Тэгэхээр.../минут дуусав./

С.Ганбаатар: 5 номерын микрофонд Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Тэр Монгол Улсыг хөгжүүлэх төлөвлөгөө дээр таны яриад байгаа Өвөрхангай, Архангай гээд сэргээгдэх эрчим хүч маань дангаараа явах юм бол нар цахилгаан станц маань тогтворгүй болчихоод байна шүү дээ Хосбаяр гишүүн ээ. Тийм учраас тэр таны яриад байгаа үнэн. Өвөрхангай аймгийн Засаг даргад бид нар хүсэлт явуулаад 300 га шийдвэрлэж авч байгаа. Тэр батареиг тогтвортой эрчим хүчинд нийлүүлэх гээд ийм асуудал хөрөнгө оруулагч азаар олоод бид нар бас олон хөрөнгө оруулагчтай уулзаад явж байсан нэг нь зөвшөөрөөд орж ирж байгаа учраас энэ ажлыг хийсэн.

Баянхонгор аймгийн тухайд бол 10 МВт-ын батареитай, 10 МВт-ын нарны станцтай ийм төсөл хэрэгжүүлэхээр төслийн сонгон шалгаруулалтын бэлтгэл ажил бид нар тендерийн бэлтгэл ажил сонгоод явж байгаа юм. Баянхонгор дээр нь шүү.

Өвөрхангай аймгийн тухайд бол тэр 30 МВт-ын хүчин чадалтай ийм төсөл тэр 10 аймгийн дулааны станцын төслийг хэрэгжүүлсэн юм байна лээ. БНСУ-ын Кореа Экзим банкны санхүүжилттэйгээр 148.7 сая долларын дүнтэй 10 аймгийн тухайд. Эхний багц нь эхний 3 багц нь 9 аймгийн тухай асуудал яригдаж байгаа. Иймэрхүү байгаа. Хүү нь жилийн 0.15 хувь хувьтай байгаа. 2028 оноос зээлийн үндсэн төлбөр төлж эхлэх ийм нөхцөлтэй зээл байгаа юм. Ийм асуудлыг бүүр 2016 онд, 14 онд би 16 онд намайг Сангийн сайд байхад Кореа Экзим банк Монгол Улсын Засгийн газар хооронд энэ хэлэлцээр явагдаж байсан. 2019 онд эцэслэн бай байгуулаад 2021 онд гэрээ, тендер зарлагдаад сонгон гүйцэтгэж шалгараад

явж байгаад харамсалтай нь энэ дампуурах байдалтай болчихсон би гэдгийг хэлье. Түрүүчийн гишүүний асуултад хариулахдаа тодорхой хариулсан учраас давтан яриад байх зүйл алга байна гэдгийг хэлье.

Өвөрхангай аймгийн тухайд бол энэ 30мвт ашиглалтад орлоо ч гэсэн цаана нь 10, магадгүй энэ хэрэглээг, ирээдүйн хэрэглээг бодох юм бол дахиад 20-30 МВт-ын ийм эх үүсвэр хэрэгтэй болж байгаа. Харамсалтай нь энийг Эрчим хүчний яам энэ эх үүсвэрийг улсын төсвийн эх үүсвэр дээр бол бид нар хүчин мөхөстөж байгаа учраас энэ тойргоос сонгогдсон гишүүд та бүхэн бас энэ дээр санал, дэмжлэг үзүүлээч. Бид нар мэдээж энэ хүсэлтийг бол Сангийн яаманд хүргүүлдэг. Улсын төсөв буугаад ирэхээр биднээс үл хамаарах байдлаар хасагдаад ороод ирдэг учраас та бүхэн дээр бас санаа тавьж хүчээ нэгтгэхэд л тэр хамтарч ажиллахад бэлэн байна гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Тодруулж асууя. Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Тэгэхээр Өвөрхангайд 100 МВт-ын тэр 300 га дээр хэрэгжих төсөл нь хэрэгжих юм байна гэж ойлгож болох уу? Тэр санхүүжилтийн төсөл хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрээ олчихсон юм байна гэж ойлголоо тээ? Тэр дулааны станцыг дуусгах ч юм уу, дахиж нэмэлт эх үүсвэр барих дээр уг нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хувийн хэвшилтэйгээ л хамтарч ажилламаар байгаа юм. Тэгээд ажиллахгүй л юм байна лээ л дээ. Таны хажууд сууж байгаа дарга бол дээр Хангайн бүсийн чуулган дээр очоод л хувийн хэвшил хийнэ гэж юу байдаг юм шахуу л юм яриад байх шиг байсан. Уг нь энэ чинь жишээ нь Өвөрхангай аймагт хэрэгжиж байгаа төсөл 50, 100 гаран тэрбумын л төсөвт өртөгтэй тийм дааж давшгүй их хөрөнгө оруулалт биш байгаа шүү дээ 11, 2 сая доллар. Өнөөдөр Өвөрхангайд байгаа 10 хэдэн уурын зуух бараг л тэр бизнест хийж байгаа хүмүүс мөнгөө нийлүүлээд л энэ чинь энгийнээр хэлэх юм бол томруулсан уурын зуух л байгаа шүү дээ. Цахилгаан гаргахгүй зөвхөн дулаан л үйлдвэрлэнэ.

Тэгэхээр ийм боломж байхад энийг ер нь яагаад ашигладаггүй юм бэ? Тэгээд л тэгээд байгаад.../минут дуусав./

С.Ганбаатар: Хосбаяр гишүүний асуулт хувийн боломж юу байгаа юм бэ гээд. Тэр Сэлэнгийн Лхагвадорж Засаг даргын бас санаачилга их сайн яваад байгаа шүү дээ тэр.

Хоёрдугаарт үгүй ер нь ийм дампуу юм, тендер зарлаж зохион байгуулалт хийсэн хүмүүс чинь ямар хэнд нь, яг яаж хариуцлага тооцсон бэ? Энэ чинь 10 аймгийн ард иргэд даарч байгаа шүү дээ. Энэний өмнөөс ямар нэгэн хариуцлага байгаа юу?

Асуултад 5 номерын микрофонд Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Энэ хариуцлагын тухай ярих ёстой. Хэзээ шалгаруулаад, яагаад ингээд бүтэлгүйтчих вэ гээд ингээд ярихаар янз бүрийн асуудал гарах нь үнэн. Та бүхэн ард талдаа сонгогчидтой энэ асуудлуудыг шийднэ гээд амлаад сонгогдсон гишүүд тухай тухайлбал та бүхэнд л тэр тойргоос сонгогдсон гишүүд асуугаад байна. Энэ тухай хариуцлагын тухай ярья. Энэ 5 сарын дундуур ингээд Солонгост гарч байгаа тэр шүүхийн шийдвэрийг хүлээгээд энийг яаж эрчимжүүлэх вэ гээд нэг талдаа гаргахгүй бол энэ байдлаараа бол дахиад энэ Засгийн газрын

бүрэн эрхийн хугацаа, Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусахад шийдэгдэхгүй байх магадлал байна.

Тийм учраас энэ тал дээр бол би тодорхой шийдвэр гаргая гээд Солонгосын Экзим банкны бүх удирдлагуудтай уулзсан. Монголоос Солонгост сууж байгаа Элчин сайд энийг хөөцөлдөж байгаа, Солонгосоос Монголд сууж байгаа Элчин сайд энийг хөөцөлдөж байгаа ийм асуудал байгаа нь үнэн. Би ийм зүйлийг ярьж гэж бодож байна.

Хувийн салбарыг хамтарч ажиллая гээд ярьж байгаа юм. Хувийн салбартай хамтарч ажиллахын төлөө л бид нар бүгдээрээ ярьдаг боловчиг үйлдэл дээрээ нэг зүйлийг хийж чадахгүй байгаа. Энийгээ илэн далангүй ярих ёстой. Хувийн салбарынхан чинь буяны байгууллагууд биш шүү дээ. Ашиг хийх гэж л энэ салбар руу орж ирвэл орж ирнэ. Тэгэхээр энэ манай энэ эрчим хүчний салбар чинь үнэ гэдэг юм чинь тариф болчихсон. Өртөг гэдэг юм зах зээлийнхээ ханшаар явчихсан. Коммунизмд байгаад байгаа юм уу, капитализмд байгаад байгаа юм уу энийгээ бид нар ялгах хэрэгтэй одоо. Энэ үнэ гэдэг юмыг нь үнэ жинхэнэ тэр шинэчлэлийг хийгээд тухай бүрд нь Эрчим хүчээ зохицуулах хороо орон нутгуудад байгаа салбар зөвлөлүүд нь тухай бүрд нь тэр зах зээлийнх нь үнэд нь ойртуулчихдаг бол хувийн салбар орж ирнэ. Энэ бодлогын шийдвэрийг хийж чадахгүй бол хувийн салбарынхан их худлаа хошхируулаад нэмэргүй. Бүр хөрөнгө оруулчихсан аягүй олон манай эрчим хүчний салбарт хувийн салбарынхан байна шүү дээ. Төрд худалдаж аваач ээ, та нар чинь энэ тариф гэдэг юмаараа бид нарыг бүгдийг нь алдагдалтай болчихлоо гээд. Сая Булган аймагт очоод ажиллахад л.../минут дуусав./

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайдын хариултыг авлаа. 5 сардаа багтааж энэ 10 аймгийг дааруулж байгаа ядрааж байгаа энэ олон зуун тэрбум төгрөгийн энэ дампуурсан тендерийг зарласан, зохион байгуулсан улс төрийн албан тушаалтан болон мэргэжлийн албан тушаалтнуудад хариуцлага тооцсоноо бичгээр 5 сард Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороонд ирүүлнэ.

Ингээд хувийн хэвшлийнхнийг орох боломжийн талаар бас сайд тодорхой ярилаа. Дамбын Батлут гишүүн асуулт асууна. Сонгобайгийн Замира гишүүнийг асуултад оруулаарай.

Д.Батлут: Чойжилсүрэн сайд бид 2 сайхан ойлголцож хамтарч бас ажилладаг ийм л хүн байгаа юм. Тэгээд 1 зүйл дээр жоохон ойлголцол тааруу байгаад байгаа юм. Тэгээд тэрийгээ би асууж гэж бодож байна. Өнөөдөр манай Монгол Улсад 1квт эрчим хүчний үйлдвэрлэж байгаа өөрийн өртөг гэдэг зүйл байна. Энэ өндөр болоход яг юу нөлөөлөөд байгаа юм бэ? Тухайлах юм бол би 2000 оноос эхтэй энэ сэргээгдэх эрчим хүчний 9 компанитай холбоотой асуудлыг хөндмөөр байна. 350 төгрөг 1квт эрчим хүчийг 350-650 төгрөгөөр төвийн нэгдсэн системд нийлүүлж байгаа энэ зардал нь Монгол Улсын нийт эрчим хүчний хэрэглээнд эргэлдэж байгаа бэлэн мөнгөний 27 хувийг аваад явчихдаг. Өгч байгаа эрчим хүчний эх үүсвэр нь 3 хувийг л хангаж байх жишээтэй. Энэ яг энэ өртөгт нөлөөлж байгаа юу? Нөлөөлж байгаа бол хэдэн хувь?

Хоёрдугаарт нь 2019 онд манай эрчим хүчний салбар 59 тэрбум, 20 онд 92, 21 онд 78 тэрбум, 22 онд 187 тэрбум, 23 онд 47 тэрбумын алдагдалтай ажилласан. 24 онд 203 тэрбумын алдагдалтай ажиллах тийм судалгаа байсан чинь 335 тэрбум болсон байна. Тэгээд энэ алдагдалтай ажиллаад байгаа зүйл чинь яг юунаас

болоод байгаа юм бэ гэж. Тэгэхээр манай энэ эрчим хүчний салбарын худалдан авалтын бодлого нь хэр зохистой зөв явж байгаа юм бэ гэдэг асуудлыг хөндөх гээд байгаа гэсэн үг. Энэ худалдан авалттай холбоотой асуудлууд нь нөлөөллийн хувьд энэ өөрийн өртөгт хэрхэн нөлөөлөөд байгаа юм бэ? Яг үнэндээ энэ эрчим хүчний реформыг хийх гэж байгаа бол бид нар бодит өртгөө зөв тооцож гаргаж ирэх хэрэгтэй гэж харж байгаа. Тэгж байж цаашлаад эрчим хүчний реформыг хийх нь илүү ард иргэдэд өгөөжтэй, нуруун дээр нь ачаалал бага үүрүүлэх тэр боломжийг бүрдүүлнэ л гэж хараад байгаа байхгүй юу. Тэгээд энэ талаар таны хийж хэрэгжүүлсэн зүйл юу байна? Энэ асуултуудад хариулж өгөөч.

Тэгээд бас энэ ташрамд нэг зүйл байгаа юм л даа. Ингээд төрийн байгууллагууд нь хөрөнгө оруулалт хийгээд эрчим хүчний найдвартай их эх үүсвэрийг бий болгох гээд явахлаар их дарамтад ордог олон жишээ байна л даа. Тухайлах юм бол манай уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ДЦС нь эрчим хүч үйлдвэрлэлээ өргөтгөсөн. 1квт эрчим хүчийг 192 төгрөгөөр үйлдвэрлээд буцаад эрчим хүчний нэгдсэн системээсээ 300 гаран төгрөгөөр худалдаж авч байгаа. Тэгээд эрчим хүчинд хөрөнгө оруулалт хийсэн биш эргээд жилдээ 10 гаруй тэрбум төгрөгийн алдагдал хүлээх нөхцөл байдал үүсчхэж байгаа юм. Тэгээд энийг ингээд бодохлоор ямар бодлого хэрэгжээд байгааг ойлгохгүй байгаад байгаа юм л даа. Энэ бүхэн дээр яаж зүй зохистой болгох юм, яаж энийг өөрчлөх юм гэдэг талаар таны бодол, санааг бас сонсмоор байгаа юм. Баярлалаа.

С.Ганбаатар: 5 номерын микрофон Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Батлут гишүүний асуултад хариулъя. Өртөг гэж юм байх ёстой. Бид нар өртгийг бол Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний яам хамтраад улирал болгон үйлдвэрлэгч болгон дээр ТӨК-удыг жишээлбэл бодож шинэчилж явж байгаа. Тэр өртөг дотор мэдээж та хэлж байгаа тэр худалдан авалтын бодлого ямар байна гэж. Худалдан авалтын бодлогыг бүгдээрээ л бид нар тендер зарлуулаад л тэр тухайн үед хамгийн хямд үнэ зарласан ийм л худалдан авалтуудыг хийж байгаа. Тендергүйгээр 1 ч худалдан авалт ТӨК-уд бол хийхгүй байгаа. Хувийн компаниудын тухай би тэгээд янз бүрийн юм яримааргүй байна. Хувийнх нь тендерээ зарлана уу, яаж зарлана уу, энийг бол бид нар төрд заахгүй. Таны яриад байгаа үнэ 2006 онд анх Сэргээгдэх эрчим хүчний хууль батлагдаад таны яриад байгаа 600 төгрөгийн үнэтэй эрчим хүч худалдан авах гэрээг хийгээд холбуулчихжээ. Яг та бид хоёртой адилхан Улсын Их Хурлын гишүүд тухайн үеийн Улсын Их Хурлын гишүүд батлаад тухайн үед энэ Улсын Их Хурал баталчихсан хуулийг Засгийн газар биелүүлж таарна. Ийм асуудал үүсчихсэн байдаг юм. Мэдэхгүйн зовлон байдаг. Би одоо бүүр тэр үеийнхэн рүүгээ хар янз бүрийн хараар будаад баймааргүй байна. Ийм л нөхцөл байдал руу орчихсон нь үнэн. Одоо би энэ юу та яриад байгаа шүү дээ. Би олон удаа ярьж байгаа. Нийт эрчим хүчний 8 аравны, өнөөдрийн байдлаар шинэчлэхээр эрчим хүчний 8.4 хувийг нийлүүлчхээд өртгийнх нь 20.7 хувийг авчхаад байгаа юм. 20.7 биш тэр чинь та би бол 23 оны юм. Одоо би 25 оныг ярих ингээд шинэчлэхээр орлогын 20.7-г авч байгаа юм. Тэр урьд нь байсан тоо бол тэр 23 оны тоо шүү. 22 оны тоо. Одоо яг шинэчлэхээр ийм байдалтай болчихоод байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Бодит өртгийг л байнга л бууруулах, мэдээж нөлөөлнө. Нөлөөлөхгүй гээд яах юм? Одоо энэ гишүүд ээ дэмжих тариф гээд л нүүрсний эх үүсвэрээс хэрэглэх цахилгаан эрчим хүчийг хэрэглэ гэж байгаа нь одоо энэ сэргээгдэх эрчим хүч нь дэмжээд л явж байгаа шүү дээ. Намайг энэ сэргээгдэх эрчим хүчийг дэмждэггүй,

үнэтэй юм сүлжээнд холбуулдаггүй гээд л я янз бүрийн байдлаар дарамтад байгаа нь үнэн. Хэвлэл мэдээллээр байдлаар ингээд Чойжилсүрэн нүүрсний лобби чинь сэргээгдэх эрчим хүч дэмжихгүй байна, хоцрогдсон гэх мэт ийм шүүмжлэлүүд явж байгаа нь үнэн. Одоо нэгэнт ийм тангараг өргөөд чадна гээд оччихоод би намайг ингээд шүүмжлээд байна, ингээд хүнд хэцүү байна гээд зовлон тоочоод байх нь утгагүй юм. Түүнээс биш ийм байдалтай байгаа нь үнэн. Та бүхэн энийг бид нар нуухгүй, хаахгүй үнэнийг хэлж байгаа ийм л юм.

Одоо энэ чинь ийм болчихоод байна шүү дээ. Одоо яг уламжлалт эх үүсвэрээс та 3 дахин өндөр үнэтэй өртгөөр нийлүүлчхээд байна шүү дээ. Та бодоо бод. ТЭЦ-4-өөс, бид нар өнөөдөр 1квт цагийг ТЭЦ-4-өөс, үгүй харин бид нар би тэрийг нь тооцож гаргасангүй. ТЭЦ-4-өөс жишээлбэл 1квт цаг эрчим хүчийг өнөөдөр 92.1 төгрөгөөр нийлүүлж байгаа. ТЭЦ-3-аас 165.9 төгрөгөөр 1квт цагийн сүлжээнд нийлүүлж байгаа нь. Эрдэнэт үйлдвэрийн дулааны станцаас 183.4 төгрөгөөр сүлжээнд нийлүүлж байгаа юм. Таныг орж ирэхээс өмнө Үүрийнтуяа гишүүн яг асуулаа. Эрдэнэт үйлдвэр хөрөнгө оруулаад одоо бид нар 183 төгрөгөөр сүлжээнд нь авчхаад Эрдэнэт үйлдвэрийн дулаан цахилгаан станцаас нь буцаад өөрт нь 342 төгрөгөөр өгч байгаа. Энэ тийм зах зээлийн зарчим биш. ТӨК-ийг ёстой урд хормойгоо хойд хормойгоор нь өгч байгаа учраас Эрдэнэт үйлдвэрийг төрийн өмчтэй юм болохлоор нь бид нар хүчээр ийм алдагдал үүрүүлж байгаа. Энийгээ нуухгүй.

С.Ганбаатар: Батлут гишүүн тодруулах гэж байна уу? Батлут гишүүн тодруулж асууя.

Д.Батлут: Би энэ сэргээгдэх эрчим хүчний гээд аймаар өндөр үнэтэй эрчим хүч нийлүүлээд байгаа энэ өртөг чинь, энэ зардал чинь 1квт эрчим хүчний үйлдвэрлэл дээр яаж нөлөөлөөд байгаа юм бэ? Тоог л асуугаад байгаа юм. Тэрийг надад хариулаад өгчхөөч гэж. Болохгүй бол надад сүүлд нь өгчхөөрэй.

Хоёрдугаарт нь энэ худалдан ав авралтын бодлоготой холбоотой энэ алдагдал дотор чинь ямар асуудлууд үүсээд байгаад байгаа юм бэ гэдгийг хариулаад өгчхөөч гээд. Тэгээд энэ бүхнийг алга болгохын тулд та яг юу хийгээд байна гэдэг асуудлыг л хөндсөн. Гуравхан асуудал дээр төвлөрч ярьж байгаа байхгүй юу. Жоохон тойролгүй яг хариулаад л өгчихмөөр л байгаа юм л даа. Энэ асуудлуудыг бид нар ингээд тойроод л байх юм бол тойроод л яваад байна. Уул нь ингээд энд нэг ийм асуудлууд байгаа юм. Тэрийг ингээд шийдчихмээр байгаа юм гэвэл Их Хурлын гишүүд бид нар дэмжээд явмаар байгаа байхгүй юу тийм биз дээ энэ дээр?

С.Ганбаатар: Манай үйлдвэрлэлийн хот Эрдэнэт хотоос сонгогдсон 2 гишүүн маань үгүй мөн тодорхой яг инженерийн тодорхой асуулт асууж байна шүү. 4 номерын микрофонд хариулъя.

П.Товуудорж: Эрчим хүчний зохицуулах хороо 2019 онд хамгийн сүүлд сэргээгдэх эрчим хүчний дэмжих тарифыг баталсан. 23 төгрөг 79 мөнгө байгаа. Тэгэхээр өнөөдөр эрчим хүчний үнийг 280 төгрөгт хүргэсэн гэвэл 8.4 хувьд нь нөлөөлж байгаа юм. Сэргээгдэх эрчим хүчний дэмжих тарифын энэ. Тэгэхдээ Зохицуулах хорооны сүүлийн тарифаар бол дэмжих тарифын энэ тогтоолыг хүчингүй болгоод яг л сэргээгдэх эрчим хүчний үнэ 280 төгрөг бүрдэхэд импортын үнэ энэ өндөр үнэтэй сэргээгдэхийн үнүүд ТЭЦ-4 92 төгрөг ингээд нийлээд өртөг гэдэг зүйл гарч байгаа учраас тухайн үед 2019 онд сэргээгдэх эрчим хүчний

дэмжих тарифыг батлах батлахад хэрэглээ 6.9, 7 орчим тэрбум төгрөг байсан, киловатт цаг байсан. Өнөөдөр 11.6 тэрбум киловатт цаг болж байгаа юм.

Гол нь валютын ханш өсөөд байгаа учраас. Энэ 23 төгрөг 79 мөнгө бодитой буурахгүй байгаа юм. Уул нь бол хэрэглээ 2 дахин нэмэгдчихсэн байхад өнөөдөр валютын ханш тогтвортой байсан бол энэ дэмжих тарифын өртөг бол буураад 10 хэдэн төгрөг л орчихсон байх ёстой. Тухайн үеэс валютаар тооцдог учраас валютын ханш нь энэ хэрэглээнийхээ өсөлтийг гүйцээд. Ингээд ерөнхийдөө энэ 23 төгрөг 79 мөнгө гэдэг дээрээ ингээд.../минут дуусав./

С.Ганбаатар: Батлут гишүүн маш тодорхой уг нь асуусан юм. Би цаг үрж тайлбарлалтай нь биш. 5 номерын микрофонд Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Батлут гишүүн асууж байна. Өртөг бууруулахын тулд юу хийж байна гэж асууж байна. Мэдээж өртгийг бууруулахын тулд манай төрийн өмчит 27 компани бий эрчим хүчний сайдаар зорилтот түвшин батлуулж байсан. Эд нар дээр бид нар бүх жил болгон л өртгийг бууруулах арга хэмжээнүүдийг аваад явж байгаа. Хамгийн доод үнээр худалдан авалтыг хий, хэмнэлтийн горимд ажилла гээд. Би яг 22 оны 8 сарын 30-наас хойш Эрчим хүчний сайдаар ажиллаж байхад жишээлбэл манай салбар хэмнэлтийн горимд ажиллаж байгаа юм. Одоо би танд дахин хэлье. ТЭЦ-4 их айхтар тендер явуулаад хусаад байдаг ТЭЦ-4 маань 92 төгрөгөөр л 1квт цаг эрчим хүчийг сүлжээнд нийлүүлж байгаа. Би энийг үр дүн гэж бодож байгаа.

ТЭЦ-3 165 төгрөгөөр 1квт цаг эрчим хүчийг нийлүүлж байгаа. Энэ өндөр инфляц ханшийн алдагдалд энэ бүх юм дунд 165 төгрөгөөр нийлүүлж байгааг үр дүн гэж бодож байгаа. Одоо би дараагийн асуудал яаж ч гүрийгээд энэ өртөг дотор хөөс байна.../минут дуусав./

С.Ганбаатар: 5 номерын микрофонд нэмж харил.

Б.Чойжилсүрэн: Энийг хэн ч Эрчим хүчний сайд байсан энэ хэн ч ТӨК-удын захирал байсан ийм хардлагаас салахгүй юм байна лээ. Энэнээс салах ганц арга хувийнх нь тэр хувьцааг нь өгөх. Хувийнх нь ороод ирчих юм бол өөрийнхөө юмыг өөрөөсөө хулгай хийхгүй шүү дээ. Тэрэнд л хүрэхийн тулд бид нар тийм. Алдагдалтай байгаа болохлоор хэн ч ямар ч хувийн хувь хүн манай энэ ТӨК-уд руу хөрөнгө оруулахгүй байна. Энийг одоо Ай Пи Өү хийхийн тулд доор хаяж 3 жил ашигтай байхын тулд одоо уул нь энэ эрчим хүчний реформыг хийж байхдаа 25, 26, 27 онуудад нь багтаагаад алдагдалгүй байлгаж байгаад хувийнханд энэ хувьцааных нь тодорхой хувийг өгчих юм бол энэ хардлагаас салж яс амрах ёстой байхгүй юу. Төр гэж дунд нь байгаад баахан юм идээд байгаа, хусаад байгаа гэдэг ийм хардлага байна. Та бүхэнд хэрвээ тийм идэж байгаа, ууж байгаа гэдэг мэдээлэл байгаа бол хүчний байгууллага нэгдүгээрт хандаач ээ. Хоёрдугаарт Улсын Их Хурлын гишүүдэд бол.../минут дуусав./

С.Ганбаатар: Батлут гишүүн.

Д.Батлут: Хоёулаа буруу л ойлголцоод байх юм. Ерөөсөө гол нь гайгүй сайн ойлголцдог хоёр байгаа юм. Би болохоор 1квт эрчим хүчний хэрэглээнд энэ сэргээгдэх эрчим хүчний өндөр тарифууд чинь хэр нөлөөлөөд байгаа юм? Аймаар том том тоо яриад байх юм. Мэдэхгүй, эсвэл би өөрөө бодож олмоор юм уу хаашаа юм.

Хоёрдугаарт нь өнөө алдагдлын тооцоо байна шүү дээ. 24 онд 203 гэсэн чинь 335 тэрбум болчихсон юм. Тэгээд энэ чинь яг юунаас болчихсон юм бэ гэдэг асуудлыг хөндөөд байгаа юм. Яах вэ зүгээр бид бүхэн ер нь мэднэ л дээ. Амьдрал баян янз янзын зүйл байгаа шүү дээ наадах чинь би мэдэж л байна ер нь. Тэгээд энийг бид нар алдагдалгүй байлгахын тулд яах ёстой юм бэ гэдэг санаа танд байгаа юу гэдгийг л сонирхох гэсэн байхгүй юу. Би яах вэ тэр зүйлийг чинь би ойлгож л байна л даа. Ингээд өртөг нь жоохон өөрийн өртөг нь жоохон буураад явж байгаа гээд. Надад тодорхой хариулт хэлээд өгөхгүй тойроод давхиад байх юм. Би бичгээр хандъя. Тодорхой хариулт өгөөрэй гэж хүсье. Баярлалаа.

С.Ганбаатар: Ингээд Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Энэ Орхон Онги гээд. Тэгээд энэ өчигдөр бас нээлтээ хийгээд өнөөдөр бас гарын үсэг зурж байх шиг байна. 2 мегабайтын УЦС гэж байгаа юм. Энэ талаар та хэд маань ямар мэдээлэлтэй байгаа вэ? Нэг дэх нь. Тийм мэдэж байгаа байх тээ? Хоёр дахь асуулт, мэдэхгүй байгаа юу? Тийм ингээд энэ бас өчигдөр яг технологийн хувьд би бас энэ УЦС-ын хувьд бас нэлээн бас сонирхдог юм. Жишээ нь Баянхонгор аймгийн Байдрагийн УЦС бас ямар шатандаа явж байгаа вэ гэдэг энэ 2 асуултыг асууж байгаа шүү?

Дараагийн асуудал энэ Баянхонгор аймаг дээр бас энэ 10мвт, 20мвт,-ын батарей хуримтлууртай системтэй 10мвт нарны цахилгаан станцын төсөл гэж байгаа. Энэ хаанахын хөрөнгө оруулалтаар ямар төсөл хэрэгжих гэж байгаа вэ? Ингээд л олон төслүүд байна. Энэ дээр ер нь бас энэ бид нарт яг таны ярьж байгаагаар ингээд л баахан л зовлон ярьж байна л даа. Тэгээд та бол 22 оноос хойш Эрчим хүчний сайд хийлээ. Тэгээд бас хийж байгаа ажлуудыг би бол хоёр талтай л байгаа. Ер нь цахилгааны үнэ нэмэгдсэнээр ард түмэн дээр очиж байгаа ачаалал бол маш их ачаалал очсон, амьдрал ахуй нь бас их хүндэрч байна. Бараа, бүтээгдэхүүний бүх ханш өслөө. Тэгээд үр дүн нь яг ямар байгаа юм бэ гэдэг юмаа та хэлээч. Ямар байж байгаад яг ямар болчхов? Энэ цөөхөн үгээр хэлчихвэл их сайн байна. Ингээд гурав дахь асуулт.

Дараагийн асуулт энэ танилцуулга дээр байгаа Тавантолгойн орд дээр түшиглэсэн энэ ДЦС гээд. Энэ олон жил ингээд яригдаж байгаа юм. Тэгээд энийг бид нар яг үндсэндээ шууд л өөрсдөө л хийх рүү ер нь орсон нь дээр юм байна гэдэг ийм дүгнэлт ард нь ч та хэд бичсэн байгаа шүү. Би ч гэсэн энэнтэй санал нэгдэж байгаа юм ер нь бол. Тэгэхээр энэ дээр ямар санаа бодол танд байдаг юм? Та бол нэлээн хэдэн жил ажиллачихлаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр шууд саналаа хэлээдхээч. Энэ Тавантолгой төслийг ингээд бид нар ийм л байдлаар барьчихвал болох гээд байна. Эс үгүй бол улсын төсвөөс барих юм уу, эс үгүй бол ер нь Монголчууд бид нар өөрсдөө яагаад барьж чаддаггүй юм? Бид нар чинь төмөр замаа барьж чаддаггүй байсан. Барьдаг болчихлоо. Орон сууцаа барьж чаддаггүй байсан та сайн барьж байгаа шүү дээ. Ингээд бүгдээрээ сайн барьж байна. Тэгэхээр ер нь энэ хурдныхаа зам, энэ дулааны энэ усан энэ станцуудаа өөрсдөө барих ёстой. Энэ тал дээр хариулт хэлээч.

Б.Чойжилсүрэн: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Энэ Орхон-Онги төслийн тухай хэвлэлээс мэдээлэл авсан. Манай яам энд огт нэгдүгээрт оролцохгүй байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт энэ Онгийн гол дээр одоогоос 4 жилийн өмнө хувийн хэвшил 3 МВт-ын хүчин чадалтай УЦС-ын ТЭЗҮ батлуулаад тэгээд тэр эргэж холбогдоогүй би ямар байдалтай байгааг нь бид нар мэдэхгүй байна.

Байдрагийн УЦС-ын тухайд одоо байгаа хүчин чадлаараа сүүлийн жилүүдэд энэ байгаль орчны нөлөөлөл их айхтар өндөр болсон үе. Байдрагийн гол Хангайн нуруунаас урагшаа их аваад урсдаг. Ийм гол учраас яг үнэнийг хэлэхэд би байгаль орчны нөлөөллийн нарийвчлалын үнэлгээ дээр гарын үсэг зурсан тэр экспортуудын үнэлгээнд би итгэхгүй байгаа. Би Эрчим хүчний сайдын хувь дээр бол төрд өр авхуулаад энэ Байдрагийн УЦС-ыг хэрвээ эхлүүлэх юм бол усны хомсдолд ороод төслийн хүчин чадлаар ажиллаж чадахгүй алдагдалд орох магадлалтай байгаа учраас би бол Байдрагийн УЦС-ыг эхлүүлэх тал дээр үнэндээ хулчийж байгаа. Хувийн салбарынхан нь өөрсдөө хөрөнгөө гаргаад эрсдэлээ үүрээд хийнэ гэвэл бид нар зөвшөөрнө.

Би хувь хүний хувьд бол тэр төрийн хөрөнгийг төсвийн хөрөнгө уйлдаггүй гэдэг шиг ийм ирээдүйд шүүмжлэл дагуулах шийдвэрийг би Эрчим хүчний сайдын хувьд гаргахгүй гэсэн бодолтой байгаа Жаргалсайхан гишүүнээ гэдгийг яг хариулъя.

Хоёрдугаарт энд та нэлээд Тавантолгойн ДЦС-ын тухайд 300 МВт-ын хүчин чадалтайгаар тендер зарласан. 23 оны 7 сарын 27-нд тэнд үнийн санал авсан. 30 хувийг нь “Эрдэнэс Тавантолгой” компани санхүүжүүлэлт, 70 хувийг нь бол И Пи Си барих компани нь санхүүжүүлэгч яг зээлээ дагаад олоод ирье гэсэн ийм нөхцөлтэй. 2 компани орж ирээд хоорондоо маргасаар байгаад харамсалтай нь 24 оны 12 сарын хүртэл маргасаар байгаад энэ тендерийг хүчингүй болгочихсон. Дахиад зарлах шаардлагатай болсон. Үеийн үед л бид нар өөрсдөө барья гэхлээр тэр 600 орчим сая долларыг гаргах бололцоо төсвийн хувьд ч тэр ТӨК-ийн хувьд ч байхгүй байсаар байгаад л энэ Тавантолгойн ДЦС-ыг ашиглалтад оруулж чадаагүй ингэж л ирсэн юм байна лээ. Одоо бид нар тендер дахиад зарлая гэхлээр И Пи Си нөхцөлөөр тендер зарлах бололцоо байхгүй. Тендерийн хууль дээр ийм өөрчлөлтийг 23 оны тэр манай бид нарыг тендер зарласны дараа 23 оны 6 сард батлаад хаячихсан Улсын Их Хурал. Одоо тендер зарлах бололцоо байхгүй. Одоо тэр Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах ийм хуулийн төслийг энэ өөрчлөлтийг тендер нээх бололцоо зарлах бололцоо бүрдэхийн тулд удахгүй ирэх долоо хоног юм уу, түүний дараагийн долоо хоногоос Их Хуралд хуулийн төсөл оруулж ирнэ. Эхний ээлжид манай яамыг харьяа байгаа Байнгын хорооны гишүүд та бүхэндээ энэ хуулийн төслийнхөө зорилго, юу шийдэх гээд байгаа асуудлаар та бүхэнд танилцуулга хийгээд Байнгын хороо болон Их Хурлын гишүүдэд танилцуулга хийж, энийг хэлэлцүүлж та бүхний дэмжлэгийг авч Их Хуралд хууль батлуулах ийм төлөвлөгөөтэй явж байгаа гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Буяагийн Тулга гишүүн сайд асуулт асууя.

Б.Тулга: Та бүгдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. 3 асуулт асуугаад тодорхой хариулт авъя гэж бодож байна. Нэгдүгээрт энэ боомтын дагуу сэргээгдэх эрчим хүчний төслийг гадна, дотнын хөрөнгө оруулагчидтай хамтраад хэрэгжүүлбэл зорилго нь бол эрчим хүчний сүлжээнд нийлүүлэхгүй экспортын зориулалтаар хэрэгжүүлбэл Эрчим хүчний яамнаас ямар ямар зөвшөөрөл авах вэ? Нэг.

Энэ Эрчим хүчний яамнаас энэний үнэ тариф дээр ямар нэгэн зохицуулалт Эрчим хүчний хорооноос ч юм уу юунаас хийдэг үү гэдэг дээр тайлбар хэлж өгөөч гэж хүсэж байна.

Хоёрт, түрүүн Эрчим хүчний зохицуулах хорооноос Орос, Хятад гээд хөрш орнуудын дундаж үнийн тарифыг хэллээ. Тэгэхлээр тэр маань бид нарын зорилтот тариф юм байна гэж ойлголоо. Гэхдээ та хэдийн таны сая хэлсэн тариф чинь эх үүсвэр нь яг ямар байгууллагаас та хэд минь авч энэ мэдээллийг явуулж байна? Яагаад гэвэл бас та нарын хэлж байгаа тариф бас хамаагүй хямдхан доор байдаг гэдэг мэдээлэл бас тэгэхлээр энэ дээр бас тайлбар хэлээч. Өөрөөр хэлбэл, үнийн мэдээлэл авч байгаа эх сурвалж чинь ер нь хэр бодитой вэ гэдэг асуулт байна.

Гуравдугаарт нь энэ СХД дээр сайдын тушаал гарсан, Зохицуулах хорооноос сая бас айл өрхүүд өөрсдөө сэргээгдэхийн төсөл хэрэгжүүлээд буцаагаад сүлжээ нийлүүлбэл авах үнийн дүнг сая хэллээ л дээ тариф. Тэгэхлээр энэ маань ер нь хэр бодитой яг амьдрал дээрээ хэрэгжиж чадаж байгаа вэ? Өнөөдрийн байдлаар хэдэн айл холбогдсон байна? Холбогдоогүй бол яагаад вэ гээд? Яг бодитой жишээ нь СХД-т бас ийм төсөл хийчхээд нийлүүлье гээд сайдын тушаалыг үзүүлээд явахлаар Улаанбаатар түгээх маань бол манай дүүрэгт ийм жишиг ердөөсөө 1 ч гараагүй тийм учраас хэрэгжүүлэх боломжгүй гэдэг хариу өгсөн байгаа гэдэг ийм тайлбар тавьж байна. Тэгэхлээр өнөөдрийг хүртэл ер нь хэдэн айл, өрх жижиг нийлүүлж чадаж байгаа, Сонгино дээр яагаад энэ болохгүй байгаа юм болоо гэдэг дээр хариулт өгөөч. 3 асуулт.

С.Ганбаатар: 4 номерын микрофонд хариулт өгье.

П.Товуудорж: Энэ журам 2020 онд батлагдсанаас хойш хэрэгжилт хангалтгүй байгаа. Хангалтгүй байгаа шалтгааныг Эрчим хүчний зохицуулах хороо олон нийтийн хэлэлцүүлгийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу 1 сар.

С.Ганбаатар: Протоколд нэрээ, албан тушаалаа хэлээрэй.

П.Товуудорж: Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч Товуудорж. Олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн. Энэ дээр бол 30 гаруй хүмүүс ирсэн. Тэгээд ерөөсөө холбогдож байгаа, хүндэрч байгаа асуудал энэ холболтын журам, техникийн нөхцөлтэй холбоотой асуудал байгаа. Яагаад гэхлээр сэргээгдэх шугамын эх үүсвэр бас энэ чинь хүчдэл гаргадаг учраас тодорхой аюулгүй ажиллагааны хувьд эргэх хүчдэл өгөхгүй шугам сүлжээн дээр ажил хийж байгаа хүмүүсийг магадгүй манайхан шугам сүлжээний засвар хийж байх үед нь хүчдэл тасарчихлаа гэж ойлгоход тэнд хэрэглэгч 220 вольт гаргаж байгаа учраас тэрийг буцаж эргэх хүчдэл өгөхгүйн тулд энэ техникийн боломжийг хангах иймэрхүү иймэрхүү асуудлууд байгаа. Гэхдээ энийг хялбарчил талаар зөвлөмжүүд өгч байгаа. Өнөөдөр яг энэ Сүхбаатарын талбай дээр Улаанбаатар ЦТС-ний техникийн албаныхан энэ техникийн нөхцөл олгоод энэ үзэсгэлэн дээр сууж байгаа. 2 сарын 5-ны бид нар тэр хэлэлцүүлэг дээр ерөнхийдөө 67 хэрэглэгч л энэ тархмал эх үүсвэрт холбогдсон байсан. Тэгэхээр энэ бол маш хангалтгүй үзүүлэлт гэж дүгнэсэн байж байгаа. Тэр эх үүсвэрүүдийг бол манай Эрчим хүчний зохицуулах хороо олон улсын байгууллагуудтай хамтарч тайлангуудад авдаг байж байгаа. Олон улсын сэргээгдэх эрчим хүчний, Олон улсын эрчим хүчний агентлаг, Дэлхийн эрчим хүчний зөвлөлүүдээс гаргадаг тайлангууд байгаа. Тэр тайлангууд дээрээс ерөнхий үнэ тарифыг бүс нутгуудаараа бол мэдээж өөр өөр байдаг. Хятад бол Өвөр Монголд бол хойд талын Өвөр Монгол энэ Ганьсү мужаар эрчим хүчний

үнэ хямд байдаг. Тэгэхээр бүс дундаж улс орны дундаж үнийг гаргаж энэ дээр өгч байгаа юм.

Түрүүн ерөнхийдөө энэ эрчим хүчний үнэ, зардал ингээд өсөөд байгаа шалтгаан дээр түрүүн олон гишүүд асуугаад байна. Ерөнхийдөө 2020 оноос хойш эрчим хүчний хэрэглээний 5-6 хувийн өсөлтийг бид нар ОХУ-ын энэ импортын өндөр үнэтэй эрчим хүчээр хаагаад байгаад байгаа юм. Жишээлбэл би тоо баримт хэлье. 2020 онд 312 сая квт цагийг авч байсан бол 24 онд 1.3 тэрбум квт цаг, 4 дахин өссөн байгаа. Нэг үгээр хэлбэл 20 оноос өмнө бид нар энэ эрчим хүчний хэрэглээний өсөлтийг 80 төгрөгийн үнэтэй, 92 төгрөгийн үнэтэй ТЭЦ-4-ийг нь эрчим хүчээр дотоодын үйлдвэрлэлээр хаадаг байсан бол 20 оноос хойш ерөнхийдөө манай дотоодын үйлдвэрлэл 21 оноос хойш тулчихсан. Тэгэхээр энэ хэрэглээний өсөлтийг 20 онд 312, 21 онд 486 сая квт цаг, 22 онд 694 сая квт цаг, 23 онд 938 сая квт цаг ингээд 24 онд 1.3 тэрбум квт цагийг ОХУ-ын импортын эрчим хүчээр. Өнөөдөр манайд нийт хэрэглээнийхээ 24.7 хувийг импортын эрчим хүчээр хангаж байгаа юм. Тэгэхээр энэ бол гарцаагүй энэ эрчим хүчний салбарын алдагдлыг нэмэхэд голтой, бас бодитой нөлөө үзүүлж байгаа шалтгаан бас энэ байгаа шүү гэдгийг бас хэлье.

С.Ганбаатар: 5 номерын микрофонд Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Тулга сайд ийм одоо бид нар чинь камер харахаараа нэн ялангуяа сонгууль дөхөхөөрөө баахан худлаа ярьдаг шүү дээ. Энэ худлаа ярилтуудын нэг нь жишээлбэл айл өрхөд сэргээгдэх эрчим хүч илүүдлээ төв сүлжээнд нийлүүлнэ гэж яриад байна шүү дээ. Онолын хувьд бололцоотой. Яг практик амьдрал дээр энэ айл болгонд ингээд сэргээгдэхээс илүү тийм тогтворгүй эрчим хүч нийлүүлэх юм бол систем тогтворгүй нурна. Өртөг нь манай энэ юу хууль дээр ингээд хүмүүсийг хошхируулахын тулд ийм заалтууд байгаа сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд. Одоо энийг засахгүйгээр явахгүй. Энэ ард түмэн чинь ингэж худлаа яриад камер харахаараа гоё дүрд тоглосоор байгаад бид нар чинь ийм байдалд орчихсон юм. Би энэ Энхцэцэг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгтээ энэ тал дээр засах тухай ярина. Тодорхой хүрээнд, сая манай, бид нар зэрэгцэж сууж байгаад манай түгээхийнхэн бол их гоё юм хийж байгаа гээд яриад байна шүү дээ. Энэ чинь худал. Энэ тодорхой хүрээнд ярихгүй бол хүн.../минут дуусав./

С.Ганбаатар: Буяагийн Тулга гишүүн тодруулж асуугаад та тэгээд Чойжил сайд нэмээд хариулчхаарай.

Б.Тулга: 2 асуултад хариулчихлаа. Эхнийх дээр боомттой холбоотой шинэ төслүүд гэдэг дээр хариулаарай. Тэгэхлээр Чойжоо сайд та хэлж байна шүү дээ сонгуулийн үеэр ингээд баахан өрхүүдээс сэргээгдэхээр эрчим хүчийг чинь худалдаж авна гээд. Угаасаа даахгүй байгаа. Дээр нь тэгээд яг тийм тогтворгүй эх үүсвэрт авна гэдэг нь хэцүү юм бол одоо ер нь та энэ бас тодорхой чиглэл гаргуулаад өөрийнхөө тушаал юунуудаа зарлачихвал яасан юм бэ эртхэн сонгуульгүй үед. Тэгэхгүй бол бас нээрээ яг ний нуугүй хэлэхэд уулзалт дээр давхиад очдог тэгээд яг л хариулчихмаар байгаа байхгүй юу. Боломжгүй, сэргээгдэхээр үйлдвэрлэж байгаа бол өөрийнхөө хэрэгцээг ханга, үндсэн сүлжээ рүү бол нийлүүлэх боломжгүй шүү гэдгээ бас хэлчихмээр байна. Тэгэхгүй янз янзын хүмүүс хөөрхий гомдчихсон, гомдчихсон ч юу байх вэ дээ янз янзын гомдол тавиад байх юм хөрөнгө оруулчихсан улсууд нь.

Тэгээд боомтын тэр экспортын зориулалттай төслүүд дээр үнэ, тэгээд эрх зүйн зөвшөөрлийн асуудлаар.

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайд хариулъя 5 номерын микрофонд.

Б.Чойжилсүрэн: Тулга сайд аа экспортыг хэрэглэгч, хэрэглэгч нь Монголын хэрэглэгч биш бол тэр экспортын гэрээгээ хийгээд аваад ирэх юм бол бид нар ямар нэгэн тээг тавихгүй, зөвшөөрөл өгөхгүй, түүгээрээ шийдчихэж болж байгаа юм. Өөр цахилгаан эрчим хүчний хэрэглээг 5мвт-аас дээшээ хэрэглээд зөвхөн өөрийнхөө хэрэглээнд зориулаад үйлдвэрлэж байгаа цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг бол бид нар тусгай зөвшөөрөл янз бүрийн юм шаардахгүй зөвхөн Монгол Улсын бусад хуулиуд, хөдөлмөр аюулгүй ажиллагааны гэх мэт бусад хуулиудыг дагаж мөрдөхийг шаардана.

Хилийн шугамын тухайд бол бид нар юу бид нар таны яриад байгаа тэр Вангийн цагаан гэдэг компани импортоор оруулж ирэх гэж байгааг нь дэмжих гэж байгаа. Гэхдээ тэр компани чинь түгээх үйл ажиллагаа явуулчих гээд байгаа учраас зөвхөн өөрийнхөө хэрэглээнд бол дэмжье. Шал утгагүй ярьж байна шүү. Тэгэхгүйгээр оруулж ирж өөрийн хэрэгцээнд гэхээд.../минут дуусав./

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайд дахиад нэмж тодруулж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Монголын хэрэглэгч биш бол тэр Хятад худалдан авагчтайгаа гэрээгээ л байгуулаад ирэхээр тэгээд үнэн дээр нь ч оролцохгүй.

С.Ганбаатар: Маш тодорхой хариулт өглөө. Сонгобайгийн Замира гишүүн асуулт асууна.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ер нь ингээд хараад байхад Чойжоо сайд аа энэ эрчим хүчний тогтолцооны системийн буруу биш үү, буруу тогтолцоотой юм биш үү? Яагаад энийг чөлөөлөхгүй байна? Тэгээд дээрээ 4 толгойтой. Хамгийн том компаниуд Оюутолгой ер нь Оюутолгой гэрээ нэг буруу хийгээд тэгээд гадаадаас эрчим хүчээ бас худалдаж аваад ингээд дотооддоо эрчим хүчний салбарыг хөгжүүлэх тал дээр хаалт хийж байгаа юм шиг сонсогдож байна л даа бүх юм. Ингээд гадаадынхны эрхшээлд орж болдог юм уу манайх? Энд нэгд юу авах ёстой л доо. Тэгээд бас бид нар 14 мега төсөл гээд маш том олон төслүүд баталчихсан байгаа. Тэгсэн чинь ийм өндөр үнэтэй цахилгаан, дээрээс нь удахгүй халаалтын үнэ нэмнэ гэнэ тэгээд бид нар яаж хөгжих вэ? Энэ тал дээр тэр ер нь яг ойлголтынх нь бодсон юм байна уу шийдвэртэй? Нэгэнт та ингээд эрчим хүчний асуудлыг ингээд хариуцаад сууж байгаа болохоор төр засагт ч гэсэн энэ Байнгын хороод ч гэсэн шийдвэртэй шийдвэртэй асуудал оруулж ирэх нь зүйтэй болов уу гээд би бодож байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бид нар Хятадаас урд, хойд хөршөөс ингээд цахилгааныг маш өндөр үнээр худалдаж авч байгаа юм байна шүү дээ. Тэрийг хөрөнгө оруулалт маягаар 2 улстай тохиролцож дотооддоо цахилгаан дулааны станц барьж болдоггүй юм уу? Тэр хүмүүстэй тохиролцвол тэр хүмүүс чинь худалдах сонирхолтой байж болно. Тэгэхдээ хамгийн гол нь яриандаа л байдаг байхгүй юу. Хүн гэдэг чинь хэлээр ойлголцдог байхгүй юу. Тийм учраас тэр хөрөнгө оруулалт татаж урд, хойд хөршөөс ингээд хөрөнгө оруулалт байвал цахилгааны асуудлыг шийдэх боломж байна уу? Энэ 2 асуултад хариулт авъя.

С.Ганбаатар: Сайд хариулъя 5 номерын микрофонд.

Б.Чойжилсүрэн: Замира гишүүний асуултад хариулъя. Та эрчим хүчний салбар 4 толгойтой боллоо, бодлогын уялдаа алдагдлаа гэсэн ийм шүүмжлэл ярьж байна. Энэ үнэн болсон юу? Одоо цахилгаан эрчим хүч доголдох, саатал гарах юм бол Эрдэнэс Монгол гэдэг компани хариуцах юм уу, Эрчим хүчний сайд хариуцах юм уу? Тодорхойгүй. Засгийн газрын тогтоолоор менежмент хэрэгжүүлэх 66 хувийг бол Эрчист Монгол гэдэг компанид өгсөн Засгийн газрын Хэрэг эрхлэх эрхийн харьяа ийм компани байгаа. Энэ одоохондоо бид нар ямар ч байсан юман дээр аваар осолгүй байгаа учраас хэл амгүй байна. Юу болохыг нэг талдаа харах байх. Эрчист Монгол гэдэг компани менежментийн эрхийг авч байгаа бол цахилгаан хангамжийн талаар энэ үнэ тарифын бодлогоо бас давж авах ёстой. Эрх, хариуцлага хоёр салахгүй гэж бодож байгаа. Хариуцлагыг Эрчим хүчний яам үүрээд эрхийг ондоо байгууллага хэрэгжүүлдэг бол энэ худлаа болно. Нэг.

Оюу толгойн төслийн тухайд өнөөдрийн нөхцөл байдал ийм байна. Сая Тавантолгойн цахилгаан станцыг 300 МВт-ын хүчин чадалтайгаар барина гэдэг маань яг өнөөдрийн байдлаар Оюу толгой компани анх 2009 онд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахдаа дотоодоос эрчим хүч авна гэдэг ийм гэрээтэй. Энэний дагуу олон жил явсан. Өнгөрсөн 2022 онд байх 1.3 тэрбум квт цаг эрчим хүчийг Монголын эрчим хүчний системээс авна гээд өөрийнх нь хэрэглээ өнөөдрийн байдлаар 2 тэрбум квт цаг эрчим хүч байгаа юм. Өнөөдөр Монголоос бид нар нийлүүлж чадахгүй байгаа учраас би яг 2 тэрбум квт цаг эрчим хүчийг бол Оюу толгойн компани Хятадаас бүрэн импортолж байгаа. Ойролцоогоор 10 цент тэр 140 орчим сая долларыг жил болгон Хятадын Өвөр Монголын эрчим хүчний системээс худалдаж авч байгаа. Тавантолгойн цахилгаан станц ашиглалтад орсон тохиолдолд энэ мөнгөний гадагшлах урсгалын дийлэнх хэсгийг нь бол Монголд үлдээх байсан. Харамсалтай нь би хэлсэн 2 компани хоорондоо шүүхэдсээр байгаад 2 жил шахам яваад одоо дахин зарлах байдал, дахиад шинээр эхлэх ийм нөхцөл байдалтай байчхаж байгаа. Оюу толгой компанийн үлдсэн дээр нь бол дахиад Монголын аж ахуйн нэгжээс сэргээгдэх 700 сая дээр нь үлдэж байгаа Монголын аж ахуйн нэгж сэргээгдэх эрчим хүчээр нийлүүлнэ. Үлдсэнийг нь бол Өвөр Монголын эрчим хүчний системээс тогтворжуулалтын гэрээ байгуулахаар ийм гэрээнүүд хийгдээд явж байгаа гэдгийг хэлье.

Яагаад цахилгаан станц барьж чадахгүй байна вэ гэхлээр Тавантолгойн цахилгаан станц жишээлбэл 300мвт дээр хүчин чадалтай барихад 600 сая доллар хэрэгтэй. Энэ мөнгө Монголд байхгүй байсан учраас л өдийг хүртэл баригдаагүй байсан нь ийм л зовлон.

С.Ганбаатар: Сонгобайгийн Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Ингээд урд, хойд хөршөөс цахилгаан худалдаж авч байгаа гэсэн тээ өндөр үнээр. Тэрийг эд бид нар тохиролцоод дотооддоо хөрөнгө оруулалт маягаар цахилгаан, дулааны станц хамтарч барьж болохгүй юу? Энэ тал дээрээ ер нь ажил, үйл ажиллагаа зохион байгуулсан уу гэж асуусан л даа сая.

С.Ганбаатар: 5 номерын микрофонд Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Замира гишүүн ээ бид нарт 2 хөрш маань бас л өөрийгөө бодно шүү дээ. Заавал биднийг бодох албагүй. Тэгэхээр өөрсдөө бид нарт цахилгаан эрчим хүчээ нийлүүлэх сонирхол тэр улсуудад байх нь зөв. Тэгэхээр

бид нар тэр хөрөнгө оруулалт гээд ингэхлээр тэр хөрөнгө оруулалтыг босгохын тулд л энэ Тавантолгойн цахилгаан станцыг 30 хувийг нь Эрдэнэс Тавантолгой компани санхүүжүүлнэ. Ай Пи Си контрактор нь бол санхүүжилтээ үлдсэн 70 хувиа босгож ирээд 5 жилийн дотор төсөл нь юу буцаагаад энэ Оюутолгойн төсөлд нийлүүлээд эргэн төлөх ёстой байсан гэсэн ганц л санхүүгийн бизнесийн боломж нь энэ. Түүнээс биш мэдээж үе үеийн эрчим хүчний сайд үе үеийн Засгийн газар энэ мэдээж энэ 2 хөрштэйгөө нийлээд дотооддоо хөрөнгө оруулалт барихаар тийм ажлууд явж байсан. Бүтэж байгаа юм байхгүй байсан. Бүтэх санхүү, бизнесийн загвар бол сая тендер зарлагдаад хүчингүй болдог. Харамсалтай нь 2 оролцогч очоод хоорондоо маргаад энэ хүчингүй болчихсон ийм л зүйл.

С.Ганбаатар: Гишүүд асуулт асуулаа. Би тодорхой 2-хон юм асуучихъя. Нэгдүгээрт гар гараа дагаж ганзага гуяа дагана, ард түмэн биднийг сонгосон гишүүдийг, 126 гишүүнийг сонгосон. Гишүүд бид сайдыг томилж сонгосон шүү. Тэгээд тэрнээс цааших дээр толгой эргүүлж болохгүй. Энэ дээр манай Очирбат гишүүн, Жангабыл гишүүнээр зохион байгуулалт хийлгэе. Тэгээд ойрын үед бас бид уулзаж Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо энэ яамныхаа үйл ажиллагааг дэмжиж бас бэрхшээлтэй зүйлүүдэд нь гарц гаргалгаа гаргах гэж уулзалт зохион байгуулалт хийнэ. Ажил хэргийн уулзалт хийхгүй бол мэдээлэл нэлээн овоорсон байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, удаа дараа ярилаа. Ер нь Засгийн газар боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч гурвыг базаар дээр, зах зээл дээр гаргадаггүй юм шүү. Үндсэн хуулийн 5.4-д бүх хэвслүүдийн сайн сайхны төлөө төрөөс эдийн засгийг зохицуулна гэж заасан. Бид төрийн зохицуулалттай эдийн засагт амьдарч байгаа. Өөр маш олон оронд, энэ хөрш орнууд ч ялгаагүй эрчим хүчнийхээ үнийг, дулаан, цахилгаан, дулаанаа базаар дээр гаргаагүй байгаа шүү. Зах зээл дээр, хар зах дээр гаргаагүй байгаа. Бүр онцгой анхаараарай. Энэ та нарын зүгээс нэлээн олон удаа хэллээ өртөгт хүрэхгүй байна гэж байна. Би Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс чинь нүүрс дээр амьдардаг улс. Нүүрс ихтэй л дээ. Тэгээд цахилгаан эрчим хүчний нүүрсний станцуудаасаа улс орноо зарим жилүүдэд бүр үнэ төлбөргүй цахилгаан дулаанаар хангаж байсан тохиолдлуудыг нь би мэдээлэл авч байсан шүү. Тэгэхлээр энэ дээр хоёр зүйл ярья.

Нэгдүгээрт яг энэ эрчим хүчний салбар дээр ёстой өөрийгөө золиослоод нэр хүндээ ч гэсэндээ өгөөд яг энэ салбараа аврах гээд зүтгэж байгааг бүүр туйлын ойлгож байна. Тэгээд энэ салбар нь ойлгож байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Тэгэхлээр миний тодруулж асуух зүйл гэвэл чуулган дээр би 4 удаа үг хэлж байсан Чойжилсүрэн сайдын нүдэнд би их ад болж харагдсан байх. Миний нүдэнд та их ад болж харагдсан. Энэ эрчим хүчний та ярьж байна гийгүүлээд байх юм байхгүй жоохон л нэмэгдсэн л гэж байна, өртөгтөө ч хүрээгүй л гэж байна. Үгүй та нарт найтаалт бидэнд бол хатгаа болчхоод байгаа юм шүү дээ. Үгүй мөн олон ЖДҮ-лэгч нар дампуурч байна даа цаана чинь. Тэр дээр тооцоо, судалгаа байгаа юу гэсэн ерөөсөө хариулаагүй. Маш их олон ажилгүйдэл, ядуурал энэнээс болж дампуурч байгаа. Дүүрсэн хэрэг орилуулсаар байгаад мань мэтээ орилуулсаар байгаад нэмлээ. Эрчим хүчний салбарынхны цалин нэмэгдсэн үү? Би Ховдод уулзалт хийлээ, Баянхонгорт уулзалт хийлээ, юу ч нэмэгдээгүй л гэж надад хэлсэн юм шүү уулзалт дээр. Тэр тодорхой тэр 10 хувь нь ерөөсөө аманд ч үгүй, хамар ч үгүй юм байна тэр тодорхой мэдээлэл өгөөч. Нэгдүгээрт.

1.3 их наяд гээд хоёулаа чуулган дээр ярьж байсан тэр өр төлбөрөөс юу буусан бэ? Энэ эрчим хүчний салбарт авлигал нүүрлэхихлээ л гээд яриад байна.

Зөндөө олон том том компаниуд яг энэ сонгуулийн үеийн хандив өгдөг хамгийн том компаниуд чинь эрчим хүчний тендер авдаг л компаниуд байгаа шүү дээ. Энэ авлигал буурсан уу, энэ дээр ямар нэгэн үр дүн гарсан уу? Энэ цахилгаан дулааныг нэмчихвэл тэгээд л цэнгэлийн манлайд хүрлээ л гэж ярьж байгаад л нэмсэн шүү дээ. Яах вэ хойшлуулсан байж болно. Тэр дээр миний асуулт нь саяын асуулт байна.

Хоёрдугаарт, Чойжилсүрэн сайд аа таны бодлого дээр харин ёстой дэмжих ёстой нэг юм байгаа шүү. Трамп цаадах чинь нүүрс рүү буцаад орчихлоо. Бид нүүрс дээр амьдарч байгаа. Ер нь нүүрс хэрэггүй шүү эрт сэргээгдэх рүү гээд л энэ бол зүгээр домог шүү. Энэ бас л их болгоомжтой хандах ёстой. Нүүрс дээрх цахилгаан станцуудаа бид бодлогоор дэмжих ёстой. Энэ ийм үлгэрт итгэж байгаад бид нүүрсээ тэр чигт нь зүгээр л шороогоор нь зөөж гаргах гэж байгаа тэнэглэлээ зогсоогоод энэ нүүрс дээр ядаж энэ Тавантолгойн цахилгаан станцаа хэрэгжүүлэх тал дээр энэ Оюу толгой мафид элсчихсэн юм шиг царайлж энэ 200 сая доллар орчим төлбөрийг Монгол хэзээ авах вэ? Энэ Тавантолгойн цахилгаан станц дээр хэдүүлээ яг хэзээ үр дүн гаргах вэ? Энэ бүр солиорсон юм шиг Баяннуурын мафид бид эзлэгдсэн юм шиг л санагдаад байна. Энэ хэзээ? Манай Байнгын хорооноос ямар тушаал, тогтоол гаргах вэ? Та нар ганцаардаж байгаа бол энэ дээр бид хамтармаар байна. Миний асуулт. Тэгээд салбар унах гээд байна, юм нэмэхгүй бол болохгүй байна л гэж байна. Үнэн үнэн. Энэ янзаараа тэгээд зүтгэх юм бол бид лаагаа барина гэж л хэлээд байгаа шүү дээ. Тэгээд үр дүн, реформ нь хаана яваа юм бэ? Олон толгойтой л боллоо. Би ингээд 3 асуулт асуучих шиг боллоо. Хариулт авъя.

Б.Чойжилсүрэн: Ганбаатар даргыг ойлгож дэмжиж байгаад маш их талархаж байна. Таны асуултад хариулъя.

Эхнийх нь цалин нэмэгдсэн үү гэж байна. Энэ 2024 оны 11 сарын 15-наас хойш цахилгаан, дулааны үнийг өртөгт ойртуулах гэж жоохон ярьсан. Би та нарт урьд нь ч хэлсэн энийг нэмчих юм цэнгэлийн манлайд хүргэж чадахгүй, энэ алдагдлыг жоохон багасгаж байгаа юм л гэсэн. Тэгээд ийм зүйлийг ярьсан. Яг ажиллагсдын цалинг 2023 оноос 2025 он хүртэл цалинг жил болгон 10 хувь нэмсэн. Энэ нэмэлтэд сая 546 тэрбум төгрөгийн 229.8 тэрбум төгрөгийг нь урьд нь байсан цалингийн өсөлт болон өр үүсээд цалин нь явж байсан. Энэ оны 4 сарын 1-нээс дахиад 10 хувь нэмэгдүүлэх ТӨК-удын эрчим хүчний салбарынхныг нэмэгдүүлэхээр тооцож зорилтот түвшин баталсан байгаа. Энэ дагуу л явж байгаа юм. 229.8 тэрбум төгрөгийг энд зарцуулсан. Шинэ эх үүсвэр болон ОХУ-ын импортын цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдсэн. Тэр шинэ эх үүсвэр гэдэг дотор Бөөрөлжүүт орно. Энэнээс шалтгаалаад 108.3 тэрбум төгрөгийг нь тэр үнийн өсөлтөд зарцуулахаас ондоо харахгүй. Импортын үнийн өсөлтийн зөрүүнээс. Бөөрөлжүүт, Тосонцэнгэл батареи хуримтлал руу болон импортын үнийн зөрүү.

Нүүрсний уурхайнууд төмөр замын нүүрс тээвэрлэлтийн өртгийг нэмж өгсөн. 102.5 тэрбум төгрөгөөр нүүрсний үнэ болон төмөр замын тээврийн хөлс. Энэ дээр 102.5 тэрбум төгрөгийг нь нэмэгдүүлсэн.

Засвар шинэчлэлтийн ажил дээр бол 77.1 тэрбум төгрөг. Баруун бүсийн эрчим хүчний систем Алтай-Улиастайн эрчим хүчний систем хэт том зайд хэт бага сийрэг хэрэглэгчтэй учраас алдагдал өндөр байдаг. Энийг улсын төсвөөс татаас өгөхөө больсон учраас 28.3 тэрбум төгрөгийг нь зарцуулаад нийтдээ 2000 бүгдийг нь орж ирсэн мөнгийг найдваргүй авлага болгочихгүйгээр ч 1 төгрөг үлдээхгүйгээр бүрэн авсан тохиолдолд 546 тэрбум төгрөг орж ирэх юм байна гэж тооцоолж байгаа 2025

онд. Бүгдийг нь авсан тохиолдолд ийм зүйлүүдэд зарцуулахаар тооцоолол хийгдсэн байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Тавантолгой дулаан цахилгаан станцын тухайд бол тендер зарлахын тулд манай худалдан авалтын Тендерийн тухай хуулиар И Пи Си гэрээ зөвшөөрөхгүй байгаа. Заавал зураг, төсөв хий гэж байгаа. Тэгэхээр манай эрчим хүчний салбар дээр юу хэлж байна вэ гэхлээр зураг, төсөв хийхийн тулд аль технологийг урьдчилж сонгоод тэгээд зураг төсөвтэй болно. Тэгэх юм бол тендер зарлаад ч нэмэр байхгүй. Аль нэг нь шууд давуу байдал олгочихно. Ийм тендерийн хуультай болжээ Монгол Улс 2024 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж байгаа юм байна. Энийг засахын тулд Эрчим хүчний тухай хууль оруулж ирнэ дарга аа. Та бүхэнд энэ эрчим хүчний тухай хуулийг дагуулаад Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай ийм 3 хуулийн төсөлд өөрчлөлт оруулж ирж байгаа. Энэ бол Энхцэцэг гишүүнтэй яриад байгаа том реформын хууль гэдэг дээр биш, би наана нь зөвхөн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлаа шийдчихье. Том юм яриад ямар ч үр дүн гарахгүй байснаас нэмэлт, өөрчлөлтөөр шийдчихээд байж байгаад тэгээд тэр үндэс Энхцэцэг гишүүнтэй ажлын хэсгийнхэн бол тэгээд тэрийгээ тэр өөрчлөлтүүдийг тусгаад явна биз гэсэн ийм байр суурьтай байгаа. Энхцэцэг гишүүн мэднэ. Би энийг бол 5 сарын 20-ноос өмнө, би өөрийнхөө санаачилж байгаа хуулийг 5 сарын 20-ноос өмнө Улсын Их Хуралд өргөн барьчихна. Хаврын чуулганаар баталж өгөөч гэж гуйх гэж байгаа юм. Тэгсэн тохиолдолд Тавантолгой ДЦС-ыг Аж үйлдвэрчдийн байнгын хороо, Эрчим хүчний яам 2 хамтраад болчих байх л гэж бодож байна. Батлуулчихсан тохиолдолд.

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайдын асуулт хариултыг авлаа. Ер нь хямд боломжтой тэгээд хамгийн гол нь найдвартай, тогтвортой эрчим хүчээр хангагдана гэдэг бүүр чухал.

Ингээд үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Очирбат гишүүнээр тасаллаа, Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа.

Г.Очирбат: Чойжилсүрэн сайд Монгол Улсын Үндсэн хуулийн 16.1.Монгол хүн амьд байх эрхтэй. 16.2.Эрүүл аюулгүй нөхцөлд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах эрхтэй гэж байгаа юм. Энэ бол Монгол төрийн үүрэг. Та Монгол төрийн сайд. Тэгээд та өөрөө өөрийнхөө эрчим хүчний салбарын хуулиудыг үгүйсгээд бас энд сууж байх юм түрүүн. Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль дээр Монгол Улсын иргэн 20квт эрчим хүчийг өөртөө үйлдвэрлээд илүүг нь төвийн шугам шилжүүлэн нийлүүлж болно гэж байгаа юм. Энэ хайбрид систем. Нарны панелтай, инвертортой, цэнэг хураагууртай, хэрэглэх үедээ хэрэглээд, хэрэглэхгүй үедээ өгдөг энэ технологийн шинэчлэл энийг үгүйсгээд энд сууж байж та болохгүй. Үнэхээр та энийг хийе гэх юм бол Монгол Улсад 190 мянган яндан байна. 190 мянган 07 га газрыг та ашиглах боломж бололцоогоо хайх ёстой. Иргэдээ бид нар орлоготой болгох ёстой. Энэ бүх газруудыг ард иргэдээ эвлэлдэн нийлүүлж чадах юм бол сэргээгдэх эрчим хүчний чинь газрынх нь нөөц тэнд бэлэн бас байж байгаа юм. Илүү гарсан тоог нь төр авчихъя л даа. Яагаад болохгүй юм, яагаад заавал гаднаас авах ёстой юм? Яагаад заавал энэ таны түрүүний хэлдэг тэр 9 компанийг дарж чадахгүй байна гээд сэргээгдэхийн тэр 9 компанид Монгол Улсаараа дарагдаад ингээд байж байх ёстой юм. Дэлхийн зах зээл дээр 1квт цаг сэргээгдэх хүчний эрчим хүч нойл нойл дөрвөн цент байна гээд та хэлж байна.

Тэгсэн мөртөө бид нэг арван долоогоор гэрээ хийчихсэн. Өнөөдөр ингээд алдагдал хүлээгээд байж байна. Нийт эрчим хүчний 8.4 хувийг нь үйлдвэрлэдэг мөртөө мөнгөний 20, 30 хувийг нь аваад явчихдаг. Тэгээд энэ байдлаа та засах ёстой шүү дээ сайд аа. Таныг засаач гэж бид нар бас итгэл хүлээлгэж сайд болгосон. Олон жил Их Хурлын гишүүн байсан, та олон ч янз бүрийн салбарын сайд хийсэн болохоор Монгол Улсын суурь хөгжил болсон энэ дэд бүтцийн эрчим хүчний асуудлыг бас босгоод ирэх юм болов уу гээд энэ Улсын Их Хурлын гишүүн чинь танд итгэж найдаад байж байгаа шүү дээ. Ялангуяа Аж үйлдвэржилтийн бодлогын хорооноос бид нар түрүүн бас БНХАУ-ын аж үйлдвэрийн паркттай танилцаад ирсэн.

Яг иргэдтэй нь уулзаад 1квт эрчим хүчээ хэдээр хэрэглэж байна гэж байгаа. 3.4 юань буюу Монгол төгрөгөөр 160, 70 төгрөгөөр хэрэглэж байгаа юм. Аж ахуйн нэгжүүд нь 4.5 юань, бүсчилснээс шалтгаалаад 6 хүртэлх юань. Ингэхээр тэнд чинь үйлдвэрлэл хөгжөөд байна шүү дээ. Бид нар энд үйлдвэрлэх гээд дэд бүтцийнх нь буюу анхан шатных нь цахилгаан эрчим хүч, уур, усных нь үнэ өндөр байхад яаж энд аж үйлдвэрийн салбар хөгжих юм бэ сайд аа. Хятадтай өрсөлдөх ямар ч боломжгүй байна шүү дээ. Орос руу та гараад хар л даа 1квт эрчим хүч аж ахуйн нэгж нь иргэдтэйгээ нийлээд дунджаар 200 төгрөг хүрэхгүй байна шүү дээ. Иргэд нь 170, 80 төгрөг максимумдаа. Бүсчилснээс шалтгаалаад зарим газар 80 төгрөгөөр хүртэл хэрэглэж байна.

Тэгээд энэ чинь өрсөлдөөний суурь зарчим шүү дээ. Тэгээд Монгол Улс цаашаа яаж хөгжих юм бэ сайд аа? Та энэ боломжуудаа нээнэ гэж гараараа яриад, нөгөө гараараа хаагаад төр бүгдийг нь хийнэ гээд яриад сууж байх юм. Тэгэхээр чинь итгэл үнэмшил төрхөө больчихлоо шүү дээ. Таны энэ гишүүдийн асууж байгаа асуулт болгонд та бүгдийг нь тойруулж хариулж байна. Өөртөө таалагдсан юмаа зөвөөр хариулж, өөртөө таалагдаагүй юмаа буруугаар хариулж байна. Зарим гишүүдийг та үг өгүүлбэрээр хүчиндэж байна шүү дээ. Бид нар хараад сууж байна шүү дээ. Та Монгол Улсын сайд, Сангийн сайд хүртэл байсан. Энэ улс эх орны хөгжлийн төлөө бас жоохон бодлого боловсруулаад сэтгэл зүрхээрээ ажиллаарай сайд аа. Аж үйлдвэрийн салбар ард иргэдийн амьдрал таны нуруун дээр байна шүү.

С.Ганбаатар: Ганбатын Очирбат гишүүн үг хэллээ. Ингээд Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Тодорхой асуултууд дээр бас тодорхой хариултуудыг мэргэжлийн хүний хувьд сайдаас авлаа. Нэмж тодруулах шаардлагатай зүйлс байгаа учраас бас тодорхой саналуудыг хэлээд хариултуудыг бас албан бичгээр өгөхийг хүсье. Энэ 10 компанитай холбоотой асуудлууд бас нэлээн яригдаж байна сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой. Үнэхээр өмнө нь парламент хууль гаргаад баталчихсан тэрний хүрээнд явж байгаа ажил юм бол энэ дээр бид нар бүрэн эрхийнхээ хүрээнд Ганбаатар даргаа хяналт, шалгалт оруулъя л даа. Энэ хуулийн хэрэгжилтийг нь үзье л дээ. Тэгээд салбарын сайдтайгаа хамтраад, салбарын яамтайгаа хамтраад сайд энэ дээр бас дэмжлэгийг нь үзүүлээд бодлогын зүгээс яаж өөрчлөх саналтай байгаа юм түүнийгээ гаргаад хамтраад ажиллая. Тэгээд эндээс үүсэж байгаа энэ эдийн засгийн дарамтыг ард иргэд үүрч болохгүй шүү дээ, аж ахуйн нэгж үрж болохгүй шүү дээ. Тэгээд энэ дээр тодорхой ажлыг зохион байгуулж хамтарч хийе гэдэг ийм санал байна.

Ер нь сэргээгдэх эрчим хүчний энэ хэдэн компаниас болоод Монголчууд бид сэргээгдэх эрчим хүч гэж ерөөсөө ямар ч хэрэггүй юм байна гэдэг ойлголтод хүрэх нь байна шүү. Ийм их зардалтай юм бол үүгээр яадаг юм бэ гэдэг ойлголтод хүрэх нь байна шүү. Тийм учраас энэ хууль, эрх зүйн орчин, энэ хэдэн компанитай холбоотой асуудлыг нэг талд нь гаргах нь зөв байх гэж. Эхний санал.

Хоёр дахь нь би хүчин зүйлийн шинжилгээ, факторын анализ, тодорхой асуулт асуусан. Салбарынхаа хувьд, мэргэшсэн хүний хувьд сайд техник технологийн асуудлыг, энэ техник тоног төхөөрөмжийн бас ашигт үйлийн коэффициент нөлөөлөх хүчин зүйлийг хэлж байна. Яах вэ би бас үйлдвэрлэлийн эдийн засаг гадарлах хүний хувьд энэ салбарт бас эдийн засгийн асуудлыг хариуцаж байсан хүний хувьд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байгаа. Нөлөөлж байгаа олон хүчин зүйл бий. Сайдын хэлдэг тоног төхөөрөмжийн ашигт үйлийн коэффициент, зуух, турбин, генератор үүний ашигт үйлийн коэффициент тодорхой хэмжээгээр нөлөөлөх нь ойлгомжтой. Хажууд нь менежментийн асуудлууд байгаа шүү дээ. Боловсон хүчний бодлого, хөдөлмөрийн бүтээмжийн асуудал, өртөг зардлыг бууруулах санхүүгийн менежментийн асуудал, худалдан авч байгаа түүхий эдийн чанар, өртгийн асуудал.

Гол нь энэ үд үзүүлэлтүүд дээр чинь тооцоо хийж, энэ эрчим хүчний үнэ тарифыг тогтоогоод байгаа Зохицуулах зөвлөлөөс гэж асуугаад байгаа нь би тэр л дээ. Тэгээд манай Зохицуулах зөвлөлөөс хариулж байгаа хүн станцуудын нүүрсний зарцуулалт яриад суугаад байх юм. Үгүй энэ чинь бүх станц нэг эх үүсвэртэй нүүрсгүй шүү дээ. Өөр өөр орд хэрэглэж байгаа биз дээ. Өөр өөр ордын, өөр өөр төрлийн нүүрс хэрэглэж байгаа юм байгаа биз дээ? Нүүрсний чинь илчлэг чанараас хамаараад зарцуулалт нэгжийн үнэ хүртэл өөр байх юм байгаа биз дээ? Тэгэхээр чинь энэ станцуудын нүүрсний зарцуулалтыг хооронд нь харьцуулаад абсолют утгаар нь харьцуулаад сууж байж болохгүй шүү дээ.

Тийм учраас энэ факторын анализыг тодорхой хиймээр байна. Хөрөнгө оруулалтын үр өгөөж гэж ер нь юу байгаа юм? Урсгал засвар үйлчилгээний үр өгөөж гэж юу байгаа юм? Салбарын хувьд хөрөнгө оруулалт шаардлагатай шинэ бүтээн байгуулалт шаардлагатай болчихсоныг ойлгож байгаа. Үүнийг хийхийн тулд яг аль үзүүлэлт дээр бид нар онцолж хэдэн хувь анхаарал хандуулах юм бэ гэдэг юмаа л гаргахын тулд энэ факторын анализ чинь хэрэгтэй байхгүй юу. Тэгээд яагаад ийм тооцоо нэхээд байгааг ойлгож байгаа гэж найдаж байна. Яагаад гэвэл эрчим хүчний салбар өнөөдөр эрчим хүчний хэрэглээ, эрчим хүчний үнэ, эрчим хүчний энэ зардал, айл өрхийн хувьд ч, аж ахуйн нэгжийн хувьд ч хамгийн гол масс эзэлж байгаа шүү дээ. Бид өнөөдөр хоногийн хоолтой байх уу, үгүй юу гэхээсээ илүү тогтой, цахилгаантай байхаа л илүүд үзэж байгаа шүү дээ.

Эрдэнэт үйлдвэр 2020 оны 12 сараас 22 оны 6 сар хүртэл 18 сарын хугацаанд айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын эрчим хүчний зардлыг даасан. Энэ үед маш олон эрчим хүчний компаниуд өртөг зардлаа бууруулж, хөрөнгө оруулалтаа нэмж чадлаа гэдгийг хэлж байсан шүү дээ. Тооцоо судалгаа байдаг.

Нөгөө талдаа Эрдэнэт үйлдвэрийн тэр дулааны станцтай холбоотой үнэ тарифын асуудлыг би Улсын Их Хурлын гишүүний хувьд Эрдэнэт үйлдвэрийн жишээн дээр өөр эх үүсвэр нэмэгдэх боломжийг хаагаад байгаа учраас хэлж

байгаа юм шүү. Ядаад хэрэглэдэг эрчим хүчээ үйлдвэрлээд өөрөө авдаг болох юм бол энэ системд эх үүсвэр нэмэгдэнэ.

С.Ганбаатар: Ингээд гишүүд үг хэлж хэллээ. Чойжилсүрэн сайдад хэлэхэд энэ олон жил сайхан найрлаж найрлаж байгаад л над дээр ирээд л шарталт нь над дээр ирчихлээ гэдэг шиг л олон жил эрчим хүчний салбар бас реформын шинж чанартай алхмуудыг хийхгүй удааж байсан талууд бий бий. Тэгээд өнөөдөр бас хатуу ч гэсэндээ реформ хийх гэж оролдож байгаа. Энийг бид ойлгож бас хүндлэх ёстой.

Дээр нь нэмээд энийг хийх гэж байна гээд ЖДҮ-лэгчид ялангуяа бизнес эрхлэгчдийн, аж ахуй эрхлэгчдийн ширвээд хаячхаж болохгүй гэдгээ хэдүүлээ бас хамтарч ярилцана. Тэгээд энэ дээр бас олон асуудал байгаа. Тэр сэргээгдэхийн тэр өмнө нь нэлээн олон жилийн өмнө бараг бүлэглэл маягтай хийчихсэн гэрээнүүд биднийг боомилж байгаа. Энэ дээр бас Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороо яамтайгаа хамтарч тэр чинь дараа дараагийн сэргээгдэхийн инновац технологи ороод ирчихсэн улсуудад бас бөглөө тээг болж байхыг үгүйсгэхгүй шүү дээ. Энэ дээр баг болж хамтарч бас бие биеийнхээ ажлыг дэмжиж ажиллах ёстой.

Тэгээд 2 дугаар гол зүйл гэвэл манай Жангабыл гишүүн байна, Очирбат гишүүн байна зохион байгуулалт хийгээд ойрын үед хэдүүлээ ажил хэргийн нэлээн мэдээллийн ойлголттой нэг болгох уулзалт хийгээд тэрний дараа Үүрийнтуяа гишүүн сая бас санал гаргалаа. Ажлын хэсэг гаргаад тэгээд тогтоолоор заавал хэрэгжих шүү дээ Аж үйлдвэрийн бодлогын байнгын хорооны тогтоол заавал хэрэгжих баримт бичиг. Тогтоолоор шийдвэр гаргана, олон толгой байхгүй. Чойжилсүрэн сайдад бид хэрвээ янз бүрийн үйл ажиллагааны дэм байгаа бол бид хамтарч ажиллах ёстой, үүрэгтэй Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороо. Ингээд ард иргэдэд тогтвортой эрчим хүчээр хангах тал дээр бид яг л энэ үеийг ашиглахгүй бол тэгээд л удахгүй 8, 9 сар, 10 сар гээд л ороод ирнэ шүү дээ. Олон олон бас нэмэгдлүүдийг чинь бас л 1 сарын 1 эд нар гээд хойшоо шидчихсэн байна лээ шүү дээ. Тэгэхлээр хэдүүлээ хамтарч баг болж энэ дээр ард иргэдийн эрчим хүчний асуудлыг бас шийдэхэд дэм болж ажиллана, хамтарч ажиллана.

Ингээд мэдээлэл өгсөн Баттогтохын Чойжилсүрэн сайд болон баг хамт олонд талархлаа. Мэдээлэл авлаа.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Дараагийн хэлэлцэх асуудал дуусаагүй шүү дээ. Хэлэлцэх 3 дугаар асуудал, 4 дүгээр асуудал нь.

15.44 цаг

Хэлэлцэх асуудал Улсын Их Хурлын гишүүн Золжаргалаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох.

Ингээд албаны хүмүүсийг та бүхэнд танилцуулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Туваан сайд ирсэн байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар ирсэн байна. Ирж байна. Хулан тус яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга? Хулан дарга ирсэн байна. Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын

дарга Итгэлт ирсэн байна. Зам, тээврийн яамны Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Мөнхбат ирсэн байна, “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал ирсэн байна. Уул уурхай технологийн газрын дарга Алтанбагана ирсэн байна. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Гантулга ирсэн байна. Хууль, эрх зүйн газрын дарга Уянга ирсэн орж ирж байна. Цэрэндондог? Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга Цэрэндондог ирсэн байна. Болчихсон юм уу? Ингээд албаны хүмүүсийг танилцууллаа.

Байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар мэдээллийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан танилцуулна та бүхэнд. 5 номерын микрофоныг нээж өгье.

Ц.Туваан: Эрхэм Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай 58 дугаар тогтоолыг баталснаар 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Гашуунсухайт -ан мод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай, Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулсан.

Энэхүү Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2025 оны 3 сарын 27-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн соёрхон баталсан.

2025 оны 2 сарын 14-ний өдөр байгуулагдсан Монгол, Хятадын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон 2002 сарын 15-ны өдөр байгуулагдсан 2 талын ажлын хэсгийн хамтарсан уулзалтын протоколд гарын үсэг тус тус зурсан.

Дээрх хэлэлцээр протоколын хүрээнд байгуулагдах гэрээнүүдийн яриа хэлэлцээ идэвхтэй хийгдэж эцэслэх шатандаа явж байна. Үүнд:

Нэгт, нүүрс худалдах, худалдан авах урт хугацаат гэрээ.

2.Уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны ерөнхий гэрээ.

3.Гашуун сухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих гэрээ болно.

Монгол Улсын Ерөнхий сайдаас төмөр замын төслийн шав тавих ёслолыг зохион байгуулах үүргийг өгсөн бөгөөд Засгийн газрын 2025 оны 156 дугаар тогтоолын дагуу бүтээн байгуулалтын нээлтийн үйл ажиллагааг 25 оны 5 дугаар сарын 14-нд зохион байгуулахаар урьдчилан тохиролцож бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Ганбаатар: Туваан сайдын мэдээлэл маш товч тодорхой боллоо. Энэ ингээд 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Золжаргал гишүүнийг бас нэрсийг нь оруулаарай. Хамгийн сүүлд нь тавьчаарай. Ингээд Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна. Жаргалсайхан гишүүнээр тасаллаа, Золжаргал гишүүнээр тасаллаа.

Г.Очирбат: Өдрийн мэнд. Туваан сайд нэлээн жоохон товчхон танилцуулга явчихлаа. Гурвыг цогцоор гээд Их Хурлын олон гишүүд бас энэ 58 дугаар тогтоол дээр дэмжлэг үзүүлээд явсан. Тэгэхээр яг тодорхой задаргаа өнөөдөр яг ямар байдалтай байгаа, ямар түвшиндээ байгаа, хэзээ гэрээ хийгдэх юм, нөгөө талаас олборлолт дээр яаж оролцох юм, борлуулалт дээрээ яг яах гэж байгаа юм? Энийг тодорхой мэдээлэл өгөөч гэж хүсэх гэсэн юм. Тэрний ар дээр нь дахиад асууя тэгэх үү? Хэтэрхий товчхон явж байгаа юм.

С.Ганбаатар: Очирбат гишүүний асуултад хариулъя 5 номерын микрофоныг нээж өгье.

Ц.Туваан: Энэ хэлэлцээр маш удаан хугацааны туршид явагдсан, нэлээн улс төржилттэй, нэлээн гацаатай, маш олон жил яригдаж байгаад хийгдсэн ийм Засгийн газар хоорондын хэлэлцээр байгаа. Энэ хэлэлцээрийг байгуулахад бид нар бас тодорхой эрсдэлүүд байгаа. Дээрээс нь анхны 126 гишүүнтэй парламент анхны хамтарсан Засгийн газрууд байгаа учраас энэ дээр бас дахин гацахгүй цааш нь явуулах үүднээс нэлээн нээлттэй ярилцаж, 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байдлаар хийе, дээрээс нь энэ хэлэлцээрийг байгуулахдаа Улсын Их Хурлаасаа үндсэн чиглэлээ авъя гэдэг ийм шийдвэрээр Улсын Их Хурлаас чиглэл авч, нийтдээ 12 заалттай ийм хэлэлцээр байгуулахад баримтлах үндсэн чиглэл гэдэг энэ чиглэлийг гаргуулж авч үүний дагуу бид нар ажиллаж, хэлэлцээрийг байгуулсан гэдгийг хэлье.

Мөн хэлэлцээрийг байгуулсны дараа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлах ийм процесс байдаг. Энэ соёрхон батлах процессын үеэр бас бид нар нэлээн ярилцаж, хэлэлцэж баталсан. Мөн энэ хэлэлцээрийг байгуулах үндсэн чиглэл батлагдсаны дараа байгуулах явцад тодорхой Байнгын хороонуудаар орж нэлээн тодорхой зүйл ярьсан учраас бас голчлон гишүүдийн асуултад хариулах явцдаа нэлээн дэлгэрүүлж ярья гэж бодож танилцуулгаа бэлдсэн. Энэ бид бүхний нэлээн сайн мэддэг ийм асуудал байгаа.

Байнгын хороон дээр энэ хэлэлцээрийн явцтай холбоотой асуудлууд яригдаж байгаа. Үндсэн 3 асуудал байгаа. Тэрийг нь дахиж давтаж хэлэх юм бол Ганц мод-Гашуунсухайт төмөр замын бүтээн байгуулалтын асуудал байгаа. Энэ дээр тендер зарлагдаад, хэд хоногийн өмнө тендерээ хаагаад, оролцогч компаниудаа дүгнээд 1 компани шалгарсан байдалтай байгаа гэдгийг хэлье.

Хоёр дахь асуудал нь нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны хэлэлцээр байгаа, гэрээ байгаа. Тэгэхээр энийг компани хооронд энэ өөрөөр хэлбэл Чайна Энержи болон Эрдэнэс Тавантолгой компаниуд хоорондоо маш удаан хугацаанд энийг нэлээн нарийвчлан ярилцаж, эцсийн байдлаар гэхэд өчигдөр би бас том ажлын хэсгийн хүрээнд, түүнээс 2 хоногийн өмнө Дэлгэрсайхан сайд мөн том ажлын хэсгийн хүрээнд харилцан ярилцаж зарим зүйлийг

тодруулснаар энэ 5 сарын 14-ний шав тавих ёслолын өмнө энэ гэрээгээ байгуулахаар ажиллаж байна. Маргааш бас ажлын хэсгийнхэн БНХАУ-д очиж эцсийн байдлаар тохирч ирээд Монгол Улсад зурахаар тохирсон байгаа гэдгийг хэлье.

Уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэрээ мөн бас энэ 5 сарын 14-ний наана хийгдэнэ гэж ингэж ойлгож болно. Энэ дээр мэдээж гэрээ нь хийгдэх боловч яг үндсэн хэрэгжих процесс нь 2030 оны 1 сарын 1-нээс цааш хэрэгжих. Өөрөөр хэлбэл, энэ хооронд онч хараат Бор толгойн ордыг хайгуул хийгээд, нөөцийг нь тогтоогоод, нүүрсний чанарыг нь үзээд ТЭЗҮ-гээ Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуул болох гээд шат дараатай нэлээн олон процессуудыг хийсний дараа үйл ажиллагаа явагдах учраас энэ дээр хэлэлцээр байгуулагдсанаас хойш, гэрээ хийгдсэнээс хойш үйл ажиллагаанууд бас нэлээн төлөвлөгөөтэй явна гэдгийг бас хэлье.

Тэгээд хэлэлцээр хийгдэх явцад бас нэлээн тодорхой болгох, бас ойлгомжгүй байдлыг үүссэн зэрэг шалтгаануудаас өдийг хүртэл бас хэлэлцээрүүд явагдаж байна. Эцэслэн хэлэхэд энэ 14-ний өдөр Гашуунсухайт-Ганц мод боомтуудад нэгэн зэрэг энэ бүтээн байгуулалтын нээлт.../минут дуусав./

С.Ганбаатар: Асуултад хариуллаа. Очирбат гишүүн тодруулж асууя гэж байна.

Г.Очирбат: Тэгээд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал ялангуяа экспортод гаргаж байгаа бараа, бүтээгдэхүүний нөхцөл байдал нэлээн тийм хүнд байгаа. Бараа, бүтээгдэхүүний үнэ ч гэсэн ханш уначихсан байгаа. Тэгэхээр Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яаман дээр нэлээн ажлын хариуцлага бас ирж байгаа. Тэгээд ямар ч байсан 58 дугаар тогтоолоор бид Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо, мэргэжлийн Байнгын хороод бүх л салбараар энэ тогтоол дээр оруулах асуудлуудаа оруулаад ажил хэрэг болгоод явж байгаа. Одоо өшөө эрчимжүүлэхийн тулд юу хийх вэ? Бодлогоор Аж үйлдвэржилтийн байнгын хороод яаж дэмжих вэ та бүхнийг? Цаашдаа ер нь энэ ажлыг хурдтай хийж эхлэхгүй бол ер нь эдийн засгийн нөхцөл байдал чинь ингээд хүндрээд ирэх юм бол улс, эх орны ард иргэдийн нийт суурь инфляц өсөх, эдийн засаг агших гээд том том асуудлууд руу орох гээд байгаа. Тэгэхээр бид ер нь мэргэжлийн Байнгын хорооны хувьд бодлогоор яаж дэмжих вэ? Энэ талаар ямар санал, санаачилга байна?

С.Ганбаатар: Туваан сайд.

Ц.Туваан: Очирбат гишүүний тодруулга асуултад хариулъя. Тэгээд Очирбат гишүүн бас яг хувийн сектор дээр ажиллаж байсан энэ ажлыг явуулахад бас нэлээн хүндрэлтэй байдаг энэ зовлонг ойлгох хүний хувиар бас маш чухал ийм асуудал асуулаа. Мэдээж ажил явуулахад нарийн чимхлүүр хэдий компани хоорондын гэрээ гээд бид хэд ч гэсэн бас ингээд орхичхож болохгүй, оролцоод шийдвэрийг нь гаргалцаад ингээд явж байгаа. Тэгэхээр 3 асуудал байгаа. Нэг нь Зам, тээврийн яаман дээр энэ төмөр замын хил холболтын асуудал нь, нөгөө 2 асуудал нь ерөнхийдөө манай яаман дээр ингээд явж байгаа. Энэ дээр мэдээж бас хамгийн сүүлд явагдаж байгаа хүндрэлтэй асуудлууд гэхээр 2030 оноос хойш 20 сая тонноо яг өгөх үү, энэ 20 сая тонн дотроо та нар манайд өгөх коксжих нүүрсээ яг хангаж.../минут дуусав./

С.Ганбаатар: Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Энэ хил холболтын төмөр замын энэ гэрээг бол яаравчилж хийж ажлыг бол түргэвчлэх бол шаардлагатай байгаа. Энийг дэмжиж байгаа. Үүнтэй холбоотой сая Улсын Их Хурлын чуулган руу орж ирсэн өнөө таны өөрийн буцааж татсан хууль холбоотой байсан уу? Үүнээс болж ажил гацаж байгаа, саатаж байгаа зүйл байна уу? Нэг дэх асуудал.

Одоогийн байдлаар гэрээ байгуулагдаагүй, 1 компани бол ямар ч байсан сонгон шалгаруулалтад хийгдээд явж байгаа юм байна гэж ойлголоо. Ер нь та хэдийн тавьж байгаа хугацаанаас наашлуулж бас энэ ажлыг гүйцэтгэж дуусгах ийм бололцоо нөхцөл хэр нааштай байна вэ? Тэгээд энийг хугацаагаа л бид нар наашлуулж байж л дараагийн хил бол хурдан шуурхай явах асуудал байна шүү дээ. Ингээд хоёр дахь асуудал.

Дараа нь бол энэ Шивээхүрэн Хангийн хил холболтын ажлууд дээр ямар ахиц гарч байна вэ? Энэний яриа хэлэлцээ, бусад зүйл ер нь яа хөдөлсөн үү? Би бол эхнийх нь сонгон шалгаруулалт нь хийгдээд Улсын Их Хурлаар ороод гарчихсан, гэрээнийх нь шатад явж байгаа ажил гэдэг бол нэлээн ажлууд явчихлаа шүү дээ. Тэгэхээр дараагийн ажлууд маань хөдлөх бололцоо, нөхцөл бүрдсэн гэж харж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ямар ахиц, дэвшил гарч байна гэсэн ийм 3 асуулт байна.

С.Ганбаатар: 5 номерын микрофонд Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Уул уурхайн биржийн тухай хуулиа бид нар татаж авсан. Гишүүдийн хэлсэн санал шүүмжлэлийн дагуу цөмийн энергийн агентлаг байгуулах асуудал, бүтээгдэхүүн солилцооны асуудал хоёроо татаж аваад буцааж оруулж ирж байгаа. Энэ хууль бас мэдээж хууль батлагдаад эерэг үр дүнтэй байгаа ч гэсэн амьдрал баян учраас энийг засаж сайжруулах ийм 3, 4 асуудал байгаа учраас энийгээ яаралтай шийдүүлэх хүрээнд бид нар маргааш Засгийн газраар оруулаад ингээд хуулиа оруулж ирнэ. Энэ 2 асуудал хоорондоо ямар нэгэн холбоогүй гэдгийг албан ёсоор хэлье.

Ажлын гүйцэтгэлийг анх 2 жил 6 сар буюу 30 сар гэж тооцоолж байсан. Яг өнөөдрийн байдлаар бид нар тэр 978 тэрбум төгрөг буюу 270-аад сая долларыг бас нэлээн наашлуулаад 220 сая доллар руу авчирсан. Дээрээс нь гүйцэтгэлийн хугацааг 24 сар дээр авчирсан буюу 2 жилийн дотор ашиглалтад оруулна гэсэн ийм урьдчилсан төлөвлөгөөтэй явж байгаа. Энэ асуудлуудыг хөдөлсний дараагаар яг дэс дараалал эрэмбийн дагуу 2 улсын хооронд ярилцан тохиролцсоны дагуу Шивээхүрэн-Сэхээгийн төмөр замын хил холболтын асуудал байгаа. Энэ хил бол яг асуудал нь шийдэгдчих юм бол маш хурдан хугацаанд орох ийм боломжтой.

Асуудал нь юундаа байна гэхлээр Улсын Их Хурлын гишүүн Ардчилсан намын Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдоржийн санаачилж оруулж ирсэн энэ импортын хийх төмөр замын царигийг тухайн импортолж авч байгаа улсын царигаар байх гэдэг энэ асуудал шийдэгдчихвэл асуудал нь маш хурдтай явах юм байна лээ гэдгийг бас энэ урд талын албаны хүмүүстэй уулзсан уулзалт бас мэдэж авсан. Тэгэхээр энэ асуудал нэлээн хурдтай шийдэгдэх юм бол, өөрөөр хэлбэл Засгийн газраас орж ирээд Их Хурлаар яаралтай шийдэгдээд хил орчмын экспорт хийх уурхайгаас шууд гарах төмөр зам нь тухайн авч байгаа улсынхаа царигтай адилхан байвал гэдэг асуудал шийдэгдэх юм бол Шивээхүрэнгийн төмөр зам холбогдох асуудал маш хурдан шийдэгдэх юм байна лээ. 320 метр байгаа. Яг

асуудал нь шийдэгдээд ажил эхэлбэл 2 сарын дотор бүрэн холбогдох ийм боломжтой юм байна лээ. Тэгээд бид бүхэн дипломат шугамаар болон яамдын шугамаар, Элчин сайдын яамдаар дамжуулж энэ асуудлуудыг маш их шахаж ажиллаж байгаа. Тэгэхээр энэ 5 сарын 14-нөөс хойш энэ ажил руугаа шууд бодитойгоор ороод явна гэж хариулъя.

С.Ганбаатар: Золжаргал гишүүн орж ирж амжаагүй байна. Бас Байнгын хорооны хурал нь бас хуралдаад байгаа юм шүү. Би тодруулж ганц зүйл асууя.

Ерөнхийдөө Туваан сайд аа Монголын энэ өнгөрсөн 30 жилийн хугацаанд ингээд л том том гэрээнүүд, том том бизнесийн дил/deal/-үүд хийдэг л дээ. Тэгээд нэг мэдэхэд л дандаа далаараа ёстой нам тавиулчихсан л байх юм даа. Тэгээд манай төр засгийн мэргэжилтнүүд нь чааваас анхиагүй гэж би хэлмээргүй байна л даа. Сэтгэлгүй, өөдгүй гэж бас хэлмээргүй байна. Ер нь муу юмнаас сайн юм үүсдэг гэдэг шиг тэгээд хаширчихсан хүн чинь хаширчихсан байх юм. Оюу толгой дээр орилоод л хэлээд л байсан ганц л юм бий. Та нар мэдэхгүйгээ мэдээч ээ, бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гаргасан уу, олон улсын болон үндэсний хэмжээний л гэж би дандаа ярьдаг. Уран дээр нам авхуулчихлаа. Газрын тосны үйлдвэрийн газар дээр би барин тавин хэлж байгаа юм шүү дээ. Яагаад энэ луйврыг зүгээр явуулаад байгаа юм бэ гэдэг шиг би эднүүсийг ингэж нуршиж ярьж байгаа нь санаагаа ойлгуулах гэж байгаа нь л санаа л даа. Энэ том олон тэрбум долларын энэ том гэрээ, дил/deal/ дээр бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтийг гаргаж, дүгнэлтийн дагуу та нар шийдвэрээ гаргасан уу, дүгнэлт гаргасан уу? Энэ дотор ийм том төсөл, ийм том төмөр замын холболт дээр урьд нь ажиллаж байсан хүн л лав та нар дотроос үзээд буцаагаад өгье гэсэн ч байхгүй. Яг тэр чигийн шинжээчдийн дүгнэлт гаргасан уу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Энэ асуудал дээр гишүүд их бага асууж байгаа нь ойлгомжтой Жавхланбаатар даргаа. Энэ бол арга байхгүй. Энэ бол Улсын Их Хурлын даргын зөвлөлөөр өнгөрсөн 5 дахь өдөр яаралтайгаар орж ирээд өнөөдөр ингээд 2 дахь өдөр ярьж байгаа учраас та нар өчигдөр материалаа өгсөн. Бас тэр нөлөөлсөн байх. Тэгээд та нар маань хойшид бас энэ тал дээр бид ч гэсэн бас анхааръя. Даргын зөвлөлөөс өмнө материалуудаа нэхэж байя.

Ингээд энэ би хоёр дахь асуулт нь болохлоор энэ хуудас, та нарын материалууд дээр чинь хуудас нь энэ харагдахгүй байна. Энэ протоколын 4.3-д гэж байгаа юм. 3-ыг цогцоор хэрэгжүүлэх хамтын ажиллагаа нь гээд ингээд зөндөө олон материалууд дээр Монголын талаас илэрхийлэв гэдэг үгнүүд их орсон байна. Энэ асуудлууд дандаа Монголын талаас саналаа илэрхийлэв л гээд байна. Бидэнд ирсэн энэ материалууд дээр нөгөө талаас түншлэгч гэдэг юм уу, хамтран ажиллаж байгаа энэ нөгөө талаас ямар ямар саналууд ирсэн, ямар ямар дээр нь ямар гарц гаргалгаатай байгаа вэ гэдэг дээр ямар ч мэдээлэл ирээгүй байна. Ингэж татаа тунгааддуулбал та нар дараад нь Монголын талаас өгсөн санал дээр хуц гэж хэллээ гэж хариулах магадлал өндөртэй. Энэ дээр надад энэ 2 дугаар дээр тодруулж хариулт хэлж өгөөч. Би 2 асуулт асуулаа.

5 номерын микрофоныг нээж өгье.

Ц.Туваан: Байнгын хорооны дарга бас чухал асуудал ярьж байна. Энэ дээр мэдээж бид нар бас өмнө нь Оюу толгой дээр алдсан алдаа гээд тэрийгээ нэг талдаа тавьж байгаад Ораногийн гэрээ хийдэг шиг бас энэ дээр 60 удаагийн ажлын хэсгийн хуралдаан гээд нэлээн хэрсүүжсэн байна лээ. Тэгээд би

бас сүүлд нь шинэ орж ирээд энэ юмнуудтай нэлээн сайн чадлынхаа хэрээр сууж танилцсан. Тэгээд энэ асуултыг ч гэсэн эргээд ярихад энэ хөндлөнгийн шинжээчид маш чухал. Энэ асуудлыг яаж шийдсэн бэ гээд ингээд тантай адилхан санаа зовниж асуусан. Явцын хувьд бас ингээд хяналтаа тавиад явж байгаа. Энэ дээр “Ананд Адвокатс” гээд өмгөөллийн компани 2030 он хүртэл зөвлөх үйлчилгээ үзүүлээд 30 онд 20 сая тонныг гаргах хүртэл гэрээгээ хийчихсэн. Хөндлөнгийн хяналтаа, зөвлөмжүүдээ өгөөд ажиллаж байгаа гэдгийг хэлье. Төмөр зам дээр ФИДИК гэж бид нар ярьдаг олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо бас зөвлөөд ажиллаад явж байгаа гэдгийг хэлье. Тэгээд үйл ажиллагаа эхлэхээр эхэлсэн цагаас эхлээд бас хяналтаа тавиад ажиллана.

Энэ өгсөн материал ер нь бас нэлээн шахуу бид нарт ирсэн. Тэгэхдээ бид нарын материал бэлэн байсан. Энэ Монголын талаас гэдэг саналууд нь 58, Их Хурлын 58-ын хэрэгжилтийн асуудлыг голчлон танилцах байсан учраас тэр талдаа Монголын талын саналуудаа оруулж хариулт өгсөн гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Баярлалаа. Гишүүд, Золжаргал гишүүн асуулт асууя. Золжаргал гишүүний бас материалууд нэлээн дэлгэрэнгүй байсан учраас асуулт асууя. Золжаргал гишүүний микрофоныг нээж өгье.

Ж.Золжаргал: Та бүхнээс 1 асуулт асуух гэсэн юм. Энэ Улсын Их Хурлын тогтоол дээр сорчлохгүй, бүтээгдэхүүн, нүүрсийг сорчлохгүй байх тухай байгаа. Тэгээд энэ хүрээнд 3-ыг цогцоор гэдэг нөхцөлийн дагуу хүчин чадлыг нэмэгдүүлэх тэр нь болохоор Онч хараат Бортолгой гэсэн шинэ талбай дээр үйлдвэрлэл, олборлолт явуулна гэж. Тэгэхээр тэр талбайгаас гарсан нүүрсний хувь, харьцаанд тулгуурлаж 3 төрлийн нүүрсээ гарсан хувь, харьцаагаар нийлүүлэхээр хэрэгжүүлж байгаа юу? Хэрвээ эндээс гарсан талбай нь 55 хувь гэсэн байх аа түрүүний мэдээлэл тийм ээ коксжих нүүрс хүрэхгүй бол өөр талбайнууд Цанхи, Бортээгээсээ авах юм уу? Тэгэх юм бол олборлолтын шинэ талбайгаас гарч байгаа юм чинь сорчлохгүй гэдэг заалт нь хэрэгжихгүй, сорчлох болоод коксжих нүүрсний дийлэнх нь 1 худалдан авагч руу явчхаад бирж дээр юм үлдэхгүй болчих юм биш биз дээ? Бирж дээр ч юм уу, эсвэл бусад худалдан авагчид тэгээд энэ тал дээр тодорхой хариулт өгнө үү? Баярлалаа.

С.Ганбаатар: 5 номерын микрофонд Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Золжаргал гишүүний асуултад тодорхой хариулъя. Эхний хэсэг нь 27 сая тонн 29 оныг дуустал, эхний 3 жил 5, 5-н сая, дараагийн 2 жил 6, 6-н сая тонн, нийтдээ 27 сая тонныг одоогийн Баруун, Зүүн Цанхийн уурхай уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх байдлаар бид нар өгнө. Энэ дээр бид нар нүүрсний харьцаагаа 55, 35, 10 гэж тохирсон харьцаагаараа өгнө. Тэгэхээр энэ нүүрсний харьцаа бол манай биржийн стандартаар хатуу коксжих 3-ны 1-ийн коксжих эрчим хүчний гээд явж байгаа. Тус тусдаа үнэтэй байгаа.

Дараагийн асуудал нь энэ уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлээд 2030 оны 1 сарын 1-нээс эхлээд 20 сая тонныг жилдээ 11 жилийн хугацаанд өгөх ийм гэрээ байгаа. Тэгэхээр энэ хугацаанд бид нар Ончхараат Бортээг, Бортолгой гэсэн 2 ордынхоо эхлээд урьдчилсан, нарийвчилсан биш урьдчилсан хайгуулын дүнтэй байж байгаа. Ойролцоогоор энэ 2 орд маань 1 тэрбум орчим тонны нөөцтэй гэсэн урьдчилсан тооцоо байгаа. Одоо бид нар энэ дээрээ хайгуулаа хийнэ. Тэгээд хайгуулынхаа дүнд нөөцөө тогтооно яг нарийвчилсан байдлаар, нүүрснийхээ чанарыг үзнэ. Үүний дараагаар бид нар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр

оруулж ТЭЗҮ-гээ батлуулна. Үүний дараагаар бас нэлээн асуудлуудыг ярина. Тэр нь мэдээж тэр доор хөрсөн доор ямар чанартай, ямар хэмжээтэй нүүрс хэдий хэмжээ байгаа гэдгийг бид нар одоогоор 100 хувь мэдэх боломж байхгүй. Тэр 30 оноос хойш хэрэглэх дээр бид нар өөр харьцаа тохирч байгаа. Тэн дээр хатуу болон 1/3-ийн коксжих нийлээд 70 хувь, эрчим хүчний нүүрс 30 хувь гэж тооцож байгаа. Тэгэхээр өмнөх 5 жилийнхээс эрчим хүчний нүүрсний эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлж тооцож байгаа гэж ингэж ойлгож болно.

Мэдээж Засгийн газар хоорондын хэлэлцээр болон Улсын Их Хурлын 58 дотор бид нар 20 сая тонн гэдгээ 30 оноос хойш 20 сая тонн гэдгээ тогтчихсон. Тэгээд нүүрснийхээ харьцааг бүтцийн харьцаагаа 70, 30 гээд тооцоолж үзээд эндээ гарч үр дүнгээрээ, судалгааныхаа үр дүн дээр ТЭЗҮ хийгдсэний дараа дахиж энэ асуудлаа ярина. Тэгэхгүй яг бол газрын доор байгаа нарийвчилсан хайгуул, судалгаа хийгдээгүй байгаа орд дээр шууд тэд гэж хэлэх ийм боломж өнөөдөр байхгүй байгаа.

С.Ганбаатар: Золжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Золжаргал: Би баталгаажуулаад асуучихъя. 30 оноос хойш 20 сая тонн нийлүүлэхэд 70 хувь нь хатуу болон 3-ны 1 коксжих нүүрс байх нь байна, 30 хувь нь эрчим хүч байх нь байна. 70 дотроо хэд нь коксжих, хэд нь сул коксжих нь тодорхойгүй. Ирээдүйд гарч ирэх учраас. Тэр нь уурхайгаас гарч ирэх олборлолтын хувь, харьцаатайгаа нийцтэй байна гэж ойлгож байна. Энийг баталгаажуулж болно.

Хоёрдугаарт нь эрчим хүчний нүүрс гэдэг ямар шалгуураар эрчим хүчний нүүрсэнд оруулж байгаа вэ 30 хувь нь? Тэгээд 3-ыг цогцоор зарчмын хүрээнд хүчин чадал нэмэгдүүлэх Онцхараат, Бортолгойн хүрээнд энэ 20 сая тонны нийлүүлэлт хийгдэнэ. Энэ хүрээнд явагдсан олборлолт л үүнд хамаатай гэж ойлгож болох уу?

С.Ганбаатар: Туваан сайд хариулъя 5 номерын микрофонд.

Ц.Туваан: Тийм, ерөөсөө протокол дээр бас яг ингэж зааж өгсөн. Онцхараат, Бортолгой гээд. Бид нар энэ дээр 1 тэрбум тонны урьдчилсан нөөцтэй. Магадгүй үүнээс цааш нарийвчилсан судалгаагаар нарийн нөөц тогтоогдоно. Тэгээд энэ дотор миний түрүүний хэлсэн яг хэдэн давхаргатай, аль аль давхаргаас нь хатуу коксжих, аль аль давхаргаас нь 3-ны 1, аль давхаргаас нь эрчим хүчний нүүрс гарна гэдгийг бид нар одоо урьдчилан хэлэх боломжгүй байгаа.

Тэгэхээр хайгуулаа бид нар энэ 5 жилийн хугацаанд явуулаад Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөрөө ТЭЗҮ-гээ батлуулаад тэгээд энэ асуудал эцсийн байдлаар тодорхой болно. Яг таны хэлж байгаачлан хатуу болон 3-ны 1 коксжих нийлээд 70 хувь, эрчим хүчний нүүрс нь 30 хувь гэдэг харьцаагаа тохирсон. Тэгэхээр одоо олборлож байгаа одоо худалдаа хийх 5 саяас эрчим хүчний нүүрсний эзлэх хувь, хэмжээг арай нэмэгдүүлж тооцсон гэсэн.../минут дуусав./

С.Ганбаатар: Нэмээд 5 номерын микрофондоо дутуу хариулснаа гүйцээнэ үү.

Ц.Туваан: Тийм. Тэгэхээр нэмэгдүүлж буюу арай зөөлрүүлж эрчим хүчний нүүрсний эзлэх хэмжээг бас нэмэгдүүлсэн гэж ингэж ойлгож болно. Энийгээ бид нар одоогийн гэрээндээ тусгаад явж байгаа гэдгийг хэлье.

Эрчим хүчний нүүрс дээр манай Мөнхжаргал захирал нэмээд хариулчих.

С.Ганбаатар: 6 номерын микрофон нээж өгье.

Х.Мөнхжаргал: Эрчим хүчний нүүрсийг тодорхойлохдоо Монгол Улсын MNS 6457:2022 гэсэн стандартаар тодорхойлж, эрчим хүчний нүүрс нийлүүлэх болно. Үүнд бол 2 төрөл, 12 ангилалтай ийм стандарт байгаа. Тэр стандартыгаа баримтална.

С.Ганбаатар: Ойлголоо хариулт авлаа. Сонгобайгийн Замира гишүүн маш товчхон асуулт асууна. Хүмүүсээ бас алдчих гээд байгаа шүү.

С.Замира: Ганц асуулт асууя. Энэ хэлэлцээр 2 гэдэг юу байна тээ? Тэр дээр яг 16 жилийн хугацаатай ингээд гэрээ хийгдсэн гэвч нүүрсний үнэ нь тавигдаагүй байна. Эсвэл зах зээлийг нь үнээр гэх юм уу тийм юм оруулах ёстой юм биш үү? Энийг л тодруулах гэсэн юм. Баярлалаа.

С.Ганбаатар: 5 номерын микрофонд Туваан сайд хариулах уу?

Ц.Туваан: Тийм 16 жилээ бид нар тохирсон. Их Хурлаар хэлэлцээр байгуулах үндсэн чиглэлдээ ч тохирсон. Эхний 5 жилдээ бид нар 27 сая, дараагийн 11 жилд 220 сая тонн нүүрсийг борлуулахаар энэ бол худалдах асуудал яригдаж байгаа ямар нэгэн солилцоо байхгүй.

Үнэ дээр бид нар бас тохирсон үнийн хэлэлцээр дээр үнийн тэр хөдөлдөг индексжүүлсэн үнээр авахаар тохирсон байгаа. Тэгэхээр одоо бол би бас нэг зүйлд баярлаж байгаа. Юу гэхлээр Их Хурал бас дэмжээд энэ Гашуунсухайт-Ганцмодны хил холболтын асуудлыг баталж өгсөн нь нүүрсний экспорт нэлээн хүндрэлтэй болчихсон байгаа энэ цаг үед гэхэд л 5 сая буюу ойролцоогоор 300-400 сая долларын экспорт хийх энэ боломжийг бид нар бас өмнө нь бий болгоод батлаад авчихсан энэ гэрээнийхээ хүрээнд борлуулах боломж нээгдэж байгаа.

С.Ганбаатар: Үнийн хувьд хөдөлгөөнтэй байгаа гэж байна шүү. Ингээд гишүүд асуулт асуулаа. Өө тодруулах юм уу? Замира гишүүн тодруулж асууя гэж байна.

С.Замира: Нэмэлт төслүүдийг хэн төлөх гэж байгаа юм?

С.Ганбаатар: Нэмэлтийг хэн төлөх гэж байгаа вэ?

С.Замира: Мөнгийг хэн хариуцах юм, нэмэлт төслүүдийн мөнгийг хэн хариуцах юм?

С.Ганбаатар: 5 номерын микрофонд хариулт.

Ц.Туваан: Төмөр замын бүтээн байгуулалт дээр 978 тэрбум гэж анхны урьдчилсан тооцоолол байсан. Энэ нь ойролцоогоор 270-аад сая доллар байсныг

хэлэлцээрийн шатанд Зам, тээврийн яаман дээр хэлэлцэж байгаад 50-иад сая доллароор бууруулсан байгаа.

Нүүрс худалдах, худалдан авах гэрээн дээр ямар нэгэн нэмэлт асуудал байхгүй. Энэ “Чайна Энержи” компани үнээ тохирсон тохиолдолд мөнгөө төлөөд манайхаас нүүрсээ авна.

Гурав дахийн хүрээнд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх дээр бид нар ТЭЗҮ гаргаад, “Эрдэнэс Тавантолгой” компани мөнгөө төлөхөөр байгаа. Яагаад гэхлээр бид нар дараагаар нь энэ уурхайг нээгээд борлуулж орлого олох нь манай тал учраас Эрдэнэс Тавантолгой санхүүжилтийг гаргана.

С.Ганбаатар: Ингээд мэдээлэл авлаа. Үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна. Золжаргал гишүүнээр тасаллаа. Золжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Золжаргал: Нэг хил дамнасан төмөр замыг байгуулах хэлэлцээрийн хүрээнд нүүрс урт хугацаанд нийлүүлэх гэрээ, тэгээд олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэх гээд ийм 3 ажил нэг дор хийгдсэн. Энэ дээр анхаарах зүйлсийг Улсын Их Хурлаас тогтоол болгож өгсөн. Миний хувьд бол тэр нүүрсийг сорчлохгүй байх, энэ урт хугацаандаа уурхайн болоод үйл ажиллагаа тогтвортой явах болоод Монгол Улсын эдийн засагт онцгой ач холбогдолтой гэж үзсэн учраас санал оруулсан.

Ингээд энэ дээр нэг анхаарууштай зүйл нь 12 энэ Улсын Их Хурлын тогтоол дээр зүйл дотор нь баахан дайвар ачаанууд дайсан, тэр дотор стадион, цэнгэлдэх хүрээлэн барих гэсэн санаа хүртэл явж байдаг. Тэгээд энэ ажил бол 2 тал бизнес хийгээд ашигтай, ашиггүй гэдэг үйл ажиллагаа явуулахын зэрэгцээгээр нөгөө талдаа баахан дайврууд байгаа. Тэгэхээр тэд нар тэр дайврууд чинь хэн нь мөнгийг нь гаргаж яаж төлөх нь эцсийн дүндээ эргээд л “Эрдэнэс Тавантолгой” компани Тавантолгой уурхай дээрээ ирж болзошгүй, ирэх л байх. Угаасаа өөр мөнгийг нь төлөх газар байхгүй. Тэгээд энэ тэр дайврууд бол буцаад манай үйл ажиллагаанд, уурхайн, Монгол Улсын үйл ажиллагаанд хүндрэл учруулна. Энэнтэй холбоотой тэр бүтээн байгуулалтыг бартердана энэ тэр гэдэг Биржийн тухай хуульд оруулж ирэх гэж байсан өөрчлөлтүүд бас холбоотой гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ зүйл дээр цаашдаа дараа дараагийнхаа шийдвэрт анхаарч хандахгүй бол ямар ч байсан энэ шийдвэрийг, тогтоолыг дэмжүүлчихье гээд баахан хүмүүсийн дайвар авчихсан. Тэр чинь буцаад бидний Монгол Улсын эдийн засагт бас тийм томоохон сөрөг нөлөөтэй болж болзошгүй шүү гэдгийг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

С.Ганбаатар: Ингээд гишүүд асуулт асууж, үг хэллээ. 2 зүйл протоколд бүр тусгаж хэлье Туваан сайд аа. Одоо энэ гэрээгээр одоо ажиллаж байгаа хувь болон хувьсгалын олон нүүрстэй холбоотой аж ахуйн нэгжүүдэд сөргөөр нөлөөлөхгүй гэдгээ наад гэрээн дээрээ баталгаажуулж тэр дүгнэлтүүдээ гарсан байх ёстой шүү.

Хоёрдугаарт энэ хөндлөнгийн бие даасан хуулийн болон шинжээ мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтүүдийг бичгээр над руу 2 өдрийн дотор ирүүлэх ёстой. Ийм 2 санал хэлье. Мэдээлэл авч дууслаа. Дараагийн хэлэлцэх асуудалдаа орьё. Дөрөв дэх хэлэлцэх асуудал маш шуурхай байгаа.

Энэ дөрөв дэх хэлэлцэх асуудал бол “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооноос тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн биелэлтийг хангуулах болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нутгийн захиргааны байгууллагатай хэрхэн харьцаж байгаа асуудлаар, талаар шалган судлах холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2025 оны 7 дугаар тогтоолоор байгуулсан.

Өнөөдрийн хуралдаанаар дээрх ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Ингээд “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай”,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын Гж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 7 дугаар тогтоолоор байгуулагдсан Ашигт малтмалын тухай хууль шинэчилсэн найруулгын 42 дугаар зүйлийн биелэлтийг хангуулах болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нутгийн захиргааны байгууллагатай хэрхэн харьцаж байгаа асуудлын талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтааж, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхийг ажлын хэсэг Сонгобайгийн Замираг үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Аж Үйлдвэрчний бодлогын байнгын хорооны дарга Санхүүгийн Ганбаатарт даалгасугай.

Аж үйлдвэрчний бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм Байнгын хорооны тогтоол байна.

Тогтоолтой холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу?

Алга байна.

Энэ “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Минийх гацчихлаа. Минийхийг протоколд дэмжсэнээр бичээрэй. Доржзодовын Энхтуяа гишүүн дэмжсэн байгаа. Ингээд 16 гишүүнээр 70 хувийн саналаар энэхүү саналыг дэмжлээ.

Ингээд “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүддээ талархал илэрхийлье.

16.22 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР